



# БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖИЛ

(Бага насны хүүхдийн хөгжил, хоол тэжээл, эрүүл мэнд, боловсрол, хамгааллын мэргэжилтнүүдэд зориулав)

# БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖИЛ

(Бага насны хүүхдийн хөгжил, хоол тэжээл, эрүүл мэнд,  
боловсрол, хамгааллын мэргэжилтнүүдэд зориулав)



Боловсруулсан: Б.Болдсүрэн (М.А.), МУИС, Шинжлэх ухааны сургууль, Боловсрол сэтгэл судлалын тэнхимийн багш

Н.Болормаа (М.А.), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн хоол судлалын албаны эрдэм шинжилгээний ажилтан

Л.Мөнхжаргал (М.Д.), НҮБ-ын Хүүхдийн Сангийн хоол тэжээлийн мэргэжилтэн

Б.Төртогтох (Ph.D.), МУБИС, СӨБС-ийн арга зүйн тэнхимийн багш

Т.Цэндсүрэн (Ph.D.), НҮБ-ын Хүүхдийн Сангийн Бага насны хүүхдийн хөгжлийн зөвлөх

## УДИРТГАЛ

Хүний хөгжлийн хамгийн эрчимтэй, чухал үе болох бага насны хөгжил, боловсролыг дэмжих нь насан туршийн ухаалаг хөрөнгө оруулалт болохыг орчин үеийн олон судалгаа нотолж байна. Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж асаргаа, хамгаалал, хөгжил боловсролыг нэгдмэл хандлага, арга зүйгээр дэмжиж ажиллах нь дэлхий нийтийн төдийгүй, Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудын нэг болж байна. Тухайлбал, Тогтвортой хөгжлийн зорилтууд болон Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал 2030-д зургаа хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж асаргаа, хамгаалал, хөгжил боловсролын зорилтуудыг илрүүлэх үзүүлэлтийн хамт нарийвчлан тусгасан байна.

Монгол Улсын Засгийн Газар болон НҮБ-ын Хүүхдийн Сангаас хамтран 2017-2021 онд хэрэгжүүлж буй Улс орны хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгууд, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт зохион байгуулсан “Бага насны хүүхдийн цогц хөгжил” сургалт-семинарын сургалтын агуулга, үйл явцад суурилан энэхүү товхимлыг боловсрууллаа.

“Бага насны хүүхдийн цогц хөгжил” сэдэвт сургалт-семинарын зорилго нь орон нутгийн түвшинд бага насны хүүхдийн хөгжлийн талаарх төрийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх нэгдмэл стратеги, төлөвлөлтийг хийх, бага насны хүүхдэд чиглэсэн нийгмийн цогц үйлчилгээнд хүүхэд нэг бүрийн хамруулах сайн туршлагыг хуримтлуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршиж байсан. Сургалт-семинарын явцад оролцогчдод үргийн хөгжлийн үеэс 6 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа халамж, хамгаалал, хөгжил боловсролын талаарх орчин үеийн онол, чиг хандлага, арга зүйг танилцуулсан.

“Бага насны хүүхдийн цогц хөгжил” товхимлыг бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил боловсрол, хамгаалал, халамж асаргааны чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд, эцэг эх, оюутан суралцагчид болон орон нутгийн дунд шатны удирдлагын баг, хамт олон ашиглах боломжтой.

Энэхүү гарын авлагын эрүүл мэнд, агаарын бохирдол сэдвийн агуулгад хувь нэмрээ оруулсан С.Гантуяа (НЭМҮТ), М.Оюунболор (НҮБ-ын Хүүхдийн Сан) нарт талархал илэрхийлье.

## АГУУЛГА

УДИРТГАЛ .....	3
АГУУЛГА .....	4
Товчилсон үгийн тайлбар .....	6
Хүснэгтийн жагсаалт .....	7
Зураглалын жагсаалт .....	7
<b>СЭДЭВ 1: БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖИЛ</b> .....	<b>8</b>
Цогц хөгжил .....	9
Бага насны хүүхдийн хөгжлийн хөрөнгө оруулалт .....	12
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих стратеги, хамтын ажиллагаа ....	14
<b>СЭДЭВ 2: БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХООЛ ТЭЖЭЭЛ</b> .....	<b>16</b>
Эхийн сүүгээр хооллолтын ач холбогдол .....	18
Хүүхдийн хоол тэжээл ба тархины хөгжил .....	27
<b>СЭДЭВ 3: БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД</b> .....	<b>28</b>
Нялх, бага насны хүүхдийн эрүүл мэндэд учирч болох эрсдэл .....	28
Хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс сэргийлэх .....	35
<b>СЭДЭВ 4: БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА, ХАЛАМЖ</b> .....	<b>43</b>
Бага насны хүүхдийн асаргаа, халамжийг дэмжих арга зүй .....	44
Асаргаа халамжийн дэмжлэг ба үйлчилгээ .....	45
<b>СЭДЭВ 5: БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХАМГААЛАЛ</b> .....	<b>47</b>
НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц .....	47
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл .....	50
Хүүхдийн хүчирхийллийг таслан зогсоох долоон стратеги (INSPIRE) .....	53
<b>СЭДЭВ 6: БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРОЛ</b> .....	<b>56</b>
Бага насны хүүхдийн хөгжилд бүх нийтийн оролцоо .....	56
Бага насны хөгжлийн онцлох үзүүлэлтүүд .....	57

Бага насны хүүхдийн тархины хөгжил .....	61
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих онол, арга зүйн зарим асуудал .....	64
Хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын идэвхтэй аргууд .....	70

### **СЭДЭВ 7: БНХ-ИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЦОГЦ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ .....**

Цогц хөгжил баг .....	73
Стратеги төлөвлөгөө .....	75
Стратегийн удирдлага .....	75
Орчны шинжилгээ .....	76
Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл.....	78
SWOT шинжилгээ .....	80
Үйл ажиллагааны стратеги.....	83
Зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө.....	84
Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ба үнэлэх.....	86

**ХАВСРАЛТ 1.** 1999-2017 оны эхийн сүүгээр хооллолтын чиг хандлага ... 90

**ХАВСРАЛТ 2.** Насандаа тохирсон давтамжаар хооллож байгаа 5 хүртэл насны хүүхэд..... 90

**ХАВСРАЛТ 3.** Стратеги төлөвлөгөөний загвар (ABCDE загвар)..... 91

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
БНХ	Бага насны хүүхэд
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮББСШУБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Байгууллага
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НБНХХ	Нялх, бага насны хүүхдийн хооллолт
НБХ	Нийслэлийн боловсролын хэлтэс
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НЭМҮТ	Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төв
ОНБТ	Олон найрлагат бичил тэжээл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХТҮС	Хүүхдийн төрөлтийн үндэсний статистик
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭХЭМД	Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Ангир уургийн шинж чанар, ач холбогдол.....	20
Хүснэгт 2.	Эхийн сүүгээр хооллолтын байдал .....	23
Хүснэгт 3.	Монгол Улсын бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын дадал .	26
Хүснэгт 4.	Дархлаажуулалтын үндэсний товллол.....	36
Хүснэгт 5.	Хүчирхийллийн төрлүүдэд өртөх эрсдэл насны бүлгээр .....	52
Хүснэгт 6.	SWOT шинжилгээний матриц .....	80
Хүснэгт 7.	Боломжийн шинжилгээ .....	81
Хүснэгт 8.	Аюул заналын шинжилгээ .....	82
Хүснэгт 9.	TOWS шинжилгээний матриц .....	82

## ЗУРАГЛАЛЫН ЖАГСААЛТ

Зураглал 1.	Хүний хөгжлийн хөрөнгө оруулалтын эргэх ашиг .....	13
Зураглал 2.	Эрт амлуулалт (хүүхдийн хүйс, байршил, төрөх үеийн жингээр)....	23
Зураглал 3.	Бага насны хүүхдийн хооллолтын байдал, 2010-2017 онд .....	25
Зураглал 4.	Бага насны хүүхдийн эхийн сүүгээр авах илчлэг ба хангагдаагүй хэрэгцээ .....	26
Зураглал 5.	Хүүхдийн мэдрэлийн эсийн хөгжил .....	27
Зураглал 6.	Насанд хүрэгч, хүүхдийн харилцаа .....	44
Зураглал 7.	Мэдрэлийн эсийн холбогдож буй болон тасарч буй байдал.....	57
Зураглал 8.	Хүүхдийн тархины мэдрэлийн эсийн хөгжил .....	61
Зураглал 9.	Стратегийн удирдлагын бүтэц .....	76





## СЭДЭВ 1

### БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖИЛ

2008 онд НҮБ-ын Хүүхдийн Сан, Хүүхдийн хөгжлийн судалгааны нийгэмлэг (*Society for Research in Child Development*)-тэй харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурснаар судалгаанд суурилсан бодлого ба бодлогын нөлөөллийн ажил өмнөхөөс илүү эрчимтэй хэрэгжих болсон.

2015 онд НҮБ-ын Хүүхдийн Сан дэлхийн тархи судлалын тэргүүлэх эрдэмтэдтэй зөвлөлдөн өнөө үеийн биологийн болон нийгмийн шинжлэх ухааны баримт, нотолгоог дэлгэн харуулж бага насны хөгжил нь насан туршийн суралцахуй, зан үйл, эрүүл мэндийн суурь, боломж болох тул улс орны засгийн газрууд бага насны хөгжлийн бодлого, үйл ажиллагаанд онцгойлон анхаарч ажиллахыг дэлхийн улс орнуудад зөвлөсөн.

2016 онд Тогтвортой хөгжлийн зорилтод бага насны хөгжил боловсролын асуудал бие даасан зорилт (Зорилт 4.2) болж орсон. Энэхүү дэлхийн хэмжээний бичиг баримт болох тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад улс орнуудын засгийн газрууд бага насны хүүхдийн хөгжилд хэрхэн анхаарч ажиллах ёстой талаар тухайн үеийн НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга

**БАРИМТ:** Тогтвортой хөгжлийн зорилт 4.2. 2030 он гэхэд бүх охид, хөвгүүд бага насны хүүхдийн хөгжил, асаргааны чанартай үйлчилгээ, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, улмаар бага боловсрол эзэмшихэд бэлтгэгдсэн байна.

*Илрүүлэх үзүүлэлт:*

- Эрүүл мэнд, зан байдал, сурах чадварын хөгжил хэвийн 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь (ялгаатай байдал: хүйс, газар зүйн байршил, орлогын байдал гэх мэт)
- Зохион байгуулалттай сургалтын хамралт (сургуулийн элсэхийн өмнөх жил) улс орнууд насыг тодруулан авч үзнэ.

Бан Ги Мүн “Ирэх 15 жилд бидний хийхийг хүсэж буй өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь чухал болохыг Тогтвортой хөгжлийн зорилтууд тодотгож байна” хэмээн цохон тэмдэглэсэн.

2019 онд НҮБ-ын Хүүхдийн Сан “Дэлхий суралцахад бэлэн: Бага насны боловсролын чанарыг чухалчлах нь” дэлхийн тайлан гаргаж, энэхүү тайланд бага насны хөгжлийг дэмжих

системтэй үйл ажиллагаа сургуулийн өмнөх боловсролын хүртээмж чухал болохыг дурдаад цаашид, ирэх жилүүдэд улс орны засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, эцэг эхчүүд хамтран боловсролын үйлчилгээний чанарт ихээхэн анхаарч ажиллах ёстойг зөвлөсөн.

НҮБ-ын Хүүхдийн Сан нь хүний хөгжлийн онол арга зүйг үндэслэн бага насны хүүхдийн хөгжлийг олон талаас нь, цогц байдлаар харж, хөгжлийг дэмжихэд засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, олон нийт эцэг эхтэй хамтран ажиллахыг чухалчилдаг.

## ЦОГЦ ХӨГЖИЛ

Сэтгэл судлаачид болон орчин үеийн тархи судлаачдын онол, үзэл баримтлал нь “бага насны хүүхдийн цогц хөгжил”-ийг тайлбарлах онол, арга зүйн үндэс болж байна.

Сэтгэл судлаачид хүний бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн өөрчлөлт, онцлогийг судлахын тулд насны үечлэлийг тодорхойлсон байдаг. Үүнийг хүний хөгжлийн үе шат хэмээн тодруулж тодорхой насыг хамааруулан авч үздэг. Тухайлбал, Германы сэтгэл зүйч (психоаналист) Эрик Эриксон (1902-1994) 6 хүртэлх насыг бага нас хэмээн авч үзээд түүнийгээ нялх нас 0-1 нас; балчир нас 1-3 хүртэлх нас; сургуулийн өмнөх нас 3-6 хүртэлх нас хуваасан байдаг. Мөн Баруун Английн их сургуулийн профессор Дохерти Ж. болон Хагхёс М. (2009) нар “Хүүхдийн хөгжил” номондоо бага нас гэдэгт 0-12 насыг

**БАРИМТ:** НҮБ-ын Хүүхдийн Сан 191 орны Засгийн газар, Иргэний нийгмийн байгууллагуудтай бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил боловсрол, хамгаалын чиглэлээр судалгаа-баримт нотолгоог суурилан үр дүнд чиглэсэн байдлаар хамтран ажиллаж байна.

Бага насны хүүхдийн цогц хөгжил гэдгийг бие бялдар, оюун ухаан, сэтгэлийн цогц бүрдэл буюу эрүүл мэнд-хоол тэжээл, хөгжил боловсрол-хамгааллын асуудлыг харилцан уялдаа холбоонд ойлгож, дэмжих явдал юм.

хамруулсан байна. Гэхдээ олонх судлаачид, бодлого боловсруулагчид бага нас гэх насны бүлэгт ихэнхдээ ургийн хөгжлийн үеэс 6 - 8 насыг хамааруулж авч үзэж байна. Түүнчлэн хүүхэд бага насандаа буюу ургийн хөгжлийн үеэс 6 хүртэлх насандаа амьдралын турш дахин давтагдашгүйгээр хүрээлэн буй орчноо таньж, дасан зохицож, шинэ зүйлийг сурч, мэдэхийн хэрээр эрхтэн тогтолцоо нь боловсронгуй болж хөгждөг хэмээн тодруулж байна. Бага насны хүүхэд өөртөө үйлчлэх, бусадтай харилцах, асуудлыг шийдэх туршлага хуримтлуулж улмаар олон талаар өөрийгөө таньж, нээдэг. Хүүхдийн бага насны туршлага, хөгжлийн шинж байдал нь түүний ирээдүйн амжилттай суралцах, чанартай амьдрах эх үндэс болдог.

Хүний амьдралын эхний 1000 хоног гэдэг нь ураг эхийн хэвлийд бүрэлдэн бий болж, нүдэнд харагдахгүй зөвхөн 1 эс байх мөчөөс эхлэн хүүхэд 2 нас хүртэлх хугацаа юм. Үүнд жирэмсэн үеийн 270 хоног, 1 нас хүртэлх 365 хоног, 2 нас хүртэлх 365 хоног багтдаг.

Монгол ардын сурган хүмүүжүүлэх ухаанд, хий наснаас 6 нас хүртэлх хугацааг бага нас гээд унаган ухаан бий болох нас 0-3, унаган ухаан суух нас 4-6 гэж нэрлээд хүүхэд 0-6 насандаа амьдралын ямар ухаан, чадвар, дадал, зуршилд суралцах ёстойг тодруулан заасан нь бий (Намжил, 2009).

Тархи судлаачид хүний амьдралын эхний 1000 хоног нь түүний хөгжлийн хамгийн чухал үе гэдгийг нотолж байна. Тухайлбал, хүүхдийн амьдралын эхний 1000 хоногийн туршлага нь түүний ирээдүйн амьдралын байр суурь, нийгэм-сэтгэл зүйн хөгжил болон амжилттай суралцах, хөдөлмөрлөх үйл явцад онцгой нөлөөг үзүүлдэг (Баркер, 1995) байна.

Түүнчлэн хүний амьдралын эхний 1000 хоног нь хүүхдэд төдийгүй түүнийг төрүүлсэн ээж, аавд мөн адил чухал. Ээж, аав шинэ хүнтэй болсон нь нэг талаас өндөр хариуцлага боловч нөгөө талаас хүүхдээ хэрхэн зохистой асрах, хооллох, хамгаалах вэ, яаж сайн хүн болгон өсгөн хөгжүүлж, хүмүүжүүлэх вэ гэх зэргээр олон зүйлд санаа зовниж байдаг. Энэхүү зовнилыг даван туулж, хүүхдээ эрүүл энх, сайн сайхан өсгөж хөгжүүлэхэд энэхүү 1000 хоногийн туршлага нэн чухал үүргийг гүйцэтгэдэг байна.

Хүүхэд эхээс мэндлэхдээ 100 сая орчим тархины эстэй төрдөг ба эдгээрийн ихэнх нь амьдралын эхний 5 сард хэлбэрждэг байна. Өөрөөр хэлбэл эдгээр эсүүд нь тархины үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог гэсэн үг юм. Хүүхдийн тархины хөгжил болон тархины эсийн идэвхтэй байдалд эх эцгийн хайраар дүүрэн харилцаа нэн чухал. Тархины хөгжил тархины эсийн холбоосонд суурилдаг бол мэдрэхүйн эрхтнүүдийн үйл ажиллагааг тархи удирддаг. Хүүхэд 3 нас хүрэхэд бүхий л мэдрэхүйгээрээ дамжуулан хүмүүстэй, гадаад

ертөнцтэй харилцан, таньж мэдсэн бүхэн нь өөрийнх нь бусдаас үл хамаарах насан туршийн туршлага болон үлддэг байна (Големэн-Рак, 1987 болон Кац, Щульц нар1997). Энэ нь хүүхдийг бага наснаас нь зохион байгуулалттай сургалтад хамруулахаас илүүтэй өдөр бүрийн ээж аавын хүүхэдтэйгээ харилцсаны үр дүнд бий болсон туршлагын чанар нь хүүхдийн тархины болон бусад талын хөгжилд нөлөөлдөг болохыг тодруулж байгаа юм.

Бага насны хүүхэд цаг ямагт эргэн тойрноо сонирхон ажиглаж, таньж мэдэхийн зэрэгцээ хэн нэгэнтэй хамт байж, харилцах дуртай байдаг. Тэд гэр бүлийнхэнтэйгээ тоглох, үлгэр сонсох, ном унших, дуулах, бүжиглэх улмаар гэр бүлийн зан заншил, соёл уламжлалаас суралцахад бэлэн, бас дуртай. Хүүхэд ганганан гунганаж, эхний авиагаа хэлэх үеэс тэдэнтэй ярилцаж, хамтдаа хөгжмийн хэмнэлээр хөдөлгөөн хийж, дуулж бүжиглэх эхний алхмыг хийх нь тэдний цаашдын хөгжлийн сэдэл болно.

Монголын ард түмний харилцааны үнэт зүйлсийн нэг нь “Миний хүүхэд надаас илүү сайхан амьдрах ёстой” хэмээх философи төдийгүй өрх гэр бүл, ээж аав бүр үр хүүхдийнхээ төлөө бүхнийг зориулах нандин уламжлалтай. Орчин үеийн нийгэм, гэр бүлийн амьдралын хэв шинж энэхүү нандин уламжлалыг сааруулах хандлагатай байна. Ээж, аав нар ажилтай, завгүй гэдэгт өөрийгөө итгүүлж улмаар үр хүүхдэдээ цаг гаргаж хамтдаа байх нь багасч, хүүхдээ үл хайхрах, хараа хяналтгүй орхих, эсвэл ажил, хэн нэгнээс шалтгаалсан уур бүхимдлаа хүүхдэдээ гаргах, тэднийг хараан загнах, зодох зэргээр зүй бусаар харилцах нь буурахгүй байна. Нөгөө талаас өрхийн орлогын түвшин доогуур, ядуу зүдүү амьдралтай байх нь гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг зохистой хэлбэрээр дэмжиж чадахгүй байх бас нэгэн шалтгаан болж байна. Бага насны хүүхдийг асаргаа хайр энэрлээр дутаах, өлсөөх, айдас түгшүүртэй байлгах, стресст оруулах, хүчирхийлэх зэрэг нь тэдний тархины хэвийн хөгжлийг нэн хүчтэй сааруулдаг.

Бага насны бүх хүүхдийн хувьд, ялангуяа хүнд, хэцүү нөхцөлд амьдарч буй хүүхдийн тухайд асаргаа, халамж анхаарал, хоол тэжээл, эрүүл мэнд болон хөгжүүлэх үйл ажиллагаа хамгийн чухал байдаг. Учир нь 3 настай хүүхдийн тархи насанд хүрсэн хүний тархинаас хоёр дахин илүү идэвхтэй, хурдтай, уян хатан байдаг. Гэтэл тархины хурд буюу уян хатан байдал нь 7 насны орчимд 50 хувиар буурдаг гэдгийг тархи судлалын эрдэмтэд нотолж байна (Нилсон, 2000).

Хүүхдийн тархины хөгжлийн хэрэгцээ хангагдахгүй байх, ялангуяа тэдний амьдралын эхний жилүүдэд буюу эрчимтэй хөгжлийн үед энэ байдал тохиолдвол хожим засаж залруулахад ихээхэн хүчин чармайлт, хөрөнгө төсөв шаардагдах төдийгүй хүссэн үр дүнд хүрэх найдлага ч эрс багасдаг.

Бага насны гачигдлаас улбаатай хоцрогдлын хожим илрэх хүндрэл, бэрхшээлийн цар хэмжээ нь хэдий чинээ эрт засаж залруулж арга хэмжээ авч чадсанаас шууд хамаардаг.

Блэкимур (2009) болон Гихард (2004) нар 6-18 сартай хүүхдийн нийгэмсэтгэл зүйн хөгжлийг судалж, энэ үед хүүхдийн нийгэмшихүйн чадамж ихэд мэдрэг, сэтгэлийн хөдөлгөөнөөс эхлэлтэй эсийн холбоос нь нэн бат бөх байдгийг тодруулжээ. Энэхүү эсийн холбоос нь хүүхэд бусадтай харилцахад үүсч, байнгын идэвхтэй харилцааны явцад урт удаан хугацаанд бат бэх болдог ажээ. Уг судалгаа нь эрт үеийн чанартай харилцаа нь балчир, бага насны хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийг дэмждэг болохыг нотолж байгаа юм.

Хүүхдэд хандсан насанд хүрэгчдийн идэвхтэй харилцаа нь тэдэнд амар амгалан, ая тухтай орчныг бий болгож улмаар хүүхэд бие даан хөгжих боломжийг өргөжүүлдэг байна.

Хүүхдийн амьдралын эхний 3-4 жилд тархины жин амьдралын туршид дахин давтагдахгүйгээр нэмэгдэж, тухайн хүнд байх ёстой тархины нийт жингийн 80 хүртэлх хувь нь энэ насанд бүрэлдэн бий болдог (Майн Конгбайер, 2014). Энэ насандаа хүүхэд аз жаргалгүй, осол аюулаас хамгаалалтгүй байгаагаа мэдэрч, тайван бус байх нь гуниг гомдлыг төрүүлж улмаар стресст хүргэдэг. Хүүхэд стресстэй байх нь бусадтай харилцах дургүй, шинийг мэдэх хүсэлгүй, суралцах дургүй, сурах сэдэл тэмүүлэлгүй байхад нөлөөлнө.

Бага насны хүүхдийн асаргаа, хамгаалал, хөгжил, боловсролыг дэмжих нийгмийн суурь үйлчилгээг хөгжүүлэх нь улс орны засгийн газруудын тэргүүлэх зорилтуудын нэг байх нь ёстой.

*НҮБ-ын Хүүхдийн Сангийн  
Ази-Номхон далайн бүсийн  
улс орнуудад хийсэн бодлогын  
судалгаа, 2010*

Стрессийн үед тархинд ялгарах кортизол хэмээх бодис нь тархины хөгжлийг удаашруулах төдийгүй тархины эсийг гэмтээх аюултай байдаг. Големэн (1987) бага насны туршлага тархины эрчимтэй хөгжлийн гол хөдөлгөгч хүч болох тул энэ үед эцэг эх, асран хамгаалагч, багш нарын зохистой дэмжлэг, хариуцлагатай байдал шийдвэрлэх үүрэгтэй гэжээ.


## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Бага насны хөгжил нь насан туршийн амжилттай суралцах, чанартай амьдрахын эх үндэс төдийгүй бага насны хөгжлийн хөрөнгө оруулалт нь насан туршийн, хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт юм.

Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг бий олгохоос гадна хамгийн өндөр эргэх ашигтай хөрөнгө оруулалт юм. Бага насны хүүхдийн хөгжлийн хөрөнгө оруулалт нь магадгүй өнөөгийн улс орны эдийн засагт хамгийн үр дүнтэй хэмээн санхүүжүүлж, дэмжин хөгжүүлж буй салбар, үйлдвэрлэлээс ч илүү үр ашигтай байж болох юм.

Нобелийн шагналт, эдийн засагч Жеймс Хейкман (2009) бага насны хүүхдийн хөгжил, боловсролын хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулахын үр ашгийг тооцоолж, энэ салбарт хөрөнгө оруулах нь улс орны эдийн засгийн хөгжилд нэн чухал гэж үздэг ихэнх төсөл тухайлбал, дэд бүтцийг хөгжүүлэх, зам гүүр барьж, байгуулах зэргээс давсан өндөр ашигтай төдийгүй бага насны хүүхдийн боловсролын үйлчилгээний салбар нь эдийн засгийн хөгжлийн стратегийн нэг чухал хэсэг хэмээн дүгнэжээ. Тэрээр 6 хүртэлх насны хүүхдийн хөгжилд оруулсан 1 доллар тутмын эргэх ашиг нь 12.90 доллар байна (Зураглал 1.) гэдгийг тооцоолж хувь хүний хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт нь зөвхөн боловсрол олж авч буй тэр хэсэг хүмүүст бус улс орны эдийн засгийн хөгжилд бүхэлд нь өндөр үр ашигтай байдаг хэмээн бага насны хөгжлийн хөрөнгө оруулалтын ач холбогдлыг тодруулсан.

**ЗУРАГЛАЛ 1. Хүний хөгжлийн хөрөнгө оруулалтын эргэх ашиг**



Эх сурвалж: Жеймс Хейкман, 2009

Бага насны хүүхдийн хөгжилд хөрөнгө оруулах нь нийгэмд эдийн засгийн хөгжлийг дэмжихээс гадна богино хугацаанд ажлын байрыг нэмэгдүүлж, бараа, үйлчилгээний худалдан авалтын эргэлт өсч, илүү бүтээмж өндөртэй ажиллах хүчинтэй болоход хувь нэмэр болдог. Урт хугацаанд бага насны

хүүхдийн чанартай боловсрол нь ирээдүйтэй, боловсролтой ажиллах хүчнийг бий болгоно. Бага насандаа чанартай боловсролд хамрагдаж буй хүүхэд нь сургуульд амжилттай бэлтгэгдэж, илүү сайн суралцдаг. Тэд сургуулиа төгсөөд, хөдөлмөр эрхлэх магадлал нь нэмэгддэг. Мөн нийгмийн халамжид хамрагдах эрсдэл нь буурч, татвар төлөгчдийн мөнгөөр ажиллаж буй шүүх цагдаатай холбогдох, шоронд суух, гэмт хэрэг үйлдэх магадлал эрс буурдаг.

Хэрвээ шийдвэр гаргагчид бага насны хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл, хөгжил боловсрол, хамгааллыг дэмжих, хөрөнгө оруулахын ач холбогдлыг уул уурхай, зам, барилга, үл хөдлөх хөрөнгө зэрэг улс орны эдийн засгийн тэргүүлэх салбаруудтай адилтган ойлгож эхэлбэл бүх нийтээр бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар нэгдсэн ойлголттой болоход тустай. Түүнчлэн бага насны хөгжлийн хөрөнгө оруулалт нь улс орны эдийн засагт оруулж буй хөгжлийн ухаалаг хөрөнгө оруулалт төдийгүй хүнд хэцүү нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийг цэцэрлэг, бага насны хөгжлийн хөтөлбөрт хамруулах нь ирээдүйн ялгаатай байдлыг бууруулах, үе дамжсан ядуурлын гинжин холбоог таслах үр дүнтэй арга хэмжээ байж болно.

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дэлхийн олон улс орнуудад бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлээр “сайн” бодлого, хөтөлбөр боловсруулж баталсан байдаг хэдий ч хэрэгжилт нь орон нутгийн түвшинд хангалттай бус байдаг (*Jacqueline Hayden and Sithu Wai, 2013*).

Сүүлийн 10 гаруй жилд Засгийн газрууд нэмж бодлого, хөтөлбөр боловсруулж батлахаас илүүтэй одоо байгаа бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизм, арга зүйг тодорхой болгохыг илүүд үзэх болж байна. Ялангуяа орон нутгийн түвшинд, нэгж байгууллага дээр бага насны хүүхдийн хөгжлийг олон талаас нь дэмжих туршлага хуримтлуулах нь нэн тулгамдаж байна.

Аймаг, дүүрэг (сум, хороо)-ийн түвшинд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд “Олон нийтийн оролцоонд суурилсан бага насны цогц хөгжлийн хөтөлбөр”-үүдийг хэрэгжүүлж болно. Ингэхийн тулд хүүхдийн хөгжлийн хэрэгцээг сайтар ойлгож, хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талууд нэгдмэл ойлголттой болохоос ажлаа эхэлнэ. Мөн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих улс үндэстний болон орон нутгийн уламжлалт үзэл хандлага, арга зүйд суурилан орон нутгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах ажил нь нэн чухал, анхдагч алхмуудын нэгэнд багтах ёстой.

Орон нутгийн олон нийтийн оролцоонд суурилсан бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих стратеги нь ургийн хөгжлийн үеэс сургуульд элсэн суралцах хүртэлх насыг хамрах нь нийтлэг байна. Олон нийтийн оролцоонд суурилсан бага насны цогц хөгжлийг дэмжих стратегийн зорилго нь зорилтот бүлгийн буюу 6 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд-хоол тэжээл, хөгжил-боловсрол, халамж асаргаа-хамгааллын асуудлыг цогцоор авч үзэж, хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

Монгол улсад, орон нутгийн түвшинд олон нийтийн оролцоонд суурилсан бага насны цогц хөгжлийг дэмжих стратегийг хэрэгжүүлэхэд аймаг, дүүрэг, сум, хорооны засаг захиргаа, эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгааллын байгууллагууд болон хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан нэгж, ажилтнууд, цагдаа болон бусад холбогдох талууд, иргэний нийгмийн байгууллагууд, эцэг эх, иргэд хамтран ажиллана.

Олон нийтийн оролцоонд суурилсан бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих стратеги нь дараах үе шатыг өөртөө агуулсан байх нь нийтлэг байна. Үүнд:

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Үр дүнд чиглэсэн төлөвлөлт
- Хамтрагч талуудын оролцоонд суурилсан идэвхтэй хэрэгжилт
- Завсрын болон үр дүнгийн хяналт
- Жилийн, дунд хугацааны тайлан зэргийг дурдаж болно.

Олон нийтийн оролцоонд суурилсан бага насны цогц хөгжлийг дэмжих стратегид дараах жишиг үйл ажиллагааг төлөвлөн багтааж болно. Үүнд:

*Эцэг эх асран хамгаалагчдыг чадавхжуулах хөтөлбөр* - хамтрагч талууд бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих сургалт зохион байгуулах, ном гарын авлагаар хангах, зайны сургалт зохион байгуулах зэрэг.

*Гэр бүлд зочлох, явуулын буюу хөдөлгөөнт үйлчилгээ* - мэргэжилтнүүд (эмч, хоол тэжээлийн мэргэжилтэн, багш, хамгааллын ажилтан, захиргааны ажилтан зэрэг) хамтран, нэгдсэн хөтөлбөрөөр гэр бүлд хүрч үйлчлэх.

*Тоглоомын бүлэг* - Зорилтот бүлгийн эцэг эхчүүдийн сайн дурын үндсэн дээр нэгтгэн хүүхдийн хөгжлийн асуудлаар туршлага солилцох, хамтран суралцах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

*Хүүхэд хүүхдэдээ* - сургуулийн сурагчид бага насны хүүхдүүдэд туслах, тэдний хөгжлийг дэмжих сайн дурын арга хэмжээ зохион байгуулах зэргийг дурдаж болно.





## СЭДЭВ 2

### БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХООЛ ТЭЖЭЭЛ,

Хүний амьдралын эхний 1000 хоногт нь эрүүл мэндийн суурь тавигдаж, бие эрхтэн хөгжин дархлаажиж, оюун хөгжлийн эх суурь тавигдаж, бодисын солилцооны хэтийн төлөв тодорхойлогддог.

Түүнчлэн энэ хугацаанд хүүхдийн тархи, бие махбодын хөгжил нь хамгийн хурдтай явагддаг төдийгүй тэдний тархины хөгжлийг дэмжих боломжит, эгзэгтэй цонх үе байдаг.

Иймд жирэмсэн эмэгтэй, хэвлий дэх ураг, хөхүүл эх, бага насны хүүхэд нь тэжээллэг, илчлэг хоол хүнсээр бүрэн хангагдаж байвал хүүхдийн бие махбодын өсөлт, сэтгэн бодох чадвар, хөдөлгөөний үр чадвар, нийгэмд дасан зохицох зөв эхлэл болдог. Харин энэхүү эгзэгтэй цонх үед хүүхдийн хооллолт, хоол тэжээл мүү байх нь ураг өсөлтгүй болох, нярай үе, нялх, бага насандаа хоол тэжээлийн дуталд өртөх, өвчлөх, эндэх шалтгаан болдог байна.

Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн хооллолт, хоол тэжээлийн байдал нь хүүхдийн хөгжилд шууд нөлөөлдөг байна. Эрүүл, зохистой хооллолт нь бага насны хүүхдийн бие махбодын



Хүний амьдралын эхний 1000 хоног гэдэг нь ураг эхийн хэвлийд бүрэлдэн бий болж, нүдэнд харагдахгүй зөвхөн 1 эс байх мөчөөс эхлэн хүүхэд 2 нас хүртэлх хугацаа юм. Үүнд жирэмсэн үеийн 270 хоног, 1 нас хүртэлх 365 хоног, 2 нас хүртэлх 365 хоног багтдаг.

өсөлт, оюун ухааны хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй. Мөн энэхүү цонх үед чиглэсэн хоол тэжээлийн тусламжийг хамгийн үр ашигтай арга хэмжээ хэмээн улс орнууд хүлээн зөвшөөрч байна.

Амьдралын эхний 1000 хоног дахь хүүхдийн өсөлт, хөгжлийн саатал нь хожим тархи, мэдрэлийн эмгэг үүсэх, суралцах чадвар буурах эрсдэлд хүргэдэг. Улмаар сургууль завсардах, боловсролгүй эсвэл үр чадвар сул иргэн болох, цаашлаад үр хүүхдээ муу асрах гэх мэт үе дамжсан ядуурал, хоол тэжээлээс хамааралтай эмгэгт өртөх шалтгаан болдог. Иймээс урьдчилан сэргийлэх – хоол тэжээлийн бүхий л арга хэмжээг амьдралын эхний 1000 хоногт чиглүүлэхийг мэргэжилтнүүд зөвлөж байна.

Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дадлыг сайжруулах нь дэлхийн болон улс орнуудын нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх алхам болохыг хүлээн зөвшөөрсөн<sup>1</sup>.

Монгол Улсын Засгийн газраас нялх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих, ялангуяа эхийн сүүгээр хооллолтыг хамгаалах, дэмжих бодлого баримтлахын зэрэгцээ нялх, бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын дадлыг сайжруулах чиглэлээр олон тооны бодлого, эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна.

Өнөөгийн байдлаар нялх, бага хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийг дэмжих зорилгоор дараах хоол тэжээлийн бодлого, эрх зүйн баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Монгол Улсын Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль, УИХ-ын тогтоол, 2017 оны 5 дугаар сарын 12 өдөр
- “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгэр сарын 16-ны өдрийн 447 дугаар тогтоол
- Нялх балчир хүүхдийг хооллох заавар, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/481 тоот тушаал
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 тоот тушаал, 2013 оны 450 тоот тушаал (эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай)
- Эрүүл мэндийн сайдын 2013 оны 100 дугаар тушаал: “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн зөвлөмж хэмжээ, заавар”, “ЭМЯ-ны дэргэдэх Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хангамж,

1 ДЭМБ, НҮБХС-аас “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дэлхийн стратеги” болон “Эхийн сүүгээр хооллодог нялх, бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын удирдамж”, “Гамшиг, онцгой байдлын үед нялх, бага насны хүүхдийг хооллох удирдамж”, “Эхийн сүүгээр хооллодоггүй 6-23 сартай хүүхдийг хооллолтын удирдамж” зэрэг суурь баримт бичгийг боловсруулж, гишүүн орнуудад хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг.

хэрэглээг үндэсний хэмжээнд зохицуулах зөвлөлийн эрх, үүрэг”, “Аймаг, нийслэлийн хэмжээнд Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хангамж, хэрэглээг зохицуулах ажлын хэсгийн эрх, үүрэг, бүрэлдэхүүн”, “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиглэл”, “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээнд хяналт тавих, үнэлгээ хийх, мэдээ, тайлан”, Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл хэрэглэсэн эхчүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхдийн бүртгэлийн маягтууд.

## ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ

Эхийн сүү нь хүүхдийн амьдралын эхний 6 сард шаардлагатай өөх тос, нүүрс ус, уураг, аминдэм, эрдэс болон усыг агуулдаг бөгөөд амархан боловсорч, бүрэн шимэгддэг байна. Мөн хүүхдийн дархлааг дэмжих, халдвараас хамгаалах хүчин зүйлсийг агуулдаг.

Эхийн сүүнд 3,5 грамм тос агуулагддаг. Энэ нь эхийн сүүний илчлэгийн тал хувийг бүрдүүлдэг байна. Эхийн сүүн дэх тос нь жижиг дусал хэлбэрээр ялгардаг бөгөөд хүүхэд хөхөх явцад хэмжээ нь нэмэгддэг. Хүүхдийг хөхүүлж эхлэх үед эхийн хөхнөөс цэхэр саарал өнгийн сүү ялгардаг ба үүнийг тослог багатай эхэн үеийн сүү гэж нэрлэдэг. Харин үргэлжлүүлэн хөхүүлэхэд эхийн сүү тод цагаан өнгөтэй болдог бөгөөд үүнийг тослогоор баялаг төгсгөлийн сүү гэнэ. Эхийн сүүний тос нь урт гинжит олон ханаагүй тосны хүчлүүд (омега – 3 буюу docosahexaenoic acid (DHA), арахидоны хүчил) байдаг. Эдгээр тосны хүчил нь бусад төрлийн сүүнд агуулагддаггүй бөгөөд хүүхдийн тархины хөгжилд нэн ач тустай. Харин бусад сүүнд агуулагддаггүй. Зарим төрлийн хүүхдийн сүүн тэжээлийг шар буурцгийн богино гинжит тосны хүчлээр баяжуулдаг хэдий ч эдгээр нь хүүхдийн тархины хөгжлийн хэрэгцээг хангаж чадахгүй.

Эхийн сүүн дэх нүүрс ус нь лактоз болон дисахар юм. 100 грамм эхийн сүүнд 7 грамм лактоз агуулагддаг бөгөөд илчлэгийн гол эх үүсвэр болдог. Эхийн сүүний лактоз нь өөрийгөө задлагч эсгэгч агуулдаг онцлогтой бол бусад төрлийн нүүрс ус болох олигосахарид нь бага



Эхийн сүүнд агуулагдах хэмжээ нь хангалтгүй байдаг цорын ганц аминдэм бол Д аминдэм юм. Иймд хүүхдийн насанд тохирсон тунгаар Д аминдэмийн бэлмэлийг уулгах, нарны туяаны тусламжтайгаар нийлэгжилтийг идэвхжүүлэх шаардлагатай.

хэмжээгээр уурагтай нэгдэж, хүүхдийг халдвараас хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Эхийн сүүний уураг нь малын сүүнээс үнэт чанар болон хэмжээгээрээ ялгаатай бөгөөд хүүхдийн бие махбодын онцлогт тохирсон, үл орлогдох аминхүчлээр баялаг байдаг. Эхийн сүүний уургийн агууламж нь малын сүүтэй харьцуулахад бага (100 миллилитр эхийн сүүнд 0.9 грамм уураг) боловч, бага насны хүүхдийн гүйцэт хөгжөөгүй хоол боловсруулах замын эрхтнүүд, бөөрөнд хэт их ачаалал үүсгэхгүй хамгийн тохиромжтой хоол юм. Малын сүүний уургийн агууламж хэт их байдаг тул түүний задралын үр дүнд үүсэх эцсийн бүтээгдэхүүнийг нялх, бага насны хүүхдийн бөөр ялгаруулахад нилээд хүндрэлтэй байдаг. Иймд хүүхдийг малын сүү, сүүн тэжээлээр хооллохоос зайлсхийх нь зүйтэй. Эхийн сүүнд казеин уураг бага хэмжээгээр байдаг бөгөөд молекул бүтэц нь малын сүүтэй харьцуулахад, амархан боловсорч шингэдэг байна. Эхийн сүүнд шар сүүний уураг буюу альбумин их хэмжээгээр агуулагддаг ба халдвараас хамгаалах үүрэг бүхий глобулин уураг байдаг. Энэ нь хүүхдийг аливаа халдвараас хамгаалахаас гадна хоол хүнснээс шалтгаалсан харшлаас сэргийлнэ.

Эх өөрөө аминдэмийн дуталтай байхаас үл хамааран эхийн сүүнд хүүхдэд хэрэгцээтэй аминдэм хангалттай хэмжээгээр агуулдаг. Эхийн сүүнд агуулагдах эрдэс бодисууд үнээний сүүнээс 3-3.5 дахин бага боловч, хүүхдэд хамгийн тохиромжтой харьцаатай байдаг аж. Эхийн сүү хүүхдийн биед хялбар шингэдэг төмрөөр баялаг тул цус багадалтаас сэргийлэх ач холбогдолтой. Нялх хүүхэд эхээс төрөхдөө зохих хэмжээний төмрийн нөөцтэй байдаг тул хугацаандаа, хэвийн жинтэй төрсөн хүүхэд 6 сар хүртлээ төмрийн бэлдмэлийг нэмэлтээр хэрэглэх шаардлагагүй. Харин хүүхэд бага жинтэй дутуу төрсөн тохиолдолд 6 сар хүрэхээс өмнө төмөр хэрэглэхийг зөвлөдөг.

#### ХАЛДВАРЫН ЭСРЭГ ХҮЧИН ЗҮЙЛС: Эхийн сүүнд нялхсыг

халдвараас хамгаалах маш олон хүчин зүйлүүд байдаг. Үүнд:

- Шүүрлийн иммуноглобулин А (sIgA) – гэдэсний салст бүрхэвчийг бүрж, нянгийн халвараас сэргийлнэ.
- Цагаан эс - нярай болон нялх хүүхдийг халдвар, үхжилээс сэргийлдэг
- Шар сүүний уураг (лизоцим, лактоферрин) – мөөгөнцөр, нян, вирусийн эсрэг үйлдэлтэй.
- Олигосахаридууд – салст бүрхэвчийн гадаргууд нян бэхлэгдэхээс хамгаална.

Эхийн сүү нь хүүхдийн бие махбод, ялангуяа тархи, мэдрэл, ходоод, гэдэсний замын эрхтний өсөлтийг дэмжих өвөрмөц үйлдэлтэй өсөлтийн хүчин зүйлийг агуулдаг байна.

**АНГИР УУРАГ БА НАЙРЛАГА ТОГТМОЛЖСОН СҮҮ.** Ангир уураг нь төрсний дараах эхний 3-4 хоногт бага хэмжээтэй (эхний өдөр 40-50 миллилитр) ялгардаг, өвөрмөц найрлагатай, тод шаргал өнгийн сүү юм. Хэдийгээр бага хэмжээгээр ялгардаг боловч, шинэ төрсөн нярай хүүхдийн бүх хэрэгцээг хангаж чадна. Ангир уураг нь цагаан эс болон эсрэг бие, шүүрлийн А иммунноглобулинаар баялаг, эрдэс, усанд уусдаг аминдэм (А, Е, К) болон уургийн агууламжаараа найрлага тогтмолжсон сүүнээс илүү байдаг. А аминдэм нь нүд болон хучуур эдийн гадаргуугийн бүрэн бүтэн байдлыг хамгаалдаг байна.

#### ХҮСНЭГТ 1. Ангир уургийн шинж чанар, ач холбогдол

Онцлог чанар	Ач холбогдол
Эсрэг биеэр баялаг	Харшил болон халдвараас хамгаална
Цагаан эс ихтэй	Халдвараас хамгаална
Цэвэрлэх үйлчилгээтэй	Зунгагийг түргэн гадагшлуулж, хүүхдийн гэдсийг цэвэрлэнэ. Төрсний дараах шарлалтаас сэргийлнэ
Өсөлтийн хүчин зүйлс	Хүүхдийн гэдэс бүрэн гүйцэт хөгжихөд тусална. Харшил үүсэх, хоол хүнс тохирохгүй болохоос сэргийлнэ.
А аминдэмээр баялаг	Халдварын хүндрэлийг бууруулна

Ангир уураг нь эсрэг бие болон халдварын эсрэг уургыг найрлага тогтмолжсон сүүнээс илүү их хэмжээгээр агуулдаг.

- Найрлага нь тогтмолжсон сүүнээс илүү их хэмжээтэй цагаан эс агуулдаг.
- Шинэ төрсөн нярайд аюултай нянгийн халдвараас сэргийлдэг ач холбогдолтой бөгөөд төрсний дараа хүүхдэд тохиолдож болох олон өвчний эсрэг анхны дархлааг үүсгэдэг.

Төрсний дараа 3-4 хоногт эхийн хөх чинэрч сүү их хэмжээгээр үүсч эхэлдэг бөгөөд үүнийг сүү орох гэж нэрлэдэг. Нярай хүүхдэд төрсний дараах 3 дахь хоногт 300 – 400 миллилитр, 5 дахь хоногт 500-800 мл сүү хангалттай байдаг. Төрсний дараах 7-14 хоногт ялгарч байгаа эхийн сүүг завсарын сүү, 2 долоо хоногийн дараах эхийн сүүг найрлага тогтмолжсон сүү гэж нэрлэдэг.

- Ангир уураг нь бага зэргийн туулгах үйлчилгээтэй тул хүүхдийн гэдсийг зунгаг (анхны бараан өнгөтэй баас)-аас цэвэрлэж өгдөг. Ийм цэвэрлэгээ нь билирубиныг биеэс гадагшлуулж, нярайн шарлалт гүн явагдах, түүний хүндрэлээс сэргийлнэ.
- Ангир уураг нь өсөлтийн хүчин зүйлс агуулдаг тул хүүхдийн гэдэс гүйцэт боловсорч, хөгжихөд эерэг нөлөө үзүүлнэ. Ингэснээр бусад төрлийн хоол, хүнс тохирохгүй болох, харшил үүсэхээс сэргийлж чадна.
- Ангир уураг нь А аминдэмээр баялаг тул хүүхдэд тохиолдож болох аливаа халдварын хүндрэлийг бууруулахад тусална.

Эхийн сүүгээр хооллолт нь бага насны хүүхдийг халдвар, харшлаас хамгаалж, өвчлөх, эндэх эрсдэлийг бууруулдаг байна. Тухайлбал, олон эрдэмтэд эхийн сүүгээр хооллолтын ач холбогдлыг баримтаар нотолсон байдаг. Тухайлбал:

- *Эхийн сүүгээр дагнан хооллолт (3 сар хүртэл ба түүнээс хугацаагаар хооллосон бол)* - дунд чихний халдварын эрсдэлийг 50% бууруулдаг.
- *Эхийн сүүгээр дагнан хооллолт (6 сар хүртэл хооллосон бол)* - чих, хамар, хоолой, амьсгалын замын хүнд халдвараар өвчлөх эрсдэл нь 63% бага.
- *Эхийн сүүгээр хооллолт* - дутуу төрсөн нярай хүүхдийн үхжилт энтерколитын тохиолдлыг 60% бууруулдаг.
- *Ямар нэг байдлаар эхийн сүүгээр хооллох* - дунд чихний халдварын эрсдэлийг 23% бууруулдаг.
- *Эхийн сүүгээр дагнан хооллолт (4 сар хүртэл ба түүнээс хугацаагаар хооллосон бол)* - амьсгалын замын халдвараар өвчилж эмнэлэгт хэвтэх эрсдэл нь 72% бага.
- *Эхийн сүүгээр хооллолт* - Нэг сарын доторх гэнэт нас баралтын эрсдэлийг 50%, 1 хүртэлх насны хүүхдийн гэнэт нас барах эрсдэлийг 36% бууруулна.
- *Эхийн сүүгээр дагнан хооллолт (3-4 сар хүртэл хугацаагаар хооллосон бол)* - багтраа, атопи дерматит, экзема зэрэг өвчлөх эрсдэлийг 27-42% бууруулдаг.
- *Эхийн сүүгээр хооллолт* - Целиак өвчнөөр өвчлөх эрсдэлийг 52% бууруулдаг.
- *Эхийн сүүгээр хооллолт* - гэдэсний үрэвсэлт өвчнөөр өвчлөх эрсдэлийг 30% бууруулдаг.
- *Эхийн сүүгээр хооллолт (6 сар хүртэл ба түүнээс хугацаагаар хооллосон бол)* - хүүхдийн цагаан эсийн хавдраар өвчлөх эрсдэлийг 15-20% бага.

- Эхийн сүүгээр дагнан хооллолт (3 сар хүртэл ба түүнээс хугацаагаар хооллосон бол) - Чихрийн шинжин-I өвчлөх эрсдэлийг 30%, Чихрийн шижин – II эрсдэлийг 40% бууруулдаг.
- Эхийн сүүгээр хооллосон хүүхдийн дунд таргалалтын тархалт сүүн тэжээлээр хооллосон хүүхэдтэй харьцуулахад 15-30% бага,
- Эхийн сүүгээр хооллосон сар тутамд таргалалтын эрсдэл 4%-аар буурдаг байна.
- Эхийн сүүгээр хооллосон хүүхдийн оюун ухааны чадамж, сурах чадвар нь илүү байдаг.

**НЭМЭГДЭЛ ХООЛЛОЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ.** Хүүхэд 6 сар хүрмэгц тэдний бие махбодын төмөр, цайр болон бусад нэн шаардлагатай шимт бодисын хэрэгцээ нэмэгдэж, эхийн сүү дангаараа энэхүү нэмэгдсэн хэрэгцээг хангаж чадахгүй болдог. Энэхүү нэмэгдсэн хэрэгцээг хангах зорилгоор хүүхдэд эхийн сүүн дээр нэмэлтээр бусад хоол хүнс өгөх шаардлага үүснэ. Иймд нялх, бага насны хүүхэд, ялангуяа 6 сараас дээш насны хүүхдийн хоол тэжээлийн байдалд нэмэгдэл хооллолт шийдвэрлэх үүрэгтэй. Нэмэгдэл хооллолт нь хүүхдийн хоол тэжээлийн байдлыг зохистой түвшинд барих, хоол тэжээлээс хамааралтай эмгэгээс сэргийлэх, улмаар өвчлөх, эндэх эрсдэлийг бууруулах үндэс болно.

Нялх, бага насны хүүхдийг хооллох дадалтааруу, хоолтэжээлийн дуталтай байх нь тэдний өвчлөх, улмаар эндэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Дэлхийн хүнс хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)–аас эрхлэн гаргадаг “Дэлхийн хүнсний баталгаат байдал ба хоол тэжээл – 2018” тайланд 5 хүртэлх насны хүүхдийн дунд өсөлт хоцролтын тархалт буурсан хэдий ч, түгээмэл хэвээр 2017 оны байдлаар 151 сая хүүхэд ( $\geq 22\%$ ) өсөлт хоцролттой байгааг тэмдэглэсэн байдаг. Мөн 51 сая хүүхэд туранхай буюу өвчлөх, эндэх өндөр эрсдэлтэй, 38 сая хүүхэд илүүдэл жинтэй байгаа талаар мэдээлсэн<sup>2,3</sup>.

ДЭМБ-ын мэдээгээр 2017 онд 5 хүртэлх насны 5.4 сая хүүхэд буюу амьд төрсөн 1000 хүүхэд тутмын 39 энджээ. Эндсэн хүүхдүүдийн 45 хувь хоол тэжээлийн дуталтай байсан бөгөөд жил бүр 2.7 сая хүүхэд хоол тэжээлийн дутлын улмаас эндэж байна.


2 FAO, IFAD, UNICEF, WFP and WHO. (2018). The State of Food Security and Nutrition in the World 2018. Building climate resilience for food security and nutrition. Rome, FAO.

3 UNICEF, WHO. (2008). World Bank Group Joint Child Malnutrition Estimates. Level and trends in child malnutrition, key findings.

Ихэнх улс орны 6-23 сартай хүүхдийн маш бага хэсэг буюу 4 хүүхэд тутмын 1 хүрэхгүй хувь нь зохих нэр төрлийн хүнсийг насандаа тохирсон давтамжтай хэрэглэж байна (ДЭМБ, 2018).

**БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХООЛЛОЛТЫН ДАДАЛ.** Монгол Улсын бага насны хүүхдийн 97.9 хувь эхийн сүүгээр хооллож байсан боловч, 83.7 хувь төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаа амласан байна. Хүүхдийг төрсний дараа эрт амлуулах байдал хүйсийн хувьд ялгаагүй, харин хөдөө (87.6%)-гийн хүүхдийн дунд хот (81.9%)-ын хүүхдээс харьцангуй илүү байв. Мөн бага жинтэй төрсөн хүүхдийн дунд ангир уургаа эрт амласан хүүхдийн үзүүлэлт нилээд доогуур, хэвийн жинтэй төрсөн хүүхдээс 1.7 дахин бага байна.

**ЗУРАГЛАЛ 2. Эрт амлуулалт (хүүхдийн хүйс, байршил, төрөх үеийн жингээр)**



Монгол улсад 6 сар хүртлээ эхийн сүүгээр дагнан хооллосон хүүхэд нийт хүүхдийн 58.3 хувийг эзэлж байгаа бол хоёр нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон хүүхдийн хувь аль ч бүс нутаг, хүн амын байршил, амьжиргааны түвшинг үл харгалзан харьцангуй доогуур байна. Ялангуяа, Улаанбаатар хотын, чинээлэг өрхийн хүүхдүүд эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох дадал тааруу байгааг дараах хүснэгтээс харж болно.

**ХҮСНЭГТ 2. Эхийн сүүгээр хооллолтын байдал**

Шинж байдал		Эхийн сүүгээр дагнан хооллолт		1 нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон		1 нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон	
		%	n	%	n	%	n
Хүйс	Эрэгтэй	56.0	102	78.7	101	43.3	84
	Эмэгтэй	61.0	99	83.5	105	51.2	86
Эдийн засгийн бүс	Баруун	76.5	34	81.1	37	50.0	32
	Хангай	63.0	46	86.7	45	65.0	40
	Төв	52.1	48	91.5	47	51.4	35
	Зүүн	58.3	24	86.8	38	45.1	31
	Улаанбаатар	55.1	49	74.3	39	37.5	32



Хот, хөдөө	Хот	57.2	110	79.3	99	41.9	83
	Хөдөө	61.2	91	84.8	107	57.3	87
Өрхийн аж байдлын түвшин	Ядуу	60.7	41	83.1	47	52.4	55
	Дунджаас доогуур	64.6	38	84.7	35	56.1	27
	Дундаж	65.5	53	77.1	44	48.4	29
	Дунджаас дээгүүр	46.5	41	84.8	56	50.6	33
	Чинээлэг	54.0	28	73.0	24	32.6	26

Эх сурвалж: Хоол тэжээлийн үндэсний 5-р судалгаа.2018

Монгол Улсын 6-23 сартай бараг бүх хүүхэд (96.5%) нэмэгдэл хоолонд хугацаандаа орсон буюу 6 сартайгаас хоол өгч эхэлсэн бөгөөд (92.1%) насандаа тохирсон давтамжаар хооллож байв. Бага насны хүүхдийг зохих хугацаанд нь нэмэгдэл хоолонд оруулах дадал хөдөө (92.5%)-гийн болон Баруун бүсийн хүүхдийн дунд (83.3%) харьцангуй доогуур байна.

Бага насны хүүхдийн эхийн сүүгээр хооллолтын чиг хандлагыг 1999–2017 оны байдлаар харьцуулан үнэлэхэд эхчүүдийн хүүхдээ хөхүүлэх хугацаа тасралтгүй буурсаар байна. Мөн ДЭМБ-аас хүүхдийг төрсний дараа 30 минутын дотор ангир уургаар амлуулахыг зөвлөдөг байсан бол 2007 онд хийсэн өөрчлөлтөөр 1 цагийн дотор амлуулахыг зөвлөсөн. Энэ шалтгааны улмаас 2004 оны судалгааны дүнгээр эрт амлуулалтын үзүүлэлт буурсан хэдий ч, 2010 оноос хойш уг үзүүлэлтэд огцом өөрчлөлт ажиглагдахгүй байна. ДЭМБ-аас хүүхдийг 4 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох зөвлөмжийг шинэчилж, 6 сар болгон өөрчилсөн билээ. Үүгээр эхийн сүүгээр дагнан хооллосон хүүхдийн үзүүлэлт 1999-2004 онд огцом буурсан дүнг тайлбарлаж болох хэдий ч, 2017 оны байдлаар 2010 оны түвшин (ХТҮС IV)-гээс 13 пунктээр буурсан байна. Түүнчлэн бага насны хүүхдийн эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох байдал, ялангуяа 2 нас хүртлээ эхийн сүүгээр хооллосон хүүхдийн хувь жилээс жилд тасралтгүй буурч байгааг удаа дараагийн судалгааны дүн харуулж байна (Хавсралт 1. -ээс харна уу).


Бага насны хүүхдийг насанд тохирсон давтамжаар хооллох байдал бүс нутгаар болон өрхийн аж байдлын түвшингээр ялгаатай, амьдралын баталгаажих түвшингээс доогуур өрхийн (87.5%) болон баруун бүсийн (83.1%) хүүхдүүд өдөрт хоолловол зохих тоогоор хооллож чадахгүй байв.

Бага насны хүүхдийн хооллолтын чанарыг илтгэх үндсэн үзүүлэлт бол хүүхдийг өдөр бүр 4 ба түүнээс олон нэр төрлийн хүнсээр хооллох дадал юм. Монгол улсад бага насны хүүхдийн тал хувь (49.6) нь зохих нэр төрлийн хүнс хэрэглэж байна. Тодруулбал, 6-11 сартай хүүхдийн дөнгөж 40.3 хувь, 12-23 сартай хүүхдийн 54.8 хувь нэмэгдэл хоолыг зохих нэр төрлийн хүнсээр

баяжуулан иддэг буюу “хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлага” хангасан хооллолттой байв. Хоногт хэрэглэвэл зохих хүнсний нэр төрлийн хамгийн бага шаардлагыг хангасан хооллолттой хүүхдийн хувь бүс нутаг, хот хөдөө, өрхийн аж байдлын түвшингээр статистик ач холбогдол бүхий ялгаатай, баруун бүсэд 24.2 хувь, хөдөөд хувь, ядуу өрхийн хүүхдийн тухайд 32.1 хувьтай байна (Хүснэгт 2).

Хоол тэжээлийн үндэсний 5 дугаар судалгаагаар нялх хүүхдийн дийлэх хувь (96.5) нь тохирох насандаа буюу 6 сартайгаас нэмэгдэл хоол идэж эхэлсэн хэдий ч, 6-23 сартай хүүхдийн талаас илүү хувь (56.2) нь зохистой байдлаар хооллож чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, 4 ба түүнээс олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж чадахгүй, насандаа тохирсон давтамжаар хооллохгүй байгааг илрүүлсэн. Мөн зохистой байдлаар хооллож чаддаггүй хүүхэд хүүхдийн дунд өсөлт хоцролтын тархалт харьцангуй илүү байгааг тогтоосон. Тухайлбал, зохистой байдлаар хооллодог хүүхдийн 4.6 хувь, харин зөвлөмжийн дагуу хооллож чадахгүй байгаа хүүхдийн 7.6 хувь нь тус тус өсөлт хоцролттой байв. Нялх, бага насны хүүхдийн зохистой хооллолтын үндэс нь өдөр бүр 7 бүлэг хүнсний бүтээгдэхүүнээс хамгийн багадаа дөрвөн нэр төрлийн хүнсийг тогтмол хэрэглэхэд оршино.

**ЗУРАГЛАЛ 3. Бага насны хүүхдийн хооллолтын байдал, 2010-2017 онд**



Эх сурвалж: Хоол тэжээлийн үндэсний 5-р судалгаа, 2018. НЭМҮТ

Нэмэгдэл хооллолтын дадал тааруу байх нь нялх, бага насны хүүхдийн дунд тохиолдож буй өсөлт хоцролт, илүүдэл жин, А ба Д аминдэм, төмөр дутлын суурь шалтгаан болдог байна. Хоногт хэрэглэвэл зохих нэр төрөл ( $\geq 4$ )-ийн хүнсийг насандаа тохирсон давтамж, хэмжээгээр хэрэглэж буй хүүхдийг “Зохистой байдлаар хооллож буй хүүхэд” хэмээн үнэлдэг. Манай улсын 6-23 сартай хүүхдийн 43.8 хувь зохистой байдлаар хооллож байгааг судлаачид илрүүлсэн. Зохистой байдлаар хооллож буй хүүхдийн үзүүлэлт

хот хөдөөгөөр, бүс нутгаар, өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай, тэгш бус байдал оршсоор байна.


### ХҮСНЭГТ 3. Монгол Улсын бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын дадал

Шинж байдал Хүүхдийн тоо			Зохих нэр төрлийн хүнс хэрэглэдэг хүүхэд <sup>a</sup>		Зохистой байдлаар хооллож байгаа хүүхэд		Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож буй хүүхэд		
			%	95%CI	%	95%CI	%	95%CI	
Бүгд			903	50.4	46.4-54.4	43.8	39.8-47.8	69.2	65.8-72.5
Хүйс	Эрэгтэй	448	52.3	46.7-57.9	46.4	40.8-52.1	66.3	61.2-71.0	
	Эмэгтэй	455	46.8	41.2-52.5	41.0	35.5-46.8	72.4	67.6-76.7	
Бүс нутаг	Баруун	161	24.2	18.2-31.4	19.8	14.4-26.7	75.4	68.9-81.0	
	Хангай	187	41.7	34.9-48.9	39.6	32.8-46.8	73.4	67.3-78.7	
	Төв	199	56.8	49.8-63.5	52.8	45.8-59.6	70.4	64.4-75.8	
	Зүүн	161	49.7	42.0-57.3	41.0	33.6-48.7	70.3	63.3-76.4	
	Улаанбаатар	195	55.9	48.9-62.7	48.2	41.3-55.2	66.0	59.8-71.7	
Хот, хөдөө	Хот	449	53.7	48.3-59.0	46.9	41.5-52.3	68.3	63.6-72.7	
	Хөдөө	454	40.8	36.2-45.6	37.1	32.5-41.9	71.3	67.1-75.1	
Өрхийн аж байдлын түвшин	Ядуу	239	32.1	25.2-39.8	29.7	23.0-37.3	71.3	64.6-77.3	
	Дунджаас доогуур	171	36.3	28.1-45.3	30.9	23.2-39.9	71.9	63.9-78.7	
	Дундаж	170	55.9	46.7-64.7	47.9	38.8-57.1	67.4	59.3-74.5	
	Дунджаас дээгүүр	180	60.1	51.1-68.5	52.7	43.7-61.5	68.4	60.1-75.6	
	Чинээлэг	143	62.6	53.2-71.2	56.5	47.1-65.5	67.3	58.7-74.9	

Эх сурвалж: Хоол тэжээлийн үндэсний 5-р судалгаа.2018

Хүүхэд өсөж томрохын зэрэгцээ тэдний хөдөлгөөний идэвх нэмэгдэж илчлэг, шимт бодисын хэрэгцээ ихэсдэг. Иймд 6 сар хүрсэн хүүхдийн илчлэгийн хэрэгцээг эхийн сүү дангаараа хангаж чадахгүй болно.

### ЗУРАГЛАЛ 4. Бага насны хүүхдийн эхийн сүүгээр авах илчлэг ба хангагдаагүй хэрэгцээ




Эх сурвалж: Хоол тэжээлийн үндэсний 5-р судалгаа.2018

Нэмэгдэл хоол иддэг 6-8 сартай хүүхдийн илчлэгийн хэрэгцээний 2/3 хувь, 9-11 сартай хүүхдийн илчлэгийн хэрэгцээний бараг тал хувь, 12-23 сартай хүүхдийн илчлэгийн 1/3 хувийг тус тус эхийн сүү дангаараа хангадаг байна.<sup>4</sup>

## ХҮҮХДИЙН ХООЛ ТЭЖЭЭЛ БА ТАРХИНЫ ХӨГЖИЛ

Ургийн тархины хөгжил ойролцоогоор 21 хоногтойгоос эхэлнэ. Хүүхдийн тархины хөгжлийн хамгийн эгзэгтэй үе бол “жирэмслэлтийн дунд үеэс 2 нас” хүртэл үргэлжилдэг. Нярай хүүхдийн тархи нь биеийн жингийн 10 хувьтай тэнцүү байдаг бол насанд хүрэгчдийнх 2 хувь байдаг аж. Тархины эс нь ойролцоогоор 100 тэрбум байдаг бөгөөд энэ тоо хүний амьдралын туршид бараг өөрчлөгддөггүй байна. Эрүүл, зохистой хооллолт нь хүний амьдралын туршид эдгээр эс хооронд холбоос үүсэхэд тусална.

ЗУРАГЛАЛ 5. Хүүхдийн мэдрэлийн эсийн хөгжил



Хүүхэд төрөх үед

7 настай хүүхэд

15 настай хүүхэд

Ургийн болон нярай үед үүссэн хоол тэжээлийн дутал нь хүүхдийн тархины хөгжил саатах шалтгаан болдог. Хоол тэжээлийн дутал хэзээ үүссэн, хэр удаан үргэлжилж байгаа, хэр зэрэг их гүнзгий буюу хүнд, хүндэвтэр хэлбэрийн аль нь болохоос сөрөг үр дагаврын цар хүрээ тодорхойлогдоно. Зарим төрлийн шимт бодисын дутал хүүхдийн тархины хөгжил саатахад шийдвэрлэх нөлөө үзүүлдэг болохыг судлаачид тогтоосон байдаг. Тухайлбал, уураг, илчлэг, тосны хүчил, төмөр, цайр, зэс, иод, селен А аминдэм, холин, фолийн хүчил гэх мэт.

4 ДЭМБ ба НҮБ-ын Хүүхдийн сан, Нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө сургалт, 2006 он.



## СЭДЭВ 3

### БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Эцэг, эх бүр өөрийн хүүхдээ эрүүл байгаасай гэж хүсдэг. Учир нь эрүүл хүүхэд баяр баясгалантай, аз жаргалтай, олны дунд идэвхтэй амьдардаг. Зарим гэр бүлийн хувьд хүүхдээ эрүүл өсгөж бойжуулах нь хүндрэлтэй байж болно. Ялангуяа ундны ус бохирдсон, эрүүл ахуйн нөхцөл тааруу, хүүхдийн асрамжлагч нь эрүүл ахуйн зөв дадал эзэмшээгүй гэр бүлийн хүүхэд аливаа өвчин, эмгэгт өртөмхий болно. Гэсэн хэдий ч гэр бүл, олон нийтийн зүгээс амьдралын нөхцөл байдалд нийцсэн, хямд өртөгтэй олон нийтийг хамарсан арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлбэл хүүхдэд тохиолдох дийлэнх өвчнөөс сэргийлэх боломжтой.

### НЯЛХ, БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ

**ЭХНИЙ НЭГ САР.** Жирэмсэн эмэгтэй, ургийн эрүүл мэнд нь түүний гэр бүл, ойр дотны хүмүүс, хамт олон, нийгмээс үзүүлж буй халамж, асаргаанаас ихээхэн хамаарна. Төрөлтөд бэлдэж төлөвлөх, төрөхийн өмнө дуншиж өвдөх, төрөх, төрсний дараах үед мэргэжлийн эх баригч, эмч тусламж үзүүлэх нь хүүхэд эрүүл төрөх, эсэн мэнд амьдрах баталгааг нэмэгдүүлдэг. Хүүхдийн амьдралын эхний сар нь хамгийн эгзэгтэй үе юм. Хүүхдийг төрсний дараах эхний 72 цагийн дотор дааруулбал дархлааны тогтолцоонд эргэлт буцалтгүй хямардаг тул төрөлтийн дараах асаргаанд үүнийг анхаарах ёстой. Ялангуяа дутуу төрсөн хүүхдийн хувьд энэ хугацаанд төрөл бүрийн халдварт өртөх магадлал нь хамгийн өндөр байдаг. Эх, хүүхэд хоёр цэвэр, аюулгүй орчинд амьдарч, тэжээллэг хоол хүнс хэрэглэж, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдах шаардлагатай. Нярай хүүхэд төрсний дараа нэг цагийн дотор ангир уургаа амлах нь түүний хувьд юугаар ч орлуулшгүй, эрүүл, тэжээллэг хоол болно. 2015 оноос ДЭМБ, Нэгдсэн Үндэстний Байгууллагын

Хүүхдийн Сангийн зөвлөмжийн дагуу “Нярайн нэн шаардлагатай тусламж” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төрсөн хүүхэд бүрийг эхний 30 минутын дотор амлуулж байна. Эхийн сүү нялхсын амьдралын эхний 6 сард шаардлагатай хоол тэжээлийн бүх хэрэгцээг бүрэн хангаж, эрүүл өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлнэ. Иймд хүүхдийг 6 сар хүртэл нь эхийн сүүгээр дагнан хооллохыг чухалчилж, хүүхдийг хүссэн үед нь өдөр, шөнийн аль ч цагт, аль болох олон удаа хөхүүлэхийг зөвлөдөг.

**НЭГ САРТАЙГААС 5 НАС ХҮРТЭЛХ ҮЕ.** Тав хүртэлх насны хүүхэд дараах өвчнөөр өвчлөх эрсдэлтэй байдаг. Үүнд:

- Уушгины хатгалгаа ба амьсгалын замын цочмог үрэвсэл
- Суулгалт
- Улаан бурхан
- Хоол тэжээлээс хамааралт эмгэг

Манай улсад бага насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийн зонхилох шалтгаан нь амьсгалын замын цочмог өвчнүүд, (ханиад шуухинаа, уушгины хатгалгаа) суулгалт, рахит, цус багадалт, тураал зэрэг эмгэгүүд байдаг<sup>5</sup>.

Бага насны хүүхэд намар, өвөл, хаврын улиралд ханиад шуухинаа<sup>6</sup>, уушгины хатгалгаар өвдөх нь элбэг бөгөөд судлаачид хүүхэд жилд дунджаар 5-8 удаа ханиад шуухинаагаар өвддөг болохыг тодорхойлсон байна.

Ханиад, шуухинаа нь амьсгалын зам (хамар, хоолой, залгиур)-ын цочмог халдвар ба нус гоожих, ханиалгах, халуурах шинжээр илэрнэ. Ханиалгах, найтаахад амьсгалын замын халдвар тархдаг. Ханиад, шуухинаатай хүүхдийн 30 орчим хувь нь уушгины хатгалгаагаар хүндэрдэг.

**УУШГИНЫ ХАТГАЛГАА** гэж амьсгалын замын цочмог халдварын улмаас уушгины эд үрэвсэхийг хэлнэ. Дэлхийн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болж байна. Хатгалгаа өвчин ихэвчлэн нянгийн гаралтай халдвараар үүсгэгддэг боловч, вирус, мөөгөнцрөөр үүсч бас болно. Дархлааны тогтолцоо нь суларсан хүүхэд хатгалгаа өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй байдаг. Хүүхдийн дархлаа нь хоол тэжээлийн дутал, улаан бурхан зэрэг халдварт өвчнөөр дахин давтан өвчилсний улмаас суларч болно. Мөн орчны зарим хүчин зүйл хүүхэд хатгалгаа өвчнөөр өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Тухайлбал, хатуу түлш болох мод, түлээ, аргал түлсний улмаас дотоод орчны агаар бохирдох, нэг дор хэт олуулаа амьдрах,

5 Манай оронд хүүхдийн зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх нэгдсэн удирдамжаар хангах эмч эмнэлгийн ажилчдад зориулсан Хүүхдийн өвчний цогц менежмент (ХӨЦМ), олон нийтийн ажилтан, асран хамгаалагч нарт зориулсан Олон нийтэд түшиглэсэн ХӨЦМ-ийн хөтөлбөр хэрэгжиж байна.

6 Ханиад шуухинаа гэж вирусийн халдвараар үүсгэгддэг томуу томуу төст өвчнийг хэлнэ.

тамхины утаанд байнга өртөх зэрэг хүчин зүйлс сөргөөр нөлөөлнө.

*2 сараас 5 хүртэл насны хүүхдийн амьсгалын замын өвчнийг гэртээ хэрхэн эмчлэх вэ?*

- Халуун, бүлээн шингэн байнга уулгах,
- Ханиалга дарах, хоолойн өвдөлт намдаах хоргүй, зөөлөн эмийг эмчийн заавраар өгнө. Үүнд: аньсны ханд, аньсны шүүс, читамон, чигатуссин гэх мэт.

Эхийн сүүгээр хооллож буй хүүхдэд хөхийг ойр ойрхон хөхүүлнэ. Харин антигрипп, демидрол зэрэг эмийг эмчийн зааваргүйгээр өгч болохгүй. Миксафлю, минигрип, терафлю зэрэг эм нь парацетамол агуулдаг тул Парацетамолтой давхар уулгаж болохгүй.



Эдгээр эмийг хүүхдэд хамгийн багадаа 6 цагийн зайтай уулгана. Хэрэв эмч хүүхдийг уушгины хатгалгаатай гэж оношилсон бол хоёр хоног гэрээр амоксациллинээр эмчлээд давтан үзүүлэх шаардлагатай. Харин уушгины хатгалгаагүй, ханиад, шуухинаа гэж гэрээр эмчлэгдэж буй хүүхдийн биеийн байдал сайжрахгүй, муудах, халуурах зэрэг нэмэлт шинжүүд гарвал эмчид яаралтай үзүүлнэ. Бага насны хүүхэдтэй бол гэртээ халууны шил байнга байлгана. Хэрэв хүүхэд халуурвал халууныг заавал хэмжинэ. Хүүхэд 38.5С хэмээс дээш халуурвал халуун буулгах эмийг зөвхөн эмчийн заавраар өгнө.

Хатгалгаагаар өвдсөн нялх хүүхэд хооллох, шингэн зүйл уух чадваргүй болж, ухаан алдах, биеийн халуун ихсэх, амьсгаадах, цээж хонхолзох, хоолондоо муудах зэрэг шинж илэрдэг. Эдгээр аюултай шинж илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад хандаж зөвлөгөө, тусламж авах шаардлагатай.

Яаралтай эмчид үзүүлэх:

- Уух буюу хөхөхдөө муудах
- Өвчин хүндэрвэл
- Халуурвал
- Амьсгал олширох
- Амьсгал саадтай бол
- Баас цустай бол

**СУУЛГАЛТ:** Бага насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийн түгээмэл шалтгааны нэг нь суулгалт юм. Хүүхдийн нас ба хоолны хэмжээнээс хамаарч өдөрт баах тоо хэвийн үед янз бүр байдагч сүүлийн 24 цагийн дотор гурав буюу түүнээс олон удаа усан, усархаг баахыг суулгалт гэнэ. Хэвийн тогтоцтой баасаар олон удаа баавал суулгалт биш. Мөн зөвхөн эхийн сүүгээр хооллодог хүүхдийн баас ихэвчлэн шингэвтэр байдаг нь суулгалт биш юм. Баасны тогтоц ба тоо хэвийнхээс өөрчлөгддөг тул хүүхдээ суулгахыг эхчүүд таньж чадна. Суулгалт хэрэв 14-өөс цөөн хоног үргэлжсэн бол цочмог суулгалт гэнэ. Цочмог усан суулгалт шингэн алдалтын шалтгаан болох ба тураалд хүргэдэг.

Суулгалтаар өвчилсөн хүүхэд биеийнхээ шингэнийг богино хугацаанд алддаг. Алдсан шингэнийг нөхөхгүй бол хүүхэд шингэний дутагдалд орно. Хэрэв хоол тэжээлийн дуталтай, дархлаа суларсан хүүхэд суулгалтаар өвчилбөл эндэх эрсдэл нь илүү өндөр байдаг. Суулгах бүрийд хүүхэд улам сульдаж, биеийн байдал нь доройтно. Мөн суулгалтын улмаас хүүхдэд хоол тэжээлийн дутал үүснэ. Суулгалтын үед алдагдсан шингэнийг богино хугацаанд нөхөх зорилгоор эцэг, эхчүүд хүүхдэдээ ердийнхөөс илүү их шингэн уулгах шаардлагатай. Энэ тохиолдолд шингэн сэлбэх давсны уусмал /хоросол/ өгнө. Мөн гэрийн нөхцөлд бэлдсэн давс чихрийн уусмалыг хүүхдэд өгч болно. Гэрийн нөхцөлд 1 литр буцалгасан усанд атга элсэн чихэр, тал цайны халбага давс уусгаж “хоросол” буюу давсны уусмал бэлдэнэ. Суулгасан хүүхдэд цайрын бэлдмэлийг тохиромжтой үед нь өгвөл хүүхэд илүү хурдан эдгэнэ. Эцэг эхчүүд өвчтэй хүүхдэд тэжээллэг хоол хүнс өгөх, хэрэв хүүхэд эхийн сүүгээр хооллодог бол хүссэн үед нь аль болох олон удаа хөхүүлнэ. Мөн хүүхдэд илрэх шингэн алдалтын шинж тэмдгийн талаар эмч, эрүүл мэндийн ажилтнаас асууж, зөвлөгөө авна.

Суулгалтыг гэрээр хэрхэн эмчлэх вэ? Хэрэв таны хүүхэд суулгалтаар өвдсөн бол гэрээр эмчлэхдээ дараах 4 зарчмыг баримтална. Үүнд:

1. Шингэнийг ердийнхөөс илүү их уулгана.
  - Хөхийг хүссэн үед нь ойр ойрхон, аль болох удаан хөхүүлнэ.
  - Хүүхэд зөвхөн эхийн сүүгээр хооллодог бол шингэн сэлбэх давсны уусмал (хоросол) болон цэвэр усыг нэмэлтээр өгнө.
  - Хүүхэд нэмэгдэл хоол иддэг бол дараах шингэнээс өгнө.

Үүнд: шингэн сэлбэх давсны уусмал, шингэлсэн усан шөл, будааны шүүс, тараг, хярам, буцалсан ус.

2. Ердийн үеийнхээс илүү их хэмжээгээр буюу нэмэлтээр шингэн өгнө.  
Үүнд:



- 2 хүртэлх насны хүүхдэд суулгалт бүрийн дараа буюу суулгалт хооронд 50-100 мл шингэн,
- 2 ба түүнээс дээш насны хүүхдэд суулгалт бүрийн дараа буюу суулгалт хооронд 100-200 мл шингэн өгнө.

*Шингэнийг уулгахдаа:*

- Аяга, халбагаар бага хэмжээгээр ойр, ойрхон уулгана.
  - Хэрэв хүүхэд бөөлжвөл 10 минут хүлээгээд аажим үргэлжлүүлэн өгнө.
  - Суулгалт зогсох хүртэл шингэнийг үргэлжлүүлэн уулгана.
3. Цайрын бэлдмэл өгнө (эмчийн зөвлөсөн тун, хэмжээгээр)
  4. Хүүхдийн хоолыг сойхгүй, шингэц сайтай хөнгөн хоолыг бага хэмжээгээр, ойр ойрхон өгнө.

**УЛААН БУРХАН** нь агаар дуслын замаар халдварладаг, вирусийн гаралтай цочмог халдварт өвчин юм. Дэлхийн бага насны хүүхдийн эндэгдлийн түгээмэл шалтгааны нэг нь улаан бурхан өвчин болж байна. Хоол тэжээлийн дуталтай, ялангуяа А аминдэмийн дуталд өртсөн, эсвэл бусад өвчин эмгэгийн улмаас дархлаа суларсан хүүхдийн улаан бурхан өвчний явц хүндрэх өндөр магадлалтай байдаг. Улаан бурхан өвчний халдвар дараах замаар дамжина. Үүнд:

- Ханиалгах, найтаалгах буюу агаар дуслын зам
- Биеэр хүрэлцэх буюу хавьтлын зам
- Халдвар бүхий нус, цэр буюу бохирлогдсон орчин

Улаан бурхан өвчнөөс дархлаажуулах аргаар сэргийлэх бүрэн боломжтой. Манай улс улаан бурхан өвчнөөс найдвартай хамгаалдаг, хүүхдэд аюулгүй вакциныг 40 гаруй жил ашиглаж байна. Энэ вакцин нь хямд өртөгтэй, гол төлөв улаанууд, гахай хавдрын эсрэг вакцинтай хавсарсан байдаг.

Улаан бурхнаар өвчилсөн тохиолдолд вирусийг бүрэн устгадаг эмчилгээ байхгүй тул зовуурийг багасгахад чиглэсэн, шинж тэмдгийн эмчилгээ хийдэг. Улаанбурханы үед нүд улайх буюу нуухтах, ханиах, хамраас нус гоожих, түгээмэл тууралт (нүүрнээс эхлэн бүх биеэр дээрээс доош чиглэсэн дараалалтай 1-3 хоногийн хугацаатай) гарна. Улаанбурханы үед А аминдэмийг насанд нь тохирсон тунгаар уулгана. А аминдэмийг 6 сараас эхлэн жилд 2 удаа товллын дагуу уулгадаг<sup>7</sup> тул өвчилсөн үед тунг ихдүүлэхгүй байхад анхаарна. Нүдний халдвартай бол тетрациклины тос түрхэх ба ам шархалсан бол генцианвтолетыг эмчийн заавраар хэрэглэнэ.

7 “Бага насны хүүхдийг А, Д амин дэмээр хангах зааврыг шинэчлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2013 оны 470 дугаар тушаал.

**НЯРАЙН ШАРЛАЛТ:** Дөнгөж төрсөн нярай хүүхдийн элэгний шүүх үйл ажиллагаа бүрэн хөгжөөгүй байдаг тул цусанд дахь билирубиныг бүрэн шүүж чаддаггүй тул цусанд байх хэвийн хэмжээнээс их болдог. Энэ нь хүүхдийн нүдний цөцгий, арьс, тагнай зэрэг газар шар туюатай болох шинжээр илэрдэг. Энэ шинжийг нярайн шарлалт гэнэ. Нярайн шарлалтыг хэвийн, эмгэг гэж 2 хуваана. Хэвийн шарлалт нь төрсний дараах 2-3 хоногт эхэлж, нярай эрүүл, асаргаа сайн бол 14 хоног дотор арилна. Тусгайлсан эмчилгээ шаардлагагүй, хөхийг сайн хөхүүлэх шаардлагатай. Эмгэг шарлалт нь төрсний дараах 24 цагийн дотор эхлэх ба 14 хоногоос удаан үргэлжлэх, гүн шарлах, биеийн ерөнхий байдал муу байх зэрэг шинжүүдээр илэрнэ. Эмгэг шарлалт нь дутуу төрөлт, ээжийн архаг өвчин, жирэмсний хүндрэл, эх эцгийн архи тамхины хэрэглээ - хорт зуршил, агаарын бохирдол зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална. Шарлалт гүнзгийрвэл тархи, мэдрэлийн тогтолцоог гэмтээдэг. Энэ нь хүүхэд унтаарах, хөхөндөө муу болох, шээс баас ховордох, шарлалт улам гүн болох шинжүүдээр илэрнэ. Зарим туршлагагүй ээж нар хүүхэд унтаж, тайван байна гэж андуурч алдаа гаргах нь бий. Эмгэг шарлалтыг эмчийн зааврын дагуу эмчилнэ. Үүнд:

- Дааруулахгүй байх,
- Сайн хөхүүлэх,
- Эмийн болон шарлага эмчилгээ хийнэ.
- Шалтгааныг тодруулж, тохирсон эмчилгээ хийнэ.

**ГАЛЗУУ ӨВЧИН** нь маш ховор тохиолддог ба нохой, муур, сарьсан багваахай зэрэг галзуу өвчнөөр өвчилсөн амьтанд хазуулах, маажуулахад хүнд халдварладаг, вирусийн гаралтай өвчин юм. Хүүхдүүдэд хэн нэгний тэжээвэр амьтан, гудамжны золбин нохой, муураас хол байх тухай хүүхдүүдэд анхааруулж ойлгуулах, галзуугийн эсрэг вакцин хийлгэх, өөрийнхөө тэжээвэр амьтныг эрүүл байлгах замаар галзуу өвчнөөс сэргийлэх бүрэн боломжтой. Галзуу өвчнийг эмчлэхгүй бол амь насанд аюултай. Хүүхдийг ямар нэг амьтан хазсан бол шархыг нэн даруй буюу 15 минутаас багагүй хугацаанд савандаж угаах эсвэл иодын уусмалаар ариутгаж, эмнэлэгт хүргэнэ. Галзуу өвчтэй байж болзошгүй амьтанд хазуулснаас хойш хэдэн цагийн дотор эмчилгээг эхэлбэл өвчин эдгэрэх бүрэн боломжтой. Галзуу өвчний халдвар авах эрсдэлтэй хүмүүс вакцин хийлгэж, сэргийлнэ. Галзуугийн эсрэг вакцин нь аюулгүй бөгөөд өвчнөөс найдвартай хамгаалж чадна.

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД.** Сэтгэцийн эмгэг хүний сэтгэн бодох, мэдрэх, аливаа үйлдэл хийхэд нөлөөлдөг. Хүүхдүүд насанд хүрэгчдийн адил

сэтгэцийн эмгэгтэй байж болно. Сэтгэцийн эмгэг нь удамшлын гаж хөгжил, бие махбодын бодисын солилцооны тэнцвэргүй байдал, төв мэдрэлийн тогтолцооны гэмтэлтэй холбоотой байх магадлалтай. Хүүхэд сэтгэцийн эмгэгтэй болох эрсдэлийг дараах хүчин зүйл нэмэгдүүлнэ. Үүнд:

- Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөх,
- Бухимдал, сэтгэл гутрал, ядуурал, үл хайхрах, ялгаварлан гадуурхах зэрэг хүчирхийлэлд өртөх,
- Хүүхдэд шууд нөлөөлж, урт хугацааны хямралд оруулахуйц улс төрийн болон байгалийн гамшиг
- Агаар, хөрсөнд шингэсэн хорт бодист байнга өртөх,
- Ойр дотны хүмүүсийн үхэл, хагацал гэх зэрэг.

**СЭТГЭЦИЙН ЭМГЭГ** нь өвчин мөн тул тохирох эмчилгээ шаарддаг. Хүүхдэд туслах, дэмжлэг үзүүлэхдээ сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн хүн байвал зохино. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ сайн ярилцаж, өөрийнхөө сэтгэл санааны байдлаа уран зураг, хөгжим, бүжиг зэрэг дүрслэх урлаг, тоглоомын хэлбэрээр илэрхийлэхийг дэмжиж болно. Энэ нь хүүхэд сэтгэцийн хямралаас гарахад туслах бөгөөд цаашид хүүхдийн хөгжилд учирч болзошгүй сөрөг үр нөлөөнөөс сэргийлнэ.

Хүүхдийг төрсөн цагаас нь хөгжил хэвийн байгаа эсэхийг эцэг эх асран хамгаалагч болон хүүхэдтэй харилцдаг бүх хүмүүс хянаж байх шаардлагатай. Үүнийг хэрэгжүүлэх олон аргууд бий. Тухайлбал: Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр<sup>8</sup> (ЭХЭМД)-т эх эцэг асран хамгаалагч нар өөрсдөө хүүхдийн өсөлт хөгжил хэвийн явагдаж байгаа эсэхийг хянах зааврууд бий. ЭХЭМД-ийн цэнхэр хуудсууд нь асран хамгаалагч нарт зориулсан. Түүнд байгаа мэдээллээр хүүхдийн хөгжил хэвийн байгаа эсэх, нүдний хараа, сонсгол, оюун ухааны хомсдол зэргийг эцэг, эх асран хамгаалагч нар илрүүлэх боломжтой. ЭХЭМД-ийн 20, 22, 24, 26, 28, 30, 32, 34, 36, 37, 39, 41, 43, 45, 47, 49, 51, 53, 55-р хуудсуудад буй асуултаар хүүхэд тухайн насандаа тохирсон үйлдлийг хийж чадаж буй байдлаар хөгжлийн түвшин хоцрогдолтой эсэхийг эх эцэг тодорхойлж чадна. Эргэлзээтэй бол мэргэжлийн эмчээс зөвлөгөө авна. Мөн хүүхдийг 18, 30 - 36 сартайд нь эрүүл мэндийн иж бүрэн үзлэгт хамруулж, илэрсэн хөгжлийн хоцрогдлыг арилгахад дэмжлэг үзүүлэхийг<sup>9</sup> эрх зүйн баримт бичгээр баталгаажуулсан.

8 Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн загвар Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 дугаар тушаал.

9 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны А/116, А/304/, А/197 дугаар тушаал.

**АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГ:** Дэлхийн хүн амын 1% нь аутизмтай, АНУ-д 68 төрөлт тутмын нэг нь аутизмтай бол мана оронд одоогоор 470 гаруй хүүхэд энэ эмгэгтэй нь оношлогдон хяналтанд байна.

Аутизм нь өвчин биш нийгмийн харилцаа, зан үйлийн эмгэг тул эдгэдэггүй бас халдварладаггүй. Аутизмтай хүүхдийн асаргаа хяналт сайн бол хэлд орж бусадтай харилцах үеэс буюу 6 сартай, 1 настайгаас таних боломжтой.

Аутизм байж болзошгүйг дараах шинжүүдээр танина:

- Дуу чимээнд хэт мэдрэг эсвэл сул,
- Нүдээрээ харилцаа тогтоохгүй,
- Нэрээр нь дуудахад хариу үйлдэл үзүүлэхгүй байх,
- Хэлд орохгүй буюу юм ярихгүй байх,
- Тоглоомоо зориулалтаас өөрөөр тоглох,
- Бусадтай харилцаанд орж чадахгүй байх,
- Нэгэн хэвшмэл болсон зүйлээ өөрчилж чадахгүй байх г.м

Аутизм нь эмгэг учир эдгэхгүй, эмийн эмчилгээгүй. Онош тогтоож, үнэлгээ<sup>10</sup> хийснээр хүүхдийн оюун ухааны хөгжлийн түвшин хэр байгаагаас шалтгаалж, хичээл сургалтанд хамруулан хөгжих боломжтой. Хүүхэд бүрийн онцлогт тохирсон зан үйл, харилцааны хөгжлийн сургалтад хамруулж, нийгэмших, хөгжихөд нь тусална.

## **ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ**

Дархлаажуулалтад хамруулах, эрүүл, аюулгүй орчинд тэжээллэг хоол хүнсээр зөв хооллох, эрүүл ахуйн зөв дадал, асаргаа халамж нь хүүхдийн эрүүл, эсэн мэнд амьдралын үндэс болно.

**ДАРХЛААЖУУЛАЛТ** нь олон өвчнөөс сэргийлж, өвчний явцыг нь хянах аюулгүй, өртөг багатай, баталгаатай арга юм. Бүх хүүхэд тухайн улс орны дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу дархлаажуулалтад бүрэн хамрагдах шаардлагатай. Тухайлбал, гепатит В, сахуу, хөхүүл ханиад, татран, саа, улаан бурхан, гахай хавдар, улаанууд, менингит, хоолойн халдварт өвчнөөс сэргийлэх, томуугийн эсрэг дархлаажуулалтад хамрагдана<sup>11</sup>.

10 Аутизмыг илрүүлэх Олон улсын DSM 4,5 сорилыг СЭМҮТ-д хийж, хүүхдийн оюун ухааны түвшинг тодорхойлж байна.

11 Манай улсын бага насны хүүхдэд зайлшгүй хийх шаардлагатай вакциныг “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэсэн байдаг тул та хүүхдийн товлолт дархлаажуулалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Түүнчлэн Монгол улс хатгалгаа өвчний эсрэг дархлаажуулалтыг 2017 оноос үе шаттайгаар нэвтрүүлсэн бөгөөд 2019 оноос 2, 4, 9 сартай бүх хүүхдийг дархлаажуулалтад хамруулж байна. Мөн амаар уух халдварт саагийн дархлаажуулалтыг тарилгат дархлаажуулалтад шилжүүлээд байна. Товлолд заасан бүх вакциныг заасан хугацаанд хийлгэж, дархлаажуулалтын ЭХЭМД-т тэмдэглүүлэх нь таны хүүхдийн ирээдүйд нэн чухал ач холбогдолтой. Вакцин хийлгэхэд хүүхэд тухайн үед бага зэрэг өвдөх, тавгүйтэх, заримдаа хэсэг хугацааны дараа халуурах шинж тэмдэг илэрдэг боловч, вакцины эерэг үр нөлөө нь түр зуурын өвдөлтөөс хавьгүй илүү байдаг. Хүүхдээ дархлаажуулалтад хамруулах асуудлаар эцэг, эх, асрамжлагчид сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ажилтантай уулзаж, үнэн зөв мэдээлэл, зөвлөгөө авах бүрэн боломжтой.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 185 дугаар тогтоолын хавсралтаар хүүхдэд заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг баталсан.

ХҮСНЭГТ 4. Дархлаажуулалтын үндэсний товллол											
Товлол	Төрсний дараа 24 цаг	2 сартайд	3 сартайд	4 сартайд	5 сартайд	9 сартайд	1 нас 2 сартайд (14 сар)	2 настайд (24 сар)	7 настайд	15 настайд	
Вакцины нэр											
Сүрьеэ (БЦЖ)	0 тун										
В вирус гепатит	0 тун										
Халдварт саа	0 тун	I тун	II тун	III тун	IV тун						
Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В вирус гепатит, В хэв шинжийн хемофилюс инфлюэнза нянгийн халдвар)		I тун	II тун	III тун							
Улаанбурхан, гахай хавдар, улаанууд						I тун		II тун			
Сахуу-татран									I тун	II тун	
А вирус гепатит							I тун	II тун			
Пневмококк		I тун		II тун		III тун					

**ЭРҮҮЛ АХУЙН ДАДАЛ.** Цэвэр, ариун цэвэрч байдлыг сахих нь олон тооны өвчнөөс сэргийлэхэд тустай. Гэр бүл, хамт олны хүрээнд хүүхдэд дараах дадал хэвшлийг төлөвшүүлэх шаардлагатай. Үүнд:

**ГАРАА САВАНДАЖ УГААХ.** Түгээмэл тохиолддог халдварт өвчний дийлэнх нь бохир гараар дамжин халдварладаг. Гараа савандаж угааснаар суулгалт

өвчний халдварыг хоёр дахин бууруулж, хатгалгаа зэрэг амьсгалын замын болон нүдний халдварт өвчин, бусад өвчинд өртөх эрсдэлийг үлэмж хэмжээгээр бууруулж чадна. Хоол идэхийн өмнө, мөн бие зассаны дараа гараа тогтмол угаах дадал эзэмшихэд нь хүүхдэд тусална.

#### *Дараах үйлдэл хийхийн өмнө гараа заавал угаах:*

- Хоол хүнсэнд хүрэх, хүүхдээ хооллох
- Хоолоо идэх
- Эм уулгах, шарханд хүрэх
- Өвчтэй эсвэл гэмтсэн хүнд хүрэх
- Дараах үйлдэл хийсний дараа гараа заавал угаах:
- Хоол хийх, ялангуяа түүхий мах, шувууны мах янзлах
- Бие засах
- Хүүхдийн баасыг цэвэрлэх, чивхийг солих
- Амьтанд хүрэх
- Нусаа нийх, гар алгандаа найтаах, ханиах
- Шарханд хүрэх, өвчтэй эсвэл гэмтсэн хүнд хүрэх
- Хогонд хүрэх

#### *Гараа угаахдаа:*

- Саван, эсвэл бусад төрлийн цэвэрлэх, ариутгах бодис тогтмол ашиглана.
- Гараа хооронд нь гурваас доошгүй удаа үрж угаах, ялангуяа хурууны завсар, хумсны доогуур сайтар цэвэрлэнэ.
- Гар дээрээ ус гоожуулж савангаа сайтар зайлна.
- Гараа цэвэр алчуураар арчих эсвэл хатаана.

#### *Цэвэр, баталгаатай ундны ус хэрэглэнэ.*

- Унданд хэрэглэх ус аюулгүй, цэвэр эсэхийг мэдэхгүй бол усаа буцалгаад шүүж хэрэглэх, эсвэл хлороор ариутгана.
- Усны сав суулгыг байнга таглаж, шороо тоос, элдэв шавьж бусад амьтан болон эд зүйл орж, ус бохирдохоос сэргийлнэ.
- Ус зөөх, хадгалах савны гадна ба дотор талыг байнга цэвэр байлгана.

#### *Хоол хүнсээ аюулгүй орчинд бэлдэж, хадгална.*

- Боловсруулаагүй түүхий хүнс, хүнсний ногоо, жимс, загасыг цэвэр усаар угаана.
- Мах, загасыг бүрэн гүйцэт болгоно.
- Бэлэн хоолыг идэхээс өмнө сайтар халаана.
- Хоол бэлддэг гадаргуу, хэрэгслийг саван/цэвэрлэх бодис, цэвэр усаар угаана.

- Хоол хүнсийг тагтай саванд хадгална.
- Аяга, таваг, хоолны хэрэгслийг саван/цэвэрлэх бодис ашиглан цэвэр усаар угаана.
- Хүүхдийн хоолны халбага, аяга, савыг буцалгаж ариутгана.

#### *Ахуйн хог, хаягдлыг хадгалах ба зайлуулах.*

- Хогоо тагтай саванд хийнэ.
- Гэр, гэрийнхээ эргэн тойрноос хогоо тогтмол зайлуулж, зориулалтын газар, зориулалтын саванд хаяна.

#### *Бие засахдаа ариун цэвэр сахих.*

- Гэрийн ойролцоох хөрс, усыг ялгадсаар бохирдуулахаас зайлсхийж, ил задгай бие засахгүй.
- Гэр бүлийн бүх гишүүд жорлонд, бага насны хүүхэд хөтөвчинд бие засаж хэвшинэ.
- Ялгадас, нялх хүүхдийн баасыг ч мөн адил хамгаалалттай, зориулалтын газар хаяна.
- Жорлон байхгүй бол ялгадсыг газарт булж, аюулгүй болгоно.

**АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНД.** Шүд буйлаа зөв арчлах нь эрүүл мэндэд тустай. Шүд цоорохоос сэргийлэх, амны хөндийн эрүүл ахуйн зөвлөгөө:

- Чихэрлэг хоол хүнс, ундаа хэрэглэхээс зайлсхийнэ.
- Нялх хүүхдийн шүдийг ургахаас өмнө буйлыг нь хуруундаа зөөлөн цэвэр даавуу ороож цэвэрлэнэ. Даавууг бага зэрэг давс эсвэл хүнсний сода уусмал, буцалгаж хөргөсөн усанд дүрж норгоод хүүхдийн буйлыг зөөлөн арчиж, цэвэрлэнэ.
- Хэрэв хүүхдийн шүд ургасан бол хоол идсэний дараа шүд, буйлыг нь зөөлөн үстэй, жижиг сойз, эсвэл нарийн модонд ороосон зөөлөн даавуу, алчуураар цэвэрлэнэ. Шүдний оог хүнсний сода, давсаар орлуулан хэрэглэж болно. Хүүхдийн буйлыг цэвэрлэхээ мартаж болохгүй.
- Хүүхэд том болоход шүдээ хэрхэн цэвэрлэхийг зааж өгнө. Хүүхдэд шүдээ тогтмол угаах дадал эзэмшүүлэхийн тулд түүнтэй хамт, зугаатай, сонирхолтой байдлаар шүдээ угааж хэвших нь хамгийн үр дүнтэй арга юм.
- Манай эцэг эхчүүд хүүхдийн уруул амыг үнсэж үнгэх, хүүхдээ хоолохдоо хоолыг нь амандаа зажилж жижиглэж өгдөг буруу зуршил байдаг. Хүн амын дунд стрептококкын гаралтай хоолой залгиурын үрэвсэл түгээмэл байхаас гадна, хүний амны хөндийд маш олон төрлийн нян агуулагдаж байдаг. Эдгээр нянгууд нь дээрхи зохисгүй үйлдлүүдийн үед хүүхдэд

халдварлан хоолой залгиурын архаг халдварт өвчтэй болох шалтаг болохыг анхаарах хэрэгтэй. Ахуйн хүрээний энэ халдварыг манайхан ээж аав нь хоолой өвддөг удмын өвчин гэж ташаа ойлгох нь ч бий.

**АГААРЫН БОХИРДОЛ:** ДЭМБ-аас мэдээлснээр жилд дэлхий дахинд гадаад орчны агаарын бохирдлын улмаас 3.0 сая хүн, дотоод орчны агаарын бохирдлын улмаас 4.3 сая хүн нас бардаг ажээ. Эдгээр нас баралтын хагас сая гаруй нь тав хүртэлх хүүхдийн эндэгдэл бөгөөд үүний 50-иас дээш хувь нь агаарын бохирдлоос үүдсэн уушигны хатгалгаа өвчнөөс шалтгаалдаг. Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдгийг ДЭМБ-аас хүлээн зөвшөөрч, 2013 онд хортой агаар нь хорт хавдар үүсгэгч болохыг зарласан.

Агаарын бохирдлыг гадаад болон дотоод агаарын бохирдол гэж ангилдаг. Гадаад агаарын бохирдол нь ердийн галлагаатай, нам даралтын зуухнаас гарч буй утаа тортог, автомашин, бусад өөрөө явагч хэрэгслийн дутуу шаталтын хий, барилга бүтээн байгуулалтын тоосноос шалтгаалдаг. Дотоод орчны агаарын бохирдол нь агааржуулалт муу байх, түүхий нүүрс, зориулалтын бус халаалтын хэрэгсэл хэрэглэх, бохир заваан байх гэр, сууцандаа тамхи татах, мөн гадаад орчны агаарын бохирдол нэвтрэх зэргээс үүдэлтэй.

Өвлийн улиралд манай орны төв суурин газруудад түүхий нүүрсний дутуу шаталт, барилгын болон үйлдвэр, замын тоос шороо, ил задгай үнс зэргээс үүсдэг нарийн ширхэгт тоосонцор буюу РМ 2.5-ийн агууламж агаарын чанарын стандарт хэмжээнээс 9-31 дахин их байдаг. Энэ нь бусад бохирдуулагчаас хүний эрүүл мэндэд хамгийн их сөргөөр нөлөөлж байна. Агаарын бохирдол нь зөвхөн амьсгалын замын өвчлөл бус зүрх судас, мэдрэлийн тогтолцоо, нөхөн үржихүйн тогтолцооны эмгэг үүсгэх эрсдэлтэй ба амьсгалын замын өвчлөлийн 52.9%, зүрх судасны өвчлөлийн 20%, уушгины хавдрын 40%, хүүхдийн амьсгалын замын өвчлөлийн 24.1%-ийн шалтгаан болдог төдийгүй өвлийн улиралд үргийн гаж хөгжил, зулбалт 3.6 дахин их, үргийн хэмжээ 80 гр-аар бага байх эмгэг байгааг тодорхойлсон байна.

Дотоод орчны агаарын бохирдлын нэг хэсэг бол хүүхдэд хүрэлцээтэй агаар байгаа эсэх асуудал ордог. Манай эцэг эхчүүд хүүхэдтэйгээ нэг оронд унтахыг хэвийн зүйл гэжсэн уламжлалт ойлголттой байдаг. Эх нь хүүхдээ өвөртөлж унтах нь хүүхдийг хайр энэрлээр дутаахгүйгээс гадна хүүхэд бусдын хайрыг мэдрэх, бусдыг хайрлах сэтгэлээр хүмүүжихийн үндэс болдог хэдий ч зай багатай, хүүхдэд оногдох талбай багатай бол хүүхэдтэйгээ нэг оронд унтах нь хүүхдийг агааргүйдэхэд хүргэдэг.



### Агаарын бохирдлоос хэрхэн хамгаалах вэ?

Айл өрх гэр доторхи агаарын бохирдлыг арилгах, бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авах шаардлагатай:

- Гэр, байшингаа эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй болгох, түүхий нүүрс түлэхгүй, зайлшгүй хрэглэх шаардлагатай бол галлагааны өрөө нь бусад өрөөнөөс тусдаа байх, сайжруулсан түлш, зуух хэрэглэх, гэртээ тамхи татахгүй байх, гадаа бохирдол ихтэй үед хаалга, цонхоо онгойлгохгүй байх, зориулалтын бус түлш ашиглахгүй байх (автомашин дугуй, хуванцар сав зэрэг хорт хий ялгаруулдаг зүйлсийг гэртээ шатааж түлэхгүй байх),
- Агаар шүүгчийг хэрэглэх,
- Гэрээ цэвэр байлгаж, чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийх нь дотоод агаарын чанарыг сайжруулах нөхцөл болно.

**ХҮҮХДИЙН ОСОЛ ГЭМТЭЛ:** Сүүлийн жилүүдэд осол гэмтэл нь хүүхдийн өвчлөл, эндэгдлийн тэргүүлэх шалтгааны нэг болж байна. Хүүхдийн осол гэмтэлд ахуйн осол голлох байрыг эзэлж байна. Үүнд: Түлэгдэлт (халуун тогоо, зуух, буцалсан ус г.м), бэртэлт (орны араар унах, хөхөндөө дарагдах, явганаас унах), авто осол, жорлон, муу усны нүх, хашаанд үхсэн нүхэнд унах, гол усанд живэх г.м.

*Хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх:* Эцэг, эх асран хамгаалагч нарыг ахуйн ослын талаар мэдлэгжүүлж, эрсдэлийг тооцон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах чадвартай байх. Үүнд:

- Зуух, галын эргэн тойронд хаалт тавих,
- Аюул учруулж болох зүйлийг (хурц үзүүртэй хутга мэс, эм цэвэрлэгээний бодис, шавьжны хор, оеросин г.см) түгжээтэй газар хийх буюу бага насны хүүхэд хүрч чадахгүй газар тавих,
- Муу усны нүхийг таглах, жорлонг цоожтой болгох,
- Хүүхдийн тоглоомын талбайг хашилттай, цэвэр байлгах г.м.

**ХҮҮХДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗӨВ ДАДАЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ.** Эцэг эхчүүд хүүхдэдээ гараа угаах гэх мэт эерэг дадлыг аль болох эрт, бага наснаас эзэмшүүлнэ. Нялх, бага наснаас эхлээд ямар нэг зүйлийг хүүхэдтэйгээ хамт хийх, томрох тутам хүүхэд өөрөө бие даан хийхийг урамшуулан дэмжих хэрэгтэй. Эцэг эхчүүд, асрамжлагч нь өөрсдөө үлгэр дуурайл болохыг хичээнэ. Хүүхдийн орчинд байгаа насанд хүрэгчид, асрамжлагчид нь эерэг дадлыг хэрэгжүүлэхгүй байвал хүүхэд уг дадлыг эзэмших магадлал эрс буурдаг. Хүүхдийг насанд хүрэгчдийн хяналт, дэмжлэгээр ургамал, цэцэрлэг арчлах,

хоол хийхэд оролцуулна. Мөн хүүхдэд ургамал, ногооны жижиг талбайг хариуцуулж болно. Ингэснээр хүүхэдтэй ярилцах, харилцаагаа бэхжүүлэх боломж нэмэгдэнэ. Эрүүл мэнд, аюулгүй байдал, зөв хооллолтын тухай дуу, шүлэг зохиох, тоглоом тоглох нь хүүхэд зугаатай, баяр баясгалантай аргаар суралцах, мэдлэг эзэмшихэд тусална. Таны хүүхдэд мэддэг дуу шүлэг байдаг бол түүнийг нь хамтдаа дуулж болно. Хэрэв байхгүй бол мэддэг дууныхаа аян дээр дуулж болно<sup>12</sup>.

*Идэвхтэй хөдөлгөөн, дасгалын талаарх ДЭМБ-ын зөвлөмж.* Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжилд аль болох богино хугацаанд хөдөлгөөнгүй сууж, харин илүү их хугацаагаар идэвхтэй, хөдөлгөөнтэй тоглох нь чухал ач холбогдолтой байдаг. ДЭМБ-аас 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл өсөлт, хөгжилд тэдний дэлгэц ширтэж хөдөлгөөнгүй суух, хүүхдийн тэрэг, зориулалтын суудалд суулгах хугацаа нь аль болох богино, харин хангалттай унтаж амрах, идэвхтэй хөдлөх, тоглох цаг нь аль болох урт байхыг заасан.

Хэрэв хүүхдэд бага наснаас эхлэн идэвхтэй хөдөлгөөнийг эрхэмлэх, хязгаартай цагт дэлгэц ширтэж, хөдөлгөөнгүй суудаг, хангалттай сайн унтаж амардаг эрүүл зан үйлийг төлөвшүүлж чадвал энэхүү дадал нь цаашид хүүхэд нас, өсвөр нас, насанд хүрсэн хойно ч хадгалагдан үлддэг байна.

### *Зөвлөмж (нэг хүртэлх нас)*

Өдөрт нилээд хэдэн цаг төрөл бүрийн (мөлхөх, цогих, алхах гэх мэт) идэвхтэй хөдөлгөөн хийнэ. Мөлхөж, сууж сураагүй хүүхдийг өдөрт хамгийн багадаа “30 минут” түрүүлгэ нь харуулж хэвтүүлнэ.

Хүүхдийг хязгаарлагдмал байрлал (хүүхдийн тэрэг, өндөр сандал дээр суулгах, үүрэх гэх мэт)-д байлгах хугацаа 1 цагаас хэтрэхгүй,

Телевиз үзэх, гар утас, компьютер тоглох буюу дэлгэц ширтэхийг зөвлөхгүй. Хүүхдийг суулгаж байхдаа ном уншиж өгөх, үлгэр ярих, тоглохыг зөвлөнө.

Унтах хугацаа:

0 – 3 сартай хүүхэд 14 – 17 цаг

4 – 11 сартай хүүхэд 12 – 16 цаг

### *Зөвлөмж (12 – 35 сар)*

Өдөрт хамгийн багадаа 180 минут байх ба энэ хугацаанд төрөл бүрийн (дунд зэргийн болон өндөр эрчимтэй хөдөлгөөн) идэвхтэй хөдөлгөөн хийнэ.

12 “Гараа угаана даа”, “Хорхой, Цоорхой хоёр” хүүхдийн дууны аяыг “Соосой” хүүхдийн цуврал видео хичээлээс мөн [www.youtube.com](http://www.youtube.com)- сайтас дууны нэрээр нь хайлт хийн үзэх боломжтой.

Хүүхдийг хязгаарлагдмал байрлал (хүүхдийн тэрэг, өндөр сандал дээр суулгах, үүрэх, эсвэл удаан хугацаагаар суулгах гэх мэт)-д байлгах хугацаа 1 цагаас хэтрэхгүй, Нэг настай хүүхдэд телевиз үзэх, гар утас, компьютер тоглох буюу дэлгэц ширтэхийг зөвлөхгүй. Хүүхдийг суулгаж байхдаа ном уншиж өгөх, үлгэр ярих, тоглохыг хичээнэ.

Хоёр настай хүүхдийн телевиз үзэх, гар утас, компьютер тоглох буюу дэлгэц ширтэх хугацаа нь аль болох богино, цагаас хэтрэхгүй байна.

Унтах хугацаа: 11 – 14 цаг

### *Зөвлөмж (36 – 59 сар)*

Өдөрт хамгийн багадаа 180 минут байх ба энэ хугацаанд төрөл бүрийн (дунд зэргийн болон өндөр эрчимтэй хөдөлгөөн) идэвхтэй хөдөлгөөн хийнэ. Өдөрт хамгийн багадаа “60 минут” дунд ба өндөр эрчимтэй хөдөлгөөн хийхийг урамшуулна.

Хүүхдийг хязгаарлагдмал байрлал (хүүхдийн тэрэг, өндөр сандал дээр суулгах, үүрэх, эсвэл удаан хугацаагаар суулгах гэх мэт)-д байлгах хугацаа аль болох богино, 1 цагаас хэтрэхгүй байна. Хүүхдийг суулгаж байхдаа ном уншиж өгөх, үлгэр ярих, тоглохыг хичээнэ.

Телевиз үзэх, гар утас, компьютер тоглох буюу дэлгэц ширтэх хугацаа нь 1 цагаас хэтрэхгүй байна.

Унтах хугацаа: 10 – 13 цаг

### *Зөвлөмж (5 – 19 нас)*

Өдөрт хамгийн багадаа 60 минут байх ба түүнээс дээш хугацаагаар дунд ба өндөр эрчимтэй хөдөлгөөн хийнэ.

Биеийн тамирын хичээл, дунд ба өндөр эрчимтэй дасгал хөдөлгөөнийг 7 хоногт 3-аас доошгүй удаа хийнэ.

### *Дүгнэлт*

- Хоол тэжээл хүүхдийн тархины хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ.
- Бага насанд хүндрэх эрсдэлтэй өвчнөөс дархлаажуулалт болон эрүүл мэндийн дадлын тусламжтайгаар урьдчилан сэргийлж чадна.

### *Өөрийгөө шалгах асуулт*

- Таны амьдарч буй орон нутагт нялх, бага насны хүүхдүүд ямар өвчнөөр хамгийн их өвчилж байна вэ?
- Хүүхдийн эрүүл мэндийн ямар асуудал хамгийн их тулгамдаж байна вэ?



## СЭДЭВ 4

### БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА, ХАЛАМЖ

Бага насны хүүхдийг асарч халамжлах нь хүүхдийн хөдөлгөөн, дуу авиа, дохио зангаа, үг хэллэгийг ажиглаж, ойлгож, нийцтэй хариу үйлдэл үзүүлэхээс эхэлнэ.

Бага насны хүүхдийг асарч, халамжлах нь:

- Хүүхдийг аюул ослоос урьдчилан сэргийлэн хамгаалж, сөрөг үр дагаврыг зогсоох;
- Хүүхэд өвчилсөн эсэхийг мэдэх, өвдсөн тохиолдолд асрах;
- Хүүхдийн танин мэдэх, сурах чадварыг дэмжих;
- Хүүхдэд итгэл бий болох, хүүхэд нийгмийн харилцаанд оролцох зэрэгт ач тустай.

Бага насны хүүхдийн асаргаа, халамжид хүүхдийн эрүүл хооллолт чухал байр суурь эзэлдэг. Ялангуяа хүүхэд бага жинтэй байх, эсвэл өвдсөн үед хооллолт нэн чухал байдаг.

Эцэг эх хүүхдээ ярьж эхлэхээс өмнө энгэртээ тэврэх (арьсаар шүргэлцэх) нүдээрээ харилцах, инээх, хүүхэд ганганан гунганах дуу авиа, нүүрний хөдөлгөөнд хариу үйлдэл үзүүлэх зэргээр тэдэнтэй харилцаж, ойлголцдог. Хүүхэд эхийн хэвлийд бүрэлдэх үеэс эцэг эх, хүүхэдтэйгээ харилцаж, ойлголцох нь хожмоо юугаар ч орлуулшгүй сэтгэлийн нарийн нандин холбоосыг бий болгодог. Улмаар энэхүү нарийн харилцаа, холбоос бага насны хүүхдийн тархины хөгжлийг дэмжих нэг чухал хүчин зүйл болдог.

## ЗУРАГЛАЛ 6. Насанд хүрэгч, хүүхдийн харилцаа



Эх сурвалж: Home natural cures.

<https://www.homenaturalcures.com/brain-development-stages/>

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА, ХАЛАМЖИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙ

Шинэ төрсөн хүүхэд амьдралын эхний саруудад юу хүсэж, юу хэрэгтэй байгаагаа таньж мэдэх нь хязгаарлагдмал төдийгүй олон талаар насанд хүрэгчид, асран хамгаалагчдаас хараат байдаг. Энэ байдал нь хөгжлийн явцад удаан үргэлжлэхгүй хэдий ч 5 хүртэлх насанд эрүүл хооллох, аюулгүй байдлаа хангаж хамгаалах, бусадтай харилцах, нийгмийн амьдралд оролцох, шинийг таньж мэдэх, туршлага хуримтлуулах, сэтгэл хөдлөлөө удирдах зэрэгт тэдэнд эцэг эх, асран хамгаалагчийн тусламж, дэмжлэг нэн чухал байсаар байх болно.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ юу хүсэж, нөхцөл байдал нь ямар байгааг сайтар ойлгож, хялбар таньж мэддэг хэдий ч хэрхэн хариу үйлдэл үзүүлэх вэ гэдэгт тулгамдах, хэн нэгнээс тусламж дэмжлэг авах хэрэгцээ үүсэж байдаг. Судалгаанаас үзвэл, эцэг эх хүүхдийн “сайн” харилцааны эх үндэс нь “бяцхан” харилцагчаа таних, ойлгохоос эхтэй төдийгүй энэ нь хүүхдийн болон нийгмийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг ажээ<sup>13</sup>.

Хүүхдээ сайтар ойлгож, харилцдаг, халамжилдаг эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ хүсэл, хэрэгцээнд нийцсэн хариу үйлдэл, арга хэмжээг байнга авдаг. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ анхаарал, халамж сайн тавьдаг, хүүхдээ хайрладаг, хүүхдийнхээ юу хүсэж байгаад мэдрэмжтэй ханддаг бол тухайн хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн хөгжлийг дэмжих бөгөөд

13 Казүо Мияаки, 1984, Нийгэм, сэтгэл зүйн хөгжлийн асуудлууд, Хокайда Их сургууль, Япон

эцэг эх, хүүхдийн хооронд тогтвортой харилцаа бий болж, хүүхэд сурч боловсроход тусалдаг<sup>14</sup> байна.

Бага насны хүүхдийн асаргаа, халамжийг сайжруулахын тулд:

- Эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдээ хэрхэн асаргаа, халамжид ажиглалт хийж, хэрхэн сайжруулах талаар зөвлөх, туслах, дэмжих;
- Эцэг эх, асран хамгаалагчийг урамшуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зарчмаар тэдэнд итгэл төрүүлж хүүхэдтэйгээ дотно сайн харилцах, ярилцах, тоглох, хийх хялбар, энгийн зүйлсийг санал болгох;
- эцэг эх, хүүхдийн харилцааны хүрээг өргөжүүлэх, чанарыг сайжруулах тоглоом, үйл ажиллагааг зөвлөх;
- Эцэг эхийн хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цагийг нэмэгдүүлэх зэргийг санал болгож, зөвлөж болно.

Эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, хүүхэд хамгаалал болон гэр бүлд нийгмийн үйлчилгээ үзүүлж буй бусад салбарын мэргэжилтнүүдэд санал зөвлөмж өгөх замаар тэдний бага насны хүүхдийн асаргаа, халамжийг сайжруулах мэдлэг, туршлагыг өргөжүүлэх боломжтой.

## АСАРГАА ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ БА ҮЙЛЧИЛГЭЭ

5 хүртэлх насны хүүхдийн асаргаа, халамжийг сайжруулахын тулд гэр бүлд дараах зан үйлийг хэвшүүлнэ. Үүнд:

- Хүүхдийг дөнгөж төрсний дараа ээжтэй нь арьс, арьсаар шүргэлцүүлэх
- Жин багатай төрсөн хүүхдэд “имж” асаргааг таниулах, хэвшүүлэх
- Ээж, дөнгөж төрсөн нярайг хамт байлгах
- Хүүхдийг хүссэн үед нь хооллох
- Эцэг эх, асран хамгаалагчийг хүүхэдтэй тоглох, харилцахыг дэмжих
- Эцэг эх, асран хамгаалагчийг хүүхдийн хүсэл, хэрэгцээг соргоогоор мэдэрч хариу үйлдэл үзүүлэхийг дэмжих
- Эцэг эх, асран хамгаалагч нарт сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх



14 М. Томлинсон, П. Күүпер, Л. Мурай, Эх-нярайн харилцаа, нярайн хамаарал Өмнөд Африкийн хотын захад, Хүүхдийн Хөгжил, 2005

- Өвөө эмээ болон гэр бүлийн бусад гишүүдийг хүүхдийн асаргаа халамжийн үйл явцад оролцуулах зэрэг болно.

### 20 секундийн тэврэлт (зөвлөмж)

- 2-5 насны хүүхдэд халамж хайрыг мэдрэх, тайвшрах хамгийн энгийн боловч гайхамшигтай арга бол аав ээжийн тэврэлт юм. Аав ээж хүүхдээ 20 секундийн хугацаанд тэврэхэд цусны даралт буурч, биеийн дархлаа идэвхжиж, хайрын гормон буюу окситоцины хэмжээ нэмэгддэг.
- Аав ээжийн тэврэлт нь хүүхдийн эрүүл мэндийн болон сэтгэл зүйн дархлааг дэмждэг. Аав ээждээ хангалттай тэврүүлдэг, хоногийн ихэнх цагийг аав ээжтэйгээ хамтдаа өнгөрүүлдэг хүүхдийн өвчлөх нь бага, сэтгэлийн хөдөлгөөн нь тогтвортой бас эерэг байдаг.
- Аав ээжийн тэврэлт хүүхдийн тархины хөгжлийг дэмжинэ. Аав ээжийнхээ энгэрт тэврүүлдэг хүүхэд асуудлыг бухимдлаар бус эвээр шийддэг, бусдад өөрийгөө ойлгуулах, бусдыг ойлгох чадвартай, шинийг таньж мэдэх хүсэл тэмүүлэлтэй, хэл ярианы хөгжил сайтай, илүү идэвхтэй байдаг.

Та хүү охиноо 20 секундийн хугацаанд чин сэтгэлээсээ тэвэрч туршаарай. Та амар амгалан, хайр, аз жаргал, хөгжлийн өөрчлөлтийг мэдрэх болно.

### Дүгнэлт

- Эцэг эх, асран хамгаалагчийн асаргаа халамж нь хүүхдийн сэтгэл санааг тайвшруулах, хүүхэд өөрийгөө таньж мэдэх, өөрийгөө зохистой илэрхийлэх, нийгэмшихэд нь туслах улмаар орчноо танин мэдэх, хөгжиж боловсрох, нийгмийн амьдралд оролцоход чухал ач холбогдолтой.
- Эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүд эцэг эх, асран хамгаалагчдад дэмжих үйлчилгээ үзүүлэхдээ тэдний хүүхэдтэйгээ хэрхэн харилцаж байгааг ажиглаж, хүүхдэдээ сайтар асран халамжлахын ач холбогдлыг таниулан сурталчлах нь хүүхэд, гэр бүлийн болон нийгмийн хөгжилд нэн тустай.

### Өөрийгөө шалгах асуулт

- Яагаад бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжихэд асаргаа ба халамж чухал байдаг вэ?
- Бага насны хүүхдийн асаргаа, халамж хэзээ, юунаас эхлэх вэ?



## СЭДЭВ 5

### БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХАМГААЛАЛ

#### НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдийн эдлэх эрхүүдийг тунхагласан олон улсын эрх зүйн баримт бичиг юм. Уг баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 оны 11 дүгээр сарын 20-нд баталснаас хойш 193 орон нэгдэн ороод байна. Монгол Улс тус конвенцид 1990 онд нэгдэн орсон.



Монгол улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон эхний 10 улсын нэг бөгөөд ингэснээрээ уг конвенцийн бүх заалтууд, ялангуяа хүүхэд бүрийн эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхүүдтэй салшгүй холбоотой эрхүүдийг хангах үүргийг НҮБ-ын өмнө болон бусад гишүүн орнуудын өмнө хүлээн зөвшөөрсөн. Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасан хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сэргөөр ашиглах, хайрлахгүй байх, үл хайхрах, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх, бэлгийн хүчирхийлэл дарамтад оруулах зэргийг олон улсын практикт хүүхэдтэй зүй бусаар харилцах явдал гэж авч үздэг.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн тогтоосон олон улсын эрхзүйн хэм хэмжээний дагуу хүүхэд бүр ямар ч алагчлалгүйгээр хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ хүртэж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж, бие хүн болж төлөвших, авьяас, чадвараа бүрэн дүүрэн нээн хөгжүүлэх боломжоор хангагдаж, аз жаргал, хайр энэрэл, ойлголцол



бүрдсэн орчинд өсөн торниж, өөрсдийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байж, эрхээ эдлэх үйл явцдаа идэвхтэй оролцох боломжоор хангагдах зэрэг нөхцөлийг бүрдүүлэх үүргийг конвенцын гишүүн орнууд хүлээсэн.

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь дараах 4 үндсэн зарчимд тулгуурладаг. Үүнд:

- Хүүхэд эсэн мэнд амьдрах ба хөгжих
- Үл ялгаварлах
- Оролцох
- Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах

Түүнчлэн дараах хоёр үндсэн зарчимд тулгуурласан нийгмийн зөвшилцлийн гэрээ бий. Үүнд:

- Хүүхэд бол идэвхтэй эрхийн субъект
- Хүүхдийн эрхийг бүрэн хангахад шаардлагатай бүхий л нөхцөлийг бий болгох үүргийг конвенцод нэгдсэн улс орнуудын засгийн газар нь бусдад шилжүүлэхгүйгээр хүлээх ёстой (Хүүхдийг ивээх сан, 2009).

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 2-р зүйлд *Оролцогч улсууд нь энэхүү конвенцод заасан эрхүүдийг хүүхэд бүрийн хувьд ямар нэгэн ялгаварлан гадуурхалгүйгээр, эцэг эх эсвэл асран хамгаалагчийн нь угсаа, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төр болон бусад үзэл бодол, үндэстний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрөлхийн болон бусад байр сууриас хамааралгүйгээр хууль эрх зүйн хүрээнд хүндэтгэн үзэж баталгаажуулна* хэмээн заасан.

Мөн уг конвенцод заасан бүх эрх бүх хүүхдэд нэгэн адил үйлчлэх тухай тодруулсан.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод *Хүүхэд гэж төрсөн цагаас эхлэн 18 хүртэлх насны бүх охид, хөвгүүдийг хэлнэ* хэмээн заасан.

Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль (2016)-д Хүүхэд гэх хүн амын насны бүлгийг, "... иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүн ... (3.3) гэж тодруулсан.

Олон улсын гэрээ конвенц болон Монгол Улсын холбогдох хуульд хүүхэд насыг 18 насаар хязгаарласан нь нэг талаас бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүйн хөгжил төлөвшлийг тооцон харгалзсан, нөгөө талаас хүн өөрийн хийсэн үйлдэлдээ ёс зүйн хувьд хариуцлага хүлээх болсон насанд хүрэх үе бол 18 хэмээн үзэж байгаатай холбоотой.

*Бага насанд хэнийг хамруулж болох вэ?* Монгол Улсын эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагчид олон улсын болон өөрийн оронд хийсэн судалгаа, баримт нотолгоо зэргийг үндэслэн ургийн хөгжлийн үеэс 6 хүртэлх насыг бага нас хэмээн тодруулж байна. Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын баримт бичигт 6 хүртэлх насныхны хөгжил, боловсролын асуудлыг “хүний хөгжлийн үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээр хөгжих, амьдрал боловсролын суурь үе” (3 дугаар бүлэг) хэмээн тодруулсан.

*Хүүхдийн эрх гэдэг нь* хуульчлагдсан боломж юм. Нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагдах тул өөр хэн нэгний эрхэд халдахгүйн тулд бусдын эрхийн талаар ойлголттой байх ёстой. Өөрийн эрхийг ойлгох нь бусдын эрхэд хүндэтгэлтэй хандах үндэс суурь юм. Өөрийн эрх ба бусдын эрхийг хамгаалан хангах нь салшгүй холбоотой гэдгийг бага наснаас нь хүүхдэд ойлгуулах нь өнөөгийн хүн төвтэй нийгмийн тэргүүлэгч зорилтуудын нэг юм.

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)-д зааснаар хүүхэд бүр дараах 4 бүлэг эрхийг эдлэх ёстой. Үүнд: эсэн мэнд амьдрах (5 дугаар зүйл), хөгжих (6 дугаар зүйл), хамгаалуулах (7 дугаар зүйл), оролцох (8 дугаар зүйл) гэсэн бүлэг эрх орох бөгөөд эдгээр нь өөр хоорондоо салшгүй холбоотой юм. Хүүхэд хоол үндтай, өлсөх, даарах зовлонгүй, айх аюулгүй, хүндлэл хайраар дүүрэн аж төрөх нь түүний төрөлх хэрэгцээ юм. Хэрвээ хүүхдийн аль нэг эрх нь зөрчигдвөл бусад эрхэд нөлөөлдөг. Тухайлбал, хүүхдийн эсэн мэнд амьдрах нь хөгжих эрхтэй нягт холбоотой төдийгүй улмаар хүүхэд боловсрол эзэмших, оролцох эрх нь хангагдах суурь болдог.

Цэцэрлэг нь хүүхдийн нас бие, сэтгэл зүйн хөгжлийн онцлогт нийцсэн агуулга, арга зүйгээр хүүхдэд тэдний эдлэх эрхийн талаар таниулж ойлгуулснаар нийгэмд хүүхдийн эрхэд хүндэтгэлтэй хандах үзлийг түгээн төлөвшүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэнэ.

Хүүхдийн эрхийг ханган хэрэгжүүлэх үйл явцад хүүхэд өөрөө ямар эрхтэй гэдгээ мэддэг байх нь нэн чухал. Хүүхэд өөрийн эдлэх эрхийн талаар ойлголт, мэдлэгтэй болсноор амьдарч буй нийгмээ ойлгож, дасан зохицох, бусдын болон нийгмийн сайн сайхны төлөө аливаа үйлсэд идэвхтэй оролцогч болон өсөж хөгжих нөхцөл болно.

Аливаа хүн бага наснаасаа өөрийгөө зохистой илэрхийлэх, бусдын ялгаатай байдал (нас, хүйсийн баримжаа, үндэс угсаа, хэл яриа, зан заншил, санаа бодол, ур чадвар болон хөгжлийн бэрхшээлтэй байх зэрэг)-ыг хүндэтгэн

сонсох, харилцах нь эрхээ эдлэх, үүргээ хүлээх аажмаар бусдын эрхийг хүндэтгэн зөв амьдарч, амжилттай сурч хөгжихийн суурь болно. Учир нь хүмүүс хоорондын амжилттай харилцаа нь харилцан ойлголцол, хайр хүндлэл дээр суурилдаг.

Эрдэмтдийн судалж нотолсноор хүүхэд 4-5 настайдаа өөрийн хүйсээ таньж, ойлгож өөрийгөө бусдаас өөр, ялгаатай гэдгээ мэдэрч өөрийн үйлдлээ бусадтай харьцуулан, өөрийгөө үнэлж эхэлдэг.

## ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

*Хүчирхийлэл гэдэг нь аливаа хүн зорилгодоо хүрэхийн тулд хэн нэгнийг албадах, эрх мэдэл, сүр хүчээр далайлгах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхийг завдсанаар уг хүнд бие махбод, сэтгэл санааны болон эдийн засгийн хохирол учруулсан буюу завшихыг хэлнэ. Ямар үйлдлийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж тооцох нь тухайн ард түмний хамааран янз бүр байдаг ч олон улсын хэмжээнд ямар үйлдлийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж тооцох вэ гэдгийг тодорхойлох гэсэн оролдлогууд олонтаа хийгдэж байна.*

Үүний нэг нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц бөгөөд түүний 19-р зүйлд зааснаар ... *гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харилцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэр хэмээн тодорхойлжээ.*

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь 18-аас доош насны хүний эсрэг, санаатай эсхүл санамсаргүйгээр амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг (Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016) хэлнэ.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хүмүүс хоорондын хүчирхийллийн 6 үндсэн төрлийг өөртөө багтаадаг бөгөөд хүүхдийн хөгжлийн янз бүрийн шатанд өөр өөрөөр илэрдэг байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь ихэвчлэн нуугдмал, хүний нүднээс далд, мэдэгдэхгүй болж өнгөрдөг.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь сэтгэл зүйн хохирол амсах, эрт бэлгийн харилцаанд орох, сэтгэл зүйн дарамтад байх, ой тогтоолт нь буурах, эмх цэгцээ алдах, хий юм үзэх, түрэмгий зан авиртай болох, хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх, уушиг, зүрх, элэг өвчлөх, бэлгийн замаар дамждаг өвчин халдварлах, үр зулбах гэх мэт урт удаан хугацаанд үргэлжлэх маш сөрөг үр дагаваруудтай.

*Зүй бус харилцаа* (үүнд хэрцгий шийтгэл багтана) гэдэгт нярай хүүхэд, бага болон өсвөр насны хүүхдийн эсрэг эцэг эх, асран хамгаалагч болон эрх бүхий албан тушаалтан, ихэвчлэн гэрийн нөхцөлд, заримдаа сургууль болон асрамжийн газар гэх мэт байгууллага дээр үйлддэг бие махбод, бэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл санааны хүчирхийлэл, үл хайхрах явдал багтана.

*Дээрэлхэлт* (үүнд цахим дээрэлхэлт багтана) гэдэг нь хохирогчтой ах дүүгийн болон хайр сэтгэлийн холбоогүй хүүхэд эсвэл хэсэг бүлэг хүүхэд тухайн хүүхдийн эсрэг түрэмгий зан үйлдэл гаргахыг хэлнэ. Үүнээс үүдэн хүүхдийн бие махбод, сэтгэл зүй болон нийгэмд хохирол учрах бөгөөд ихэнхдээ сургуулийн орчин болон хүүхэд олноор цуглардаг бусад газарт тохиолддог. Мөн цахим орчинд гардаг.

*Өсвөр үе, залуучуудын дундах хүчирхийлэл гэдэг нь* 10-29 насны хүүхэд залуучуудад илүү тохиолдох ба танилууд болон танихгүй хүүхдүүдийн хооронд олон нийтийн газарт болдог. Зэвсэгтэй (хутга, буу) болон зэвсэггүй халдлага зэргийг өөртөө багтаах бөгөөд танхайчуудын бүлгийн хүчирхийлэл үүнд багтаж болно.

*Дотно харилцаатай хамтрагчийн хүчирхийлэл* (гэр бүлийн хүчирхийлэл) гэдэг нь дотно харилцаанд байгаа болон байсан хамтрагчийн үйлдсэн хүчирхийлэл юм. Дотно харьцаатай хамтрагчийн хүчирхийлэлд ихэнхдээ эмэгтэйчүүд өртдөг. Мөн хүүхэд байхдаа гэрлэсэн, эрт болон хүчээр гэрлэсэн охид өртөх нь элбэг байдаг. Хэдийгээр хайр сэтгэлийн харилцаатай ч гэрлээгүй байгаа өсвөр насныхны дунд үүсэж буй хүчирхийллийг “Болзооны үеийн хүчирхийлэл” гэж нэрлэдэг.

*Бэлгийн хүчирхийлэл* гэдэгт нөгөө талын зөвшөөрөлгүйгээр бэлгийн харилцаанд орох, орохыг завдах, биед нь хүрэхгүй хэдий ч бэлгийн шинж чанартай зөвшөөрөлгүй аливаа үйлдлүүд (тухайлбал бусдын бэлэг эрхтэн, бэлгийн харилцааг нууцаар харах (voyeurism), бэлгийн дарамт), зөвшөөрөл өгөх эсвэл эсэргүүцэх чадваргүй хүнийг бэлгийн харилцааны зорилгоор хүний наймаанд оруулах, цахим орчинд бэлгийн мөлжлөг үйлдэх зэрэг орно.

*Сэтгэл санаа болон сэтгэл зүйн хүчирхийлэл болон хүчирхийллийн гэрч болох* гэдэгт хүүхдийн хөдөлгөөнийг хязгаарлах, нэр төрд нь халдах, доромжлох, заналхийлэх, сүрдүүлэх, ялгаварлан гадуурхах, шоовдорлох болон бусад биет бус хүчирхийллийн үйлдлүүд багтана. Хүчирхийллийн гэрч болох гэдэгт хүчирхийллийн үйлдлийг ажиглах, үйлдэхийг хүүхдээс шаардах болон санамсаргүй байдлаар хоёр болон түүнээс дээш хүний хооронд болж буй хүчирхийллийг харах зэрэг багтана (ДЭМБ, 2016).

ХҮСНЭГТ 5. Хүчирхийллийн төрлүүдэд өртөх эрсдэл насны бүлгээр			
5-аас доош насны хүүхэд	5-10 насны хүүхэд	11-17 насны хүүхэд	18-аас дээш насны хүн
Хүүхэдтэй зүй бусаар харилцах			
Дээрэлхэлт			
Өсвөр үе, залуучуудын дундах хүчирхийлэл			
		Дотно харилцаатай хамтрагчийн хүчирхийлэл	
Бэлгийн хүчирхийлэл			
Сэтгэл санаа, сэтгэл зүйн хүчирхийлэл, хүчирхийллийн гэрч болох			

Бага насны, тэр дундаа 4-5 насны хүүхдүүд нь өөрийн хамгийн хайртай, дотны хэн нэгний дарамт, хүчирхийлэлд байгаагаа мэддэггүй бас ихэнхдээ нуудаг. Иймээс хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эцэг эх, асран хамгаалагч нь туслахгүй, эсвэл мэдээгүй тохиолдолд цэцэрлэгийн багш болон олон нийтийн байгууллагын үүрэг, хариуцлага нэн чухал болно. Нөгөө талаас цэцэрлэг, цэцэрлэгийн багш хуульд заасны дагуу хүүхдийг хамгаалах үүрэгтэй<sup>15</sup>.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас нийгмийн эрүүл мэндэд учрах богино болон урт хугацааны хор уршиг, эдийн засгийн өртөг нь боловсрол, эрүүл мэнд, хүүхдийн сайн сайханд оруулж буй хөрөнгө оруулалтыг үнэгүйдүүлж, ирээдүй хойч үеийн бүтээлч чадварыг сулруулж байдаг.

Улс орнуудын түршлагаас харахад, хүүхэд аль болох эрт, бага насандаа хүчирхийллийн тухай ойлголт, мэдлэгтэй байх нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах аж төрөх ёсонд амжилттай суралцаж байна. Жишээлбэл, *Гэрээр айлчлах хөтөлбөр*. АНУ-д хийсэн гэрээр айлчлах хөтөлбөрийн 20 гаруй судалгааг харьцуулан судалж үзэхэд, гэрээр айлчлах хөтөлбөр нь хүүхэдтэй зүй бус харилцах үйлдлийг ихээхэн хэмжээгээр бууруулсан дүнтэй байна. Мөн *Сувилагч Өрхийн Хамтын ажиллагааны хөтөлбөрийн* 15 жилийн дараах үнэлгээ судалгаагаар хүүхэдтэй зүй бус харьцах явдал буурсан үзүүлэлттэй байна. Хэд хэдэн бага дунд орлоготой улс орнуудад хэрэгжсэн *Хүүхдээ аюулгүй өсгөө* санаачилга нь вакцинд хамрагдах үед эрүүл мэндийн төвүүд

Бага насандаа хүчирхийлэлд өртөх нь тархины хөгжилд нөлөөлж, мэдрэлийн тогтолцооны бусад хэсгийг нэн хортой гэмтээдэг.

15 Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) болон Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль (2016) зэрэг.

дээрх анхан шатны эмнэлгийн ажилтнуудын хийсэн сурталчилгаа нь хүүхдээ өсгөхдөө хүчирхийлсэн болон үл хайхарсан арга хэлбэр ашиглах байдлыг тодорхой хэмжээнд бууруулсан гэсэн судалгаа байна. Эцэг эх Гэр бүл Чухал! хөтөлбөр нь бэлгийн харилцаа, бэлгийн амьдрал, бэлгийн эрсдэлийг бууруулах, ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх, бие махбод болон сэтгэл санааны хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл сэдвүүдээр эцэг эх, хүүхдүүдийн дунд үр дүнтэй яриа харилцааг бий болгох, эерэг хүмүүжлийн арга зүйг дэмжсэн, эцэг эхэд чиглэсэн үйл ажиллагаа болж чадсан (ДЭМБ, 2016).

## ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ ДОЛООН СТРАТЕГИ (INSPIRE)

Хүүхдийн хүчирхийллийг таслан зогсоох нь засгийн газраас эхлээд иргэн бүрийн үүрэг. Энэ үүрэг хариуцлагын хэрэгжилтэд улс орон болон орон нутгийнханд туслах зорилгоор ДЭМБ-ийн санаачлагчаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах хамгийн өндөр боломжтой, урьдчилсан сэргийлэх нотолгоо дээр суурилсан, бодит жишээ бүхий долоон стратеги хөтөлбөр үйлчилгээг боловсруулан гаргасан байдаг.

7 стратеги хөтөлбөрийн зорилго нь бүх улс орны засгийн газрууд иргэний нийгэм, олон нийтийн оролцоотойгоор бүх хүүхэд, өсвөр насныхны эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хариу үйлдэл үзүүлэн тэднийг өөрийн бүрэн боломжиндоо хүртэл хөгжих нөхцөлөөр хангах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, хянаж байдаг дэлхий ертөнцийг бүтээх явдал. 7 стратегид:

- Хууль хэрэгжүүлэх, сахиулах
- Хэм хэмжээ болон үнэт зүйлс
- Аюулгүй орчин
- Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг
- Орлого нэмэгдүүлэх, эдийн засгийг бэхжүүлэх
- Хариу үйлдэл болон дэмжих үйлчилгээ
- Боловсрол болон амьдрах үр чадвар зэрэг багтаж байгаа юм.

Стратегиудыг дэлгэрүүлэн авч үзвэл,

i) *Хууль хэрэгжүүлэх, сахиулах.* Хүүхэд залуучуудад зориулсан эрх зүйн хамгаалалт болсон хууль, бодлого болон тэдгээр хамгааллыг сахиулах арга хэрэгслийг боловсруулж бэхжүүлэх нь хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чухал алхам юм. Хүчирхийлэгч зан үйлээс урьдчилан сэргийлэх, архины хэт хэрэглээг багасгах, галт зэвсэг болон бусад зэвсгийн хүүхэд залуучуудад хүртээмжтэй байдлыг

хязгаарлах зорилго бүхий хуулийн хэрэгжилтийг хангаж, сахиулах үйл ажиллагаа.

- ii) Хэм хэмжээ болон үнэт зүйлс.* Хүүхэд өсвөр насныханд зориулсан, хүчирхийллийн бус, тэднийг хүндэтгэсэн, хөгжих боломжийг нь хангасан, эерэг, жендерийн тэгш харилцааг дэмжсэн хэм хэмжээ үнэт зүйлсийг бэхжүүлэх зорилготой үйл ажиллагаанууд. Үүнд хор уршиг үзүүлж болохуйц хүмүүжлийн болон жендерийн хэм хэмжээг өөрчлөх хөтөлбөр, хор уршигтай жендерийн болон нийгмийн хэм хэмжээг дагаж мөрдөхийг өөрчлөх, орон нутгийг идэвхжүүлэх, хөндлөнгийн хүний оролцоог дэмжих, хэвлэл мэдээлэл болон нийгмийг идэвхжүүлэх өргөн хүрээний компанит ажлын дэмжлэгтэйгээр хүчирхийллийн кейсийг мэдээлэх зэрэг багтаж байгаа юм.
- iii) Аюулгүй орчин.* Аюулгүй гудамж болон хүүхэд залуучуудын цуглаж чөлөөт цагаа өнгөрөөх бусад орчинг бүрдүүлж, аюулгүй байдлыг нь тогтвортой хадгалах зорилготой ба аюулгүй орчинг бүрдүүлэх стратеги нь тухайн орон нутагт нийгмийн болон бодит орчинд өөрчлөлт оруулснаараа зөв зан төлөвийг дэмжиж, аюултай зан үйлээс сэргийлж чадна.
- iv) Эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг.* Хатуу гараар хүүхэд хүмүүжүүлэх явдлыг бууруулж, эцэг эх хүүхдийн хооронд эерэг харилцааг бий болгох зорилготой. Гэр бүлийг дэмжиж, эерэг хүмүүжлийн аргыг эцэг эх асран хамгаалагч нарт сургаснаар, хүүхдийг гэр бүлээсээ тусгаарлагдах, гэр бүлийн орчинд хүүхэдтэй зүй бус байдлаар харьцах, ээж болон хойд ээж нь хүчирхийлэлд өртсөн үйлдлийн гэрч болох, хүүхэд өсвөр насныхны дунд түрэмгий зан үйл илрэх зэргээс урьдчилан сэргийлж чаддаг байна.
- v) Орлого нэмэгдүүлэх, эдийн засгийг бэхжүүлэх.* Гэр бүлийн эдийн засгийн аюулгүй байдлыг сайжруулж, хүүхэдтэй зүй бусаар харьцах болон гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилготой хөтөлбөр. Бэлэн мөнгөний тусламж нь хүүхдийн бэлгийн хүчирхийлэл мөлжлөгийг бууруулахад нөлөөлж байна.
- vi) Хариу үйлдэл болон дэмжих үйлчилгээ.* Хүчирхийллийн урт хугацааны хор уршигийг багасгахын тулд хүчирхийллийн талаар мэдээлэх болон эрүүл мэнд, нийгмийн халамж, хууль эрхзүйн чанартай тусламж үйлчилгээг хэрэгцээтэй бүх хүүхдэд хүртээмжтэй болгон сайжруулах зорилготой үйлчилгээ нь хүчирхийллийн биеийн болон сэтгэхүйн эрүүл мэндэд учруулсан хор хохирлоос хүүхдийг нөхөн сэргээхэд тустай.
- vii) Боловсрол болон амьдрах үр чадвар.* Хүүхдэд үр өгөөжтэй, жендерийн тэгш байдлыг хангасан боловсрол, нийгэм - сэтгэл хөдлөлийн талаар

суралцах боломж, амьдрах ур чадварын сургалтыг илүү хүртээмжтэй болгох, аюулгүй бөгөөд хүүхдийг дэмжсэн боловсролын орчин бүрдүүлэх зорилготой ба боловсролын бүх түвшинд хамрагдалтыг нэмэгдүүлэх, аюулгүй, сурах боломжийг хангасан орчин бүрдүүлэх, өөрсдийгөө хүчирхийллээс хамгаалах талаар хүүхдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, амьдрах болон нийгмийн ур чадварын сургалт явуулах, дотно хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

### Дүгнэлт

- Бага насны хүчирхийллийн сүүдэр хүнийг насан туршид дагадаг.
- Хүүхдийн хүчирхийллийн ихэнх хувийг бага насны хүүхдийн хүчирхийлэл эзэлж байна.

### Өөрийгөө шалгах асуулт

- Бид санамсаргүй байдлаар хүүхдээ хүчирхийлж байна уу? Яагаад?
- Бид хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар юу мэдэх вэ?
- Бага насны хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход, устгахад та юу хийж чадах вэ?





## СЭДЭВ 6

### БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРОЛ

#### БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД БҮХ НИЙТИЙН ОРОЛЦОО

Боловсрол бол бид бүгдийн хамтын үүрэг хариуцлага юм. Бүх нийтийн хүчин чармайлтын үр дүнд тогтвортой хөгжилд хүрч чадна. Үүрэг хариуцлагыг дан ганц тоглогч (сургалтын байгууллага, багш) бус, харин олон талын хамтын үүрэг, хариуцлагын үр дүнд боловсрол үнэ цэнтэй, үр өгөөжтэй болдог. Өөрөөр хэлбэл, нийтийг хамарсан, тэгш боломжийг баталгаажуулсан, чанартай боловсрол нь ихэнх тохиолдолд талууд дор бүрнээ үүрэг хариуцлагаа ухамсарласан хамтын ажиллагааны үр дүн байдаг (НҮБ-ын БСШУБ, 2017).

БНХ-ийн хөгжлийн төлөө бүх талууд хамтран ажиллах учиртай. Хариуцлага нь тодорхойгүй, мөн чиг үүрэг нь давхардсанаас зорьсон үйл замхрах магадлалтай байдаг тул оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нарийн тодорхойлж өгөх нь зүйтэй.

Бага насны хүүхдийн хөгжил төлөвшилд олон нийтийн, ялангуяа эцэг эх, асран хамгаалагчдын хувь нэмэр нэн чухал билээ. Тэгш бус байдал амьдралын анхны өдрөөс эхэлдэг ба ийм байдлыг устгахын тулд оролцогч талууд нэгдэн, ажиллах нь хүүхэд бүрийн эрүүл, цогц хөгжлийн төлөө гэдгийг монгол хүн бүрийн зүрх сэтгэлийн угт орших эрхэм зүйл байх учиртай. Ийм нэгэн эрхэм зүйлийг сэтгэлдээ тээхэд тань нэмэр болох үүднээс бага насны хөгжлийн зарим онцлох үзүүлэлтүүдийг дор сийрүүлэн өгүүлье.

## БАГА НАСНЫ ХӨГЖЛИЙН ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Хэрвээ бид үлгэрийн эхлэлийг өөрчилж чадвал, үлгэр тэр чигээрээ өөрчлөгдөнө.*

Эдийн засгийг жигд, тогтвортой өсгөх, иргэдэд тэгш, хүртээмжтэй боломжийг олгох, ядуурлыг бууруулах, хөгжил цэцэглэлтэд хүрэх хамгийн зөв, ашигтай арга зам юу вэ? Хариулт нь маш энгийн. Энэ бол бага насны боловсролд хөрөнгө оруулах явдал юм. Бага насны боловсролын хөрөнгө оруулалт хүн бүрт ашигтай. Яагаад гэдгийг дараах 5 тайлбараас харъя.

1. *Бага нас, тэр дундаа амьдралын эхний 3 жил хүүхдийн тархины хөгжилд нэн чухал үе. Хүүхдийн харж, сонсож, хүрч, амталж, үнэрлэж байгаа үйл бүхэн түүний тархины бүтцийг хэлбэржүүлж, сэтгэн бодохуйн хөгжлийг дэмжиж байдаг. Энэ насанд хүүхдийн тархи маш хурдтай хөгждөг ба энэ хэрээр хүүхэд оюун ухаан, хэл яриа, нийгэмшихүй, сэтгэлийн хөдөлгөөн, бие бялдрын хувьд хурдтай хөгждөг гэсэн үг. Мэдрэхүйн аль нэг эрхтнээрээ ямарваа нэгэн зүйлийг мэдрэх бүр хүүхдийн тархинд мэдрэлийн эсийн нэгэн шинэ холбоос үүсч байдаг.*

### ЗУРАГЛАЛ 7. Мэдрэлийн эсийн холбогдож буй болон тасарч буй байдал



Эх сурвалж: Харвардын Их Сургуулийн Хүүхэд хөгжлийн төв

Эдгээр мэдрэмж давтагдах бүр үүссэн эсийн холбоос батжихын зэрэгцээ өөр шинэ шинэ холбооснууд мөн үүсч, энэ үйлүүд нь хүүхдийн сэтгэн бодох, мэдрэх, биеэ авч явах, суралцах үйлийг чиглүүлж байдаг. Хүүхдийн тархины хөгжлийг дэмжих хамгийн таатай, эерэг хүчин зүйл нь эцэг эх, асран хамгаалагчийн халуун дотно харилцаа юм. Эцэг эх, асран

хамгаалагчийн хүүхэдтэйгээ тоглож, ярилцаж, хайрлаж халамжилж, ном уншиж, үлгэр ярих, эрүүл шим тэжээлтэй хоолоор хооллох зэрэгт хүүхдийн тархи тэжээгдэж, тэтгэгдэж байдаг. Бага насанд ийм асаргаа сувилгаа, хайр халамж хамгийн их шаардлагатай. Хүүхдийг өргөх, тэврэх, ярилцах зэрэг нь хүүхдийн тархины хөгжлийг хурдасгахаас гадна сэтгэлийн хөдөлгөөний хөгжилд таатай нөлөө үзүүлдэг. Ээжийн дотно харилцаа, хөхөөрөө хооллож байгаа зэрэг нь хүүхдийн мэдрэхүй, сэтгэлийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангадаг сайн талтай. Хүүхэд хөхөөр хооллох үедээ шим тэжээл болон тайтгарал, ая таатай байдал аль алиныг нь авч байдаг. Хүүхдэд таатай, энэ халуун дотно харилцаа нь түүний цаашдын суралцах, өөртөө итгэх итгэл, нийгэмшихүйн эерэг чадварууд, харилцаа, өр зөөлөн сэтгэлийн суурь болох ба эдгээр нь түүний насан туршдаа амжилттай ажиллаж амьдрах суурь нөхцөл болдог.

Хүүхэд гэр бүл, цэцэрлэг, байгаа орчиндоо аюулгүй, итгэлтэй байдлыг мэдрэх бүр өөртөө итгэлтэй, бие даасан, өөрт тулгарсан асуудлыг элдэв бүхимдалгүйгээр даван туулж чаддаг болно.

2. Хүүхэд төрсөн цагаасаа л маш хурдтай суралцдаг. Энэ нь эрүүл, шим тэжээлтэй хоол хүнс, шаардлагатай эрүүл ахуйн асаргаа, сувилгаа, аюулгүй орчин, хайр энэрэл бүхий харилцааны үр дүнд амжилттай явагддаг. Хүүхдийн өөрийн ертөнцийг нээх, танин мэдэх хэрэглүүр нь түүний мэдрэхүйн эрхтнүүд: хүрэлцэх, сонсох, үнэрлэх, харах, амтлах чадварууд юм. Мэдрэхүйн 5 эрхтнээрээ дамжуулан тэд шинэ зүйлийг мэдэрч, гайхаж, эрж хайж, түршиж, өөртөө шинэ шинэ зүйлсийг нээж, суралцдаг. Хүүхэд:

- юмсыг тэвэрч, түүнтэй харилцаж байхад,
  - ойр дотны хүмүүсийнхээ царайг харж, дуу хоолойг нь сонсож байхдаа,
  - олон сонин зүйлийг барьж байхдаа илүү хурдан хүртэж, ойлгон ухаарч, мэдэж байдаг.
3. Хүүхэд тоглох үедээ шинэ зүйлсийг танин мэдэж, учир ухааныг тунгаан эргэцүүлж, бусдын үзэл бодлыг сонсож, эргэцүүлж, түүнд өөрийгөө

зохицуулж, гүйж харайж, хийж бүтээдэг. Тоглох үйл нь түүний хөгжих, суралцах гол арга байдаг. Тоглоом нь:

- хүүхдийн танин мэдэхүй, үйлийн туршлага, сониуч, өөртөө итгэлтэй байдлыг хөгжүүлдэг.
- үйлийг турших, үр дүнг харьцуулах, асуулт асуух, саад бэрхшээлтэй тулгарах нөхцөлийг бүрдүүлж, түүнээсээ суралцах боломжийг олгодог.
- хүүхдийн хэл ярианы болон зохион бодох, төлөвлөх, зохион байгуулах, шийдвэр гаргах чадварыг дэмждэг.



Жишээлбэл, хүүхэд өрж байгуулах тоглоомоор тоглож байх үедээ:

- Дүрсүүдийг хэлбэр, өнгө, хэмжээгээр ялган, таньж мэдэх явцад хүүхдийн тархинд оюуны энгийн хялбар болон хүндэвтэр үйлдлүүд явагдаж байдаг.
- Хоорондоо идэвхтэй харилцаж, ярих чадвар, хэлний тухай ойлголтоо бататгаж, сайжруулж, хэлний шинэ шинэ чадваруудыг эзэмшиж байдаг.
- Хамтрагчийнхаа сэтгэлийн хөдөлгөөнийг мэдрэх, даган дуурайх, учир шалтгааныг ойлгохыг хичээх байдлаар нийгэмшихүй, сэтгэлийн хөдөлгөөний тухай ойлголтоо бататгаж, түүнийгээ зохицуулах чадварт суралцаж байдаг.
- Тоглоомын эд ангийг барьж, зөөх, өрөх үед тэдний том болон жижиг булчин идэвхтэй хөдөлгөөнд орж, гарын хөдөлгөөнөө мэдрэх, зохицуулах чадвар болон хурууны үзүүрийн мэдрэмж сайжирч байдаг.
- Хүүхэд сэтгэл зүйн тайван байдалд анхаарлаа бүрэн төвлөрүүлж, дүрсүүдийг давхарлан өрөх үед тэнцвэрийг нь олж тогтоох гэж оролдох, нураад байгаа учир шалтгааныг олох замаар өөрөө юмсын шинж чанарыг таньж, асуудал бэрхшээлийг олж харах, шийдвэрлэх байдлаар идэвхтэй суралцаж байдаг.

Энэ мэт тоглох үйлийн олон талын нөлөөг өөр ямар ч хөндлөнгийн оролцоо дэмжлэг орлож, нөхөж чадахгүй учраас хүүхдийн хөгжил, төлөвшилд тоглох нь маш чухал ач холбогдолтой.

4. Хүүхэд ойр дотныхоо хүмүүсийг дуурайх замаар биеэ авч явах чадварт суралцдаг, бусдын хийж буй үйлдэл, гаргаж буй зан авирыг хүүхэд анхааралтай харж, тогтоож түүнийгээ дуурайх, давтан хийх байдлаар

бусадтай харилцах чадварт суралцдаг. Ингэхдээ хүний зохистой ба зохисгүй зан байдлыг аль алиныг нь харж дуурайж байдаг. Хүүхэд дүрд хувирч тоглох их дуртай байдаг. Өөрөөр хэлбэл, бусдын дүрд (аавын, ээжийн, багшийн гэх мэт) хувирч, түүний хэлдэг үг, хийдэг ажил, үйл хөдөлгөөн зэргийг дуурайх дуртай байдаг. Энэ нь хүүхдийн төсөөлөн бодох, бүтээлчээр сэтгэх чадварыг нь дэмждэг сайн талтайгаас гадна хүмүүсийн зан байдал, харилцааны ялгаатай байдлыг ойлгож, түүнийг хүлээн авах, татгалзах, түүнд зохицуулан харилцах боломжийг олгодог.

5. Бүх хүүхэд хөгжлийн тодорхой үе шат, зүй тогтлын дагуу хөгждөг хэдий ч хүүхэд бүрийн хөгжил өөрийн онцлог, хөгжлийн хурдтайгаар явагддаг. Хүүхэд бүр өөрийн сонирхол, суралцах хэв шинж, бусадтай харилцах зан байдал, темпераментаараа ялгаатай. Хүүхдийн хөгжлийн талаарх ойлголт, мэдлэг нь эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийнхээ хөгжилд гарч буй өөрчлөлтийг ойлгох, түүнийг дэмжихэд тустай. Хүүхэд бүрийн хөгжилд давтагдаж байдаг онцлог байдаг хэдий ч энэ нь онцлогууд бүгд ижил байдлаар нэг цаг хугацаанд, ижил илрэлтэйгээр явагддаггүй. Үүнийг бид хүүхдийн хувийн онцлог гэж ойлгодог. Хүүхдийнхээ үйл хөдөлгөөн, хэл яриа, зан байдалд гарч буй өөрчлөлтийг өөр хүүхдэд илэрсэн байдалтай харьцуулан, адил арга барилаар ажиллах нь тэр бүр үр дүнтэй байдаггүй. Өөрөөр хэлбэл, хүүхэд бүрт тохирох арга гэж байдаггүй. Хүүхдийн хөгжил төлөвшилд илэрч байдаг онцлог шинжүүд тухайн хүүхдэд ямар байдлаар илэрч байгааг түүний бие физиологи, сэтгэхүйн хөгжлийн онцлогтой нь холбон авч үзэх нь түүний хөгжлийн ерөнхий төлөвийг хянах, аливаа асуудал бэрхшээлээс урьдчилан сэргийлэх боломжийг эцэг эх, асран хамгаалагчдад өгч байдаг.

Дээрх тайлбар нь хүүхдийн тархины хөгжлийн онцлогтой холбоотой болохыг орчин үеийн тархи судлалын шинжлэх ухаан илрүүлж, нотолж байгааг дараагийн бүлэгт өгүүлэх болно.

### Дүгнэлт

- Аливаа улс орны хөгжил бага насны хөгжил, боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээтэй шууд холбоотой болохыг улс орнуудын туршлага харуулж байна.
- Бага нас хүний хөгжлийн хамгийн чухал үе гэдгийг олон судалгааны үр дүн байна.
- Бага насны хүүхдийн хөгжилд хөндлөнгийн нөлөөлөл, насанд хүрэгчдийн дэмжлэг, зан үйл чухал нөлөөтэй.

### Өөрийгөө шалгах асуулт

- Бага насны хүүхдийн хөгжил эцэх, асран хамгаалагчдын үүрэг, оролцоо яагаад хамгийн чухал байдаг вэ? Яагаад?

### БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ТАРХИНЫ ХӨГЖИЛ

Бага насны буюу 5 хүртэлх насны хүүхдийн хөгжил яагаад хөгжин цэцэглэсэн, тогтвортой хөгжлийг хангасан нийгмийг байгуулахад суурь хүчин зүйл болохыг бага насны тархи судлалын шинжлэх ухаан хүүхдийн тархи болон зан харилцаан дээр хийсэн олон арван жилийн судалгааны үр дүнд гаргаж авсан дараах үндсэн ойлголтуудаар тайлбарлаж байна.

Хүний тархинд хараа, сонсгол гэх мэт мэдрэхүйн чанарууд эхлэн хөгжиж, хожуу 9 сар орчмоос хэл яриа, нэг нас хүрэхийн үед дээд мэдрэлийн үйл

ажиллагаанууд хөгжиж эхэлдгийг доорх зургаас харж болно. Өөрөөр хэлбэл, тархи эхэндээ олон шинэ холбоосоор хурдтай баяжиж байгаад яваандаа шинэ холбоос нэмэгдэх хурд буурч, өмнөх энгийн үйлдлийн хэлхээн дээр тулгуурласан илүү нарийн төвөгтэй үйлдлийн хэлхээнүүд бүрэлдэн тогтдог байна (Зураглал 8.).


Амьдралын эхний жилүүдэд тархины мэдрэлийн эсүүд асар их хурдаар, секундэд 700-1000 шинэ холбоос үүсгэдэг.

*Шанкоф, 2009*

Тархины жингийн 87% нь (энэ нь 1100 грамм орчим) гурав хүртэлх насанд бүрддэг.

*Декабан, 1978*

**ЗУРАГЛАЛ 8. Хүүхдийн тархины мэдрэлийн эсийн хөгжил**



Бага насны хүүхдийн тархи хамгийн уян байдаг бөгөөд энэ нь хүүхдийн бие бялдар, оюуны хөгжил, насан туршдаа суралцах, дасан зохицох чадварын сэтгэл зүйн үндэс нь болдог. Орчноос, ялангуяа эцэг эх, асран хамгаалагчаас ирэх өдөөлтөд хариу өгөх, эсвэл өөрийн хүсэлд ирэх хариу үйлдлийг хүлээн авах зэрэгт хүүхдийн тархинд шинэ шинэ холбоос үүсч байдаг. Хүний тархины энэ хурдтай хөгжил нь хэдэн мянган жилийн туршид бүрэлдэн бий болсон генетикийн загвар дээр үндэслэгддэг хэдий ч үүнд хүүхдийн оролцож буй үйлүүд, ялангуяа харилцаа, тоглох үйл, түүний давтагдах байдал чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тархины хөгжлийн үндсэн жор нь “өдөөлт ба хариу үйлдэл” болохыг эрдэмтэн нэгэнт тогтоосон. Энэ нь хүүхэд өөрийн шулганаа, нүүрний хувирал, дохио зангаагаараа насанд хүрэгчдийн анхаарлыг өөртөө хандуулж чаддаг ба насанд хүрэгчид түүний хариуд уян зөөлнөөр дуудах, инээмсэглэх, хүссэн үйлдлийг нь хийх өгөх явдал юм.

Энэ чухал харилцааг мэдрээгүй, эсвэл зохисгүй, хүсээгүй хариуг мэдэрсэн хүүхдэд хожим зан төлөвийн хувьд өөртөө болон бусдад итгэлгүй, айдастай, суралцахуйн хувьд бусдыг даган дуурайсан, өөртөө итгэлгүй зэрэг ялгаатай байдал илэрдэг. Эндээс харахад, хүүхдийн тархины хөгжилд хүний өөрийн генийн бүтэц болон түүний туршлага хамтдаа нөлөөлдөг болохыг ойлгож болно.

Тархи хөгжихийн хэрээр хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөн хүчтэй илэрдэг. Аливаа зүйлийг хийж, авч чадахгүй үедээ сэтгэлээр унаж, танихгүй хүн, шинэ орчин, харанхуйгаас айна. Аливаа үйлдлийнхээ хариуд шоолсон, загнуулж, шийтгүүлсэн, гадуурхагдсан мэдрэмжийг авсан хүүхэд ичимхий, өөрийн сэтгэл хөдлөлөө зохистой илэрхийлэх чадваргүй болох ч тохиолдол бий. Хүүхдийн хүчтэй сэтгэлийн хөдөлгөөнд анхаарал тавьсан, сэтгэл гаргасан хариу үйлдэл үзүүлэх нь түүний баяр хөөртэй, хамгаалагдсан, өөртөө болон орчиндоо итгэлтэй бие хүн болон өсдөг.

Хүний тархины үндсэн бүтэц нь эхийн хэвлийд үр бүрэлдэн бий болсон гурав дахь долоо хоногоос насанд хүрэх хүртэлх удаан хугацааны турш хүмүүний хийж буй үйлийн явцад бүрэлдэн бий болдог.

Хүний тархины бүтэц түүний хөгжилд удамшил болон орчин нөлөөлдөг.

Хүний тархи бага насандаа хамгийн уян байдаг ба аливаа шинэ зүйлийг сурах, хүлээж авахдаа хурдан, түүний хөгжил төлөвшилд нөлөөлөх боломж

өндөр байдаг бол нас ахихын хэрээр бага насанд илрэх өөрчлөлтийг бий болгохын тулд гаргах хүчин чармайлтын хэмжээ бараг үрвүү хамааралтай байхаар их байгааг дээрх зургаас харж болно.

Хүний тархи нь цогц үйл ажиллагаатай эрхтэн ба оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөн, нийгэмшихүйн чадамжууд нь хүний тархины нарийн үйл ажиллагаагаар зохицуулагддаг.

Сэтгэлийн хөдөлгөөний эрүүл, тогтвортой байдал ба нийгэмшихүйн чадамж нь сэтгэхүйн хөгжлийн үндэс суурь нь болдог ба энэ бүгд нийлээд хүний хөгжлийг бүрдүүлж байдаг. Бага насанд суурь нь тавигддаг сэтгэлийн хөдөлгөөн, бие бялдрын эрүүл байдал, нийгэмшихүйн чадварууд болон хэл яриа, сэтгэхүйн чадамжууд нь хүний хожим сургуульд амжилттай суралцах, ажил дээр болон нийгэмд амжилттай ажиллаж, амьдрах урьдач нөхцөл нь болдог.

Хорт стрессүүд нь хөгжиж буй тархины бүтцийг алдагдуулдаг ба энэ нь хүний суралцах, зан байдлыг хувьд бие авч явах байдалд бие бялдар болоод оюун ухааны насан туршийн бэрхшээл үүсэх шалтгаан болдог.

Ядуурал, гадуурхал, эд материалын гачигдал, сэтгэл зүйн дарамт зэрэг нь хүүхдийн тархины хөгжилд хортой нөлөө үзүүлдэг.

Бага насны хүүхдийн тархины хөгжилд хоол тэжээл, халамж хайр, сэтгэл зүйн орчин, асаргаа зэрэг нөлөөлөх хүчин зүйлс онцгой ач холбогдолтой. Тухайлбал,

- *Бага насны хоол тэжээлийн дутагдал тархины хөгжлийг сааруулдаг.* Төрөхийн өмнөх үе болон төрсний дараах эхний жилүүдэд хүүхдийн тархи асар их энерги шаарддаг бөгөөд хоолоор авч байгаа тос, уураг, амин дэм, эрдэс бодисын 50–75 хувийг тархи хэрэглэдэг байна. Энэ үед хоол тэжээл хангалтгүй бол тархины бүтэц, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хожим засаж залруулахад бэрхшээлтэй болдог.
- *Сэтгэл зүйн байдал ба хоол тэжээл харилцан үйлчлэлээрээ хүүхдийн тархи ба бие махбод хоол хүнсний шим тэжээлийг шингээх үйл явцад нөлөөлж улмаар хүүхдийн хөгжилд нөлөөлдөг.* Хүний бие махбодын хоол тэжээлийг шингээх чадвар, бие организмд орж ирж байгаа хоол тэжээлийг хаана хэрхэн хуваарилах, шингээхийг хүний бие организм цогц тогтолцоогоороо эрэмбэлэн тогтоодог байна. Сэтгэлийн дарамт буюу стресс ихтэй байвал бие махбод нь тархины хөгжлийг дэмждэг амин чухал шим тэжээлийг шингээх чадвараа алддаг. Мөн сэтгэлийн дарамт нь эмзэг, чухал эрхтнүүдийн хоол шингээх чадварыг бууруулж,



нэмэлт тэжээл, ялангуяа онцгой байдлын үед тэжээлийн дутагдалтай хүүхдэд эмчилгээний зорилгоор өгдөг нэмэгдэл тэжээлийн үр нөлөөг ч сулруулдаг.

- *Бага насандаа мэдэрсэн хүчирхийлэл, дарамт, үр хайхрах байдал нь насан туршийн урхагтай.* Сэтгэлийн дарамт шахалт, айдас түгшүүр, үл хайхрах байдал зэрэг нь кортизол хэмээх стрессийн хортой даавар үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг ба энэ нь тархины эсүүдийн нэвчих чанарыг хязгаарлаж, хөгжлийг сааруулдаг. Улмаар энэ нь хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, зан төлөвт сөргөөр нөлөөлдөг.
- *Бага насны боловсрол насан туршид хадгалагддаг.* Учир нь бага насанд үүссэн эерэг сэдэл, сонирхол, үзэл бодол хүний амьдралын туршид хадгалагдан үлддэг учраас энэ насанд оруулсан хөрөнгө оруулалт хамгийн үнэ цэнэтэй байдгийг Нобелийн шагналт эдийн засагч Дж.Хекман судалж нотолсон.
- *Эхийн сүүгээр хооллох нь эх хүүхдийн аль алины нь зан төлөвт эерэг нөлөө үзүүлж, холбоог улам бэхжүүлдэг.* Энэ эерэг холбоо, асаргаа халамж нь хүүхдийн насан туршийн тархины бүтэц, үйл ажиллагаа болон дараа дараагийн үе удамд ч нөлөөлдөг.

### Дүгнэлт

- Бага нас хүний тархины хөгжлийн хамгийн уян, эрчимтэй хөгжлийн үе.
- Сэтгэл зүйн тайван байдал хүүхдийн тархины хөгжлийн чухал амин дэм.

### Өөрийгөө шалгах асуулт

- Бага насны хүүхдийн тархины хөгжилд хамгийн чухлаар нөлөөлөх хүчин зүйлс юу байх вэ?

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Бага насны талаарх орчин үеийн үзэл баримтлал. Өнөөдөр дэлхийн улс орнууд бага насны талаар олон бодлого, үзэл баримтлал, хандлага дэвшүүлэн гаргаж байна. Үүнээс хамгийн нөлөө бүхий 4 хэтийн хандлагыг товч авч үзвэл:

- *Хөгжлийн хэтийн хандлага* – хүүхэд нас бие бялдар, сэтгэхүй, нийгэмшихүйн хөгжлийн хувьд хамгийн эмзэг, бусдаас хамааралтай, хүний хөгжлийн суурь тавигдах үе хэмээн авч үзэх хандлага.

- *Улс төр, эдийн засгийн хэтийн хандлага* – хүүхэд нас улс, нийгмийн хүний нөөцийн дараагийн суурь үе, хүний хөгжлийн эхний бүрэлдэх үе учраас хүүхэд насанд боловсрол, нийгмийн оролцооны үзүүлэх нөлөөг онцлон анхаарч үзэх хандлага.
- *Нийгэм, соёлын хэтийн хандлага* – бага насны хүүхдэд зориулсан сургалтын зорилго, агуулга, стандартыг хэрэгжүүлэхэд ашиглаж буй арга барил, практик үйл ажиллагаанд хүүхдийн хувийн болон соёлын ялгаатай байдлыг харгалзах, хүндэтгэлтэй авч үзэх хандлага.
- *Хүний эрхийн хэтийн хандлага* – онол, судалгааны бодлогын уламжлалт барилыг өөрчилж, бага насны хүүхдийн дахин давтагдашгүй хувь онцлог, тэдний өөрийн хөгжил болон хөгжлийг дэмжих үйлчилгээнд оруулах хувь нэмрийг харгалзаж, түүнд хүндэтгэлтэй хандах хандлага.

Бага насны хүүхдийн амьдралын чанарыг сайжруулах, хөгжлийг дэмжих нь өнөөгийн улс орнуудын тэргүүн зорилго бөгөөд энэ нь тэдний бага насны хүүхдийн хөгжил, боловсролын талаар хийж буй судалгаа ба баримтлах бодлогын идэвх санаачилгууд болон бага насны хөгжлийг дэмжих хөтөлбөр төлөвлөгөө, хамгааллын арга хэмжээгээр илэрч байдаг. Бага насны хөгжил, хамгаалал, боловсролын асуудал улс орнуудын хөгжлийн бодлогоос гадна хүүхдийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх ойлголт, итгэл үнэмшил зэргээс харагддаг. Бага насны хүүхдийн амьдралын чанарыг сайруулахад зориулан хийж буй зүйлс, оруулж буй хөрөнгө оруулалт нь тэдний ирээдүйн төлөө хийх хамгийн зөв шийдэл, үйл хэрэг юм.

*Бага насны хөгжлийн чиглэл.* Өнөөдөр бага насны хүүхдийн хөгжлийн шинжлэх ухаанд үндсэн 3 хөгжлийн чиглэлийг авч үздэг. Үүнд:

- *Бие бялдрын хөгжил* – биеийн ерөнхий өсөлт, том болон жижиг булчингийн хөгжил, тархины хөгжил
- *Оюун ухааны хөгжил* – хэл яриа, төсөөлөхүй, зохион бодохуй, ой, сэрэл хүртэхүй
- *Нийгэмшихүй, сэтгэлийн хөдөлгөөний хөгжил* – темперамент, өөрийгөө илэрхийлэх, хамтран ажиллах, бусдыг ойлгох, зорилгоо тодорхойлох,

Эдгээр чиглэлүүдийг хэдийгээр ингэж тус тусад нь авч үздэг хүүхдийн хөгжлийн зүй тогтлыг сайн ойлгоход чиглэгдсэн болохоос биш хүний хөгжил нь цогц байдлаар явагддаг. Өөрөөр хэлбэл, хүүхдийн бие бялдрын хөгжил түүний өөртөө итгэх байдал, харилцааны хөгжилд нөлөөлж байдаг. Хүүхдийн хэл ярианы хөгжил нь хүүхдийн сэтгэн бодохуй, нийгэмшихүйн хөгжилд нөлөөлж байдаг.

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих орчин үеийн арга барил. Тархи судлалын шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажлын үр дүн нь бага насны хөгжлийн талаар урьд өмнө байгаагүй бодит боломжуудыг нээж өгсөн байдаг. Ийм боломжуудад тулгуурлан бага насны боловсролын үр дүнг сайжруулахад дараах зарчмуудыг баримтлахыг Харвардын их сургуулийн эрдэмтэд санал болгосон байна. Үүнд:

*Хүүхэд ба насанд хүрэгчдийн идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг дэмжих* – Хүүхэд ба насанд хүрэгчдийн хариуцлагатай харилцаа, хамтын ажиллагааг дэмжих. Хүний амьдралын эхний жилүүдэд мэдэрсэн анхаарал тавьсан, хариуцлагатай хамтын ажиллагаа нь хүүхдийн тархины бүтцийн хэлбэржилт, хөгжилд чухал нөлөө үзүүлдэг. Энэ нь дээр өгүүлсэн хүүхэд ба эцэг эх, асран хамгаалагчийн “өдөөлт ба хариу үйлдэл” харилцаанаас эхлэлтэй бөгөөд хүүхдийн асуулт, давтсан үйл, сонирхсон зүйл бүхэнд насанд хүрэгчдийн зүгээс тодорхой нэгэн хариултыг өгч байх хүүхэд нас, цаашлаад насанд хүрэх үеийн аливаа асуудалд уян, олон талаас нь ойлгож хандах чадварын суурь болдог хэмээн үздэг байна. Үүний тулд эцэг эх, асран хамгаалагчдад зориулан:

- аль болох олон удаа, олон янзын байр газарт хүүхэдтэйгээ хамт байх боломжоор хангах
- хүүхдийн хөгжил төлөвшлийн талаар тодорхой ойлголт мэдлэгийг эзэмших сургалт, чөлөөт ярилцлага зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах
- мэргэжлийн хүмүүстэй өөрийн хүүхдийн онцлог, ялгаатай байдлын талаар зөвлөгөө авч, хамтран ажиллах боломжийг олгох зэрэг идэвхтэй үйл ажиллагааг бүх нийтийн үйл болгон зохион байгуулах шаардлагатай юм.

*Амьдралын чухал чадваруудыг эзэмших, бататгах орчин, нөхцөлийг бүрдүүлэх* – Ажил амьдралд тохиох асуудал, бусадтай хамтрах харилцахад учрах аливаа бэрхшээлүүд нь тодорхой чадваруудыг биднээс шаардаж байдаг. Эдгээр чадваруудыг бид хэр зэрэг эзэмшсэнээс шалтгаалан тухайн асуудал, бэрхшээлийн амжилттай шийдэгдэх эсэх нь шалтгаалдаг. Эдгээр цогц чадварууд нь биднийг асуудалдаа төвлөрөх, төлөвлөх, зорьсондоо хүрэх, нөхцөл байдлын өөрчлөлтөд дасан зохицох, эргэн тойрны хүмүүсийн ялгаатай зан байдлыг зохицуулах, ойлгох боломжийг бидэнд олгодог. Хэн ч эдгээрийг эхээс төрөхдөө эзэмшсэн байдаггүй, тухайн нөхцөл байдлыг мэдэрч, өөрөө оролцож, амьдралын туршид эзэмшдэг. Эдгээр нь хүүхдийн амжилттай суралцах, ажиллахад шаардлагатай төдийгүй насанд хүрээд эцэг

эх болсон үедээ ч хойч үеэ өсгөн торниулахад, өвлүүлэхэд чухал чадварууд юм. Харин эзэмших боломжийг хангахын тулд:

- Бага насны боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрт энэ чадамжуудыг эзэмших боломж, нөхцөлөөр хангасан орчин, үйл ажиллагааг төлөвлөхийн сацуу эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан арга зүйн үйл ажиллагааг зохион байгуулах
- Хүүхдийн нас сэтгэхүй, хувийн онцлогт тохирсон агуулга бүхий үйл ажиллагааг урт, богино хугацааны сургалтын төлөвлөгөөг боловсруулах
- Хүүхдийн хувийн онцлогт тохирсон шаардлагатай, шат дараалсан дэмжлэгийн арга зүйг хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах нь үр ашигтай байдаг.

*Хүүхэд, гэр бүлийн амьдрал дахь дарамт шахалт, сэтгэлийн хямралыг үүсгэх эх сурвалжийг багасгах, арилгах* – Ядуурал, нийгмийн гадуурхал, хүчирхийлэл, оюуны хомсдол зэрэг шалтгаанаас үүдэлтэй удаан хугацаагаар үргэлжлэх, хурц хэлбэрийн дарамт, сэтгэлийн хямрал хүүхдэд болон түүний эцэг эх, асран хамгаалагчид тохиолддог. Урт хугацаагаар үргэлжлэх ийм стресс нь хүүхдийн тархины эрүүл хөгжлийг дэмжих хүч энергийг бууруулдаг. Ийм дарамт, сэтгэлийн хямрал үүсэх шалтгааныг бууруулах нь шууд ба шууд бус байдлаар хүүхдийг хамгаалж байдаг. Стресс, хямралыг бууруулахын тулд:

- Гэр бүлд тогтвортой, харилцан ойлголцсон, дэмжсэн орчныг бүрдүүлж бэхжүүлэх эцэг эх, асран хамгаалагчдын чадварыг сайжруулах,
- Гэр бүлд тогтвортой, харилцан ойлголцсон дэмжлэгтэй орчныг бүрдүүлэх талаар эцэг эх, асран хамгаалагчдад туслах үйлчилгээгээр хангах нь чухал.

Бага насны хүүхдийн хөгжил, боловсролыг дэмжих үйл ажиллагаандаа дараах санаануудыг байнга санаж, харгалзан үздэг байна. Үүнд:

- Хөгжлийн болон суралцахуйн бүх чиглэл чухал ба харилцан бие биедээ нөлөөлж байдаг.
- Хүүхдийн хөгжил ба суралцахуй тодорхой зүй тогтлоор явагддаг.
- Хүүхэд бүрийн хөгжил ба суралцах үйл харилцан адилгүй хурдтай явагддаг.
- Хүүхдийн хөгжил ба суралцахуй нь насан хүрэгчдийн хамтын ажиллагааны үр дүн байдаг.
- Бага насны үеийн танин мэдэхүй, үйлийн туршлага нь хүний хөгжил, суралцах үйлд хүчтэй нөлөөлдөг.

- Хүүхдийн хөгжил нарийн төвөгтэй, билэг тэмдгийн, бодит дүрслэлийн шинжтэй үйл.
- Хүүхэд баталгаатай хамгаалагдсан хамтын ажиллагааны үед идэвхтэй суралцаж, хөгждөг.
- Хүүхэд нийгмийн болон соёлын янз бүрийн баялаг орчинд суралцаж, хөгждөг ба түүний нөлөөлөл хүүхдийн хөгжил, суралцах үйлийг илүү олон талт болгодог.
- Хүүхэд олон янзын аргаар суралцдаг.
- Тоглох нь хүүхдийн өөрийн хөгжих, суралцах үйлийг хөтлөх, хэл яриа, оюун ухаан, нийгэмшихүйн чадвараа дэмжих маш чухал, гол үйл.
- Хүүхдийн хийж буй үйл тэдний мэдлэг, чадварыг сорьсон байх нь хөгжил, суралцахуйг дэмждэг.
- Хүүхдийн хийж буй үйл, улмаар хуримтлуулсан туршлага нь тэдний суралцах, хөгжих сэдэл тэмүүлэл, арга замыг тодорхойлж байдаг.

Эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх боломжтой сургалтын идэвхтэй аргууд байдгийн нэг нь Хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон үйл ажиллагаа (Developmentally Appropriate Practice)–ны арга юм. Хүүхдийн хөгжил, суралцах үйлийн дэмжих гол арга нь тэдний нас сэтгэхүй, хувийн онцлогийг харгалзсан хөгжлийн онцлогт тохирсон үйл ажиллагаа юм. Хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон үйл ажиллагаа гэдэг нь бага насны хүүхдийн сурч, хөгжиж, төлөвших онцлогийн талаарх судалгаанд суурилсан хувь хүүхдийн хөгжлийн онцлог болон бага насны боловсролд идэвхтэй, үр дүнтэй хэрэглэгдэж буй арга барилууд дээр суурилсан багшлах хандлага юм. Энэ нь бага насны хүүхдийн суралцахуй болон хөгжлийг оновчтой, илүү тохиромжтой арга барилаар зохион байгуулах, дэмжих хандлага бөгөөд хүүхдийн хөгжлийг дэмжих ажлын төлөвлөлт, хөтөлбөр, бага насны хүүхдийн хөгжлийн судалгаа шинжилгээний ажлын үндэс суурь нь болох учиртай.

Хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон үйл ажиллагааны зорилго нь хүүхэд нэг бүрийн болон насны бүлгийн суралцахуйн зорилгодоо хүрэхэд нь туслах үйлүүдийн цогц юм. Тэрхүү зорилго нь хүүхэд бүрийн хувьд хүч сорьсон буюу бага зэргийн хүнд боловч чадахуйц байх учиртай.

Хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон үйл ажиллагааг зохион байгуулахад дараах үндсэн 3 ойлголтыг анхаарч авч үздэг. Үүнд:

- i. Хүүхдийн хөгжлийн насны онцлогийг мэдэх хэрэгтэй ба энэ нь судалгаанд суурилсан байдаг ба багшийн үйлийн үр дүнг баримжаалах боломжийг олгодог.

- ii. Хүүхэд нэг бүрийн онцлогийг харгалзсан үйл ажиллагааг боловсруулахад түүнд шаардлагатай байгаа дэмжлэгийг тодорхойлох нь чухал байдаг. Үргэлжилсэн ажиглалт /хүүхдийн тоглох үйл явц, бусадтай болон эд юмстай харилцаж байгаа байдлыг ажиглах/ нь бидэнд тухайн хүүхдийн сонирхол, чадвар, хөгжлийн ахицыг мэдэх боломж олгодог.
- iii. Хүүхдийн гэр бүлийн болон нийгмийн соёлын ялгаатай байдал, түүний үнэт зүйлс, үүнд нөлөөлдөг хүчин зүйлс зэргийг мэдэх нь хүүхдийн гэр бүлийн болоод орчны амьдралыг төсөөлөх, ойлгоход тусалж, үр дүнтэй, уялдаа холбоотой, утга учиртай үйлээр хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглүүлдэг.

Хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон үйл ажиллагаанд баримтлах зарчмууд:

- *Хүүхдийн хөгжлийн тодорхой чиглэлүүдийг дэмжихэд чиглэгдсэн байх.* Нэг хөгжлийн чиглэлд гарч буй өөрчлөлт нөгөө хөгжлийн чиглэлд нөлөөлж байдаг.
- *Хүүхдийн хөгжлийн үе нь тодорхой дараалалтай, урьдчилан таамаглахуйц байдаг учир нь үйл ажиллагаа нь хүүхдийг сорьсон байх.* Хүүхдийн өнөөдөр эзэмшсэн мэдлэг, чадвар нь маргаашийн эзэмших мэдлэг чадварын суурь, урьдач нөхцөл болж байдаг.
- *Үйл ажиллагаа нь зорилго, хэрэглэгдэхүүн, орчин, үр дүнгээрээ хүүхдийн хувийн хэрэгцээнд тохирсон олон янз байх.* Хүүхэд бүрийн хөгжлийн түвшин харилцан адилгүй байх ба нэг хүүхдийн хөгжлийн чиглэл бүрийн түвшин мөн харилцан адилгүй байдаг.
- *Үйл ажиллагаандаа хүүхдийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзах.* Жишээлбэл, хүүхдийн генийн өгөгдөл нь түүний эрүүл өсөлт хөгжлийн урьдал нөхцөл болж болох ч хэрвээ бага насандаа эрүүл, шим тэжээлтэй хоол хүнсээр хангагдахгүй тохиолдолд дээрх генийн өгөгдөл бүрэн биелэхгүй байх нь бий.
- *Үйл ажиллагаа нь хүүхдэд сөрөг дурсамж, туршлагыг үлдээхгүй байх.* Хүүхдийн үзсэн сайхан бүхэн аливааг сайнаар төсөөлөх, сайнаар бодох, эергээр төсөөлөх нөхцөл болдог. Насанд хүрэгчид аливаа эрсдэлийг урьдчилан тооцоолох нь чухал.
- *Үйл ажиллагааны зорилго нь хүүхдийн нас сэтгэхүй, хөгжлийн түвшинд тохирсон байх.* Хүүхэд аливааг энгийнээс хүнд рүү буюу хуучин мэдлэгээ өргөжүүлэх, эсвэл түүнийгээ өөрчилж шинэ мэдлэг бүтээж байдаг.
- Эерэг дулаан, найрсаг орчинг бүрдүүлэх. Хүүхэд халуун дулаан, аюулгүй, орчинд, эерэг харилцааны орчин бүрдсэн нөхцөлд илүү сайн хөгждөг.

- *Үйл ажиллагаагаар нийгмийн бодит, бичил орчинг бүрдүүлсэн байх.* Орчин хэдий чинээ бодит байна, төдий чинээ хүүхэд бодит бэрхшээлтэй тулгардаг.
- *Хүүхэд таньж мэдэхийн хүслээр дүүрэн байдаг ба дэлхий ертөнцийг олон янзын арга замаар танин мэдэж, суралцдаг.* Ийм учраас багшлахуйн олон арга барилыг ашиглаж багш хүүхэдтэй хамтдаа байх нь тэдний суралцах үйлийг идэвхжүүлж байдаг.

Хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон хөтөлбөрийн шинжүүд:

- Хүүхэд суралцах үйлийн идэвхтэй гишүүн байх ба тэдний хөгжлийн цогц байдлыг хангахад чиглэсэн байна.
- Хүүхэд бүр өөрийн хурдаар хөгжих боломжийг бүрдүүлсэн байна.
- Хүүхэд өөрийн үйлийг нээх, таних, судлах үйлээрээ өөрөө хянах, үнэлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл насанд хүрэгч хүүхдийн хийсэн аливаа үйл, ажил сайн болсныг хөндлөнгөөс хянах учиргүй.
- Хүүхдийн үйл түүний одоогийн чадвартай нийцэж байх ба бага зэргийн хүндрэлтэй, чадварыг аажмаар сайжруулж байхаар төлөвлөгдөх учиртай.
- Заан сургасан, сургуульжсан байдлаас татгалзсан байна.

## **ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГТ ТОХИРСОН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ИДЭВХТЭЙ АРГУУД**

Бүтээлч идэвхтэй багш, асран хамгаалагчаас тухайн тодорхой үйлийн нөхцөл байдалд тохирсон, нөхцөл байдалтай уялдсан аргыг сонгож хэрэглэх чадварыг шаарддаг. Энэ үед хүүхэд чухам юуг мэдэж, чадаж байгааг, мөн тэр нөхцөлд юуг мэдэх нь чухлыг мэдэх шаардлагатай байдаг. Хэрвээ насанд хүрэгч уян хатан, ажигч гярхай байж чадвал идэвхтэй аргуудыг тохиромжтой байдлаар сонгож хэрэглэж чадна. Хэрвээ аль нэг сонгосон арга нь үр дүнгээ өгөхгүй бол нөгөө нэг арга нь үр дүнгээ өгч байдаг.

*Хүлээн зөвшөөрөх* – Хүүхдийн хэлж хийж байгаа зүйлийг хүлээн зөвшөөрөх арга. Насанд хүрэгч өөрийн үйл хөдөлгөөн, байр байдал, үг хэлээрээ хүүхдийн хэлж байгаа зүйл, хийж байгаа үйлийг нь хүлээн зөвшөөрч байна гэдгээ ойлгуулах, батлах арга юм. Жишээ нь: “Баярлалаа, Болороо. Зөндөө их зүйл дээр надад тусаллаа.” эсвэл “Нийлбэр нь 5 болно гэдгийг чи өөр аргаар харуулж чадлаа” гэх мэт.

*Урам өгөх, зоригжуулах* – Хүүхдийн хийсэн үйлдлийг зөвхөн магтан сайшаах биш, түүний гаргасан хичээл зүтгэл, тэсвэр тэвчээрийг хэлж, зоригжуулах, урам өгөх арга юм. Жишээ нь: “Чи хүнсний ногоогоор хийж болох маш олон

хоолыг нэрлэж чадлаа. Дараа дараагийн дасгал, тоглоомд яг ийм байдлаар идэвхтэй оролцож байгаарай.”

*Хариу үйлдэл үзүүлэх* – Хүүхдэд ерөнхий байдлаар зөвлөхийн оронд тодорхой, оновчтой хариу өгөх арга юм. Жишээ нь: Хүүхэд элсэн бөмбөгийг шидэж чадахгүй байгаа хүүхдэд “Хүчтэй шид, хүчтэй шид” гэсэн зөвлөгөөг өгөхийн оронд “Элсэн бөмбөг нь бидний тоглодог бөмбөгийг бодвол хүнд жинтэй учраас хүчтэй, сайн түлхэж шидэх хэрэгтэй” гэх мэт.

*Үлгэрлэх* – Шийдвэрлэх гэж байгаа асуудлын талаар бодол, шийдэх аргууд, бусдын зан байдалд үзүүлэх хариу үйлдлийн талаар зүгээр нэг хэлэх бус, өөрийн үйл үйлдэл дээр харуулах арга юм. Жишээ нь: “Аанха, энэ арга нэг л болохгүй байна, яагаад гэдгийг бодох хэрэгтэй болж байна.”, эсвэл “Уучлаарай, Батаа. Би чиний хэлсэн зүйлийн зарим хэсгийг анхаарч сонсож чадсангүй. Надад дахиад нэг удаа давтаад хэлж өгч болох уу” гэх мэт.

*Үзүүлэх* – Зарим нэг зүйлийг яаж зөв аргаар хийхийг хийж үзүүлэх арга юм. Үүнийг зарим нэг тодорхой арга аргачлалаар хийх үйл дээр хэрэглэх нь илүү ач холбогдолтой юм. Жишээ нь: “Ө” үсгийг хэрхэн, ямар дарааллаар бичих гэх мэт.

*Сорих, хүндрүүлэх* – Даалгаврын зорилгыг хүүхдийн чадвараас бага зэрэг хүндрүүлэх, сорих үйл нэмэх, баяжуулах арга юм. Жишээ нь: Хүүхдүүдтэй хамт 10 ширхэг зүйлийг оноож тоолж байсан бол хүндрүүлэхийн тулд холоос харж тоолуулж болох юм. Үүний эсрэг арга нь даалгаврыг хөнгөрүүлэх арга байдаг. Жишээ нь: хүүхэд 10 хүртэл зүйлийг оноож тоолох нь хүндрэлтэй байвал хөнгөрүүлж цөөлөх, гарыг нь барьж, хамт зааж тоолох гэх мэт.

*Асууж, лавлах* – Хүүхдийн бодож буй бодлыг, хийх үйлийг өдөөхийн тулд асуулт тавих арга юм. Жишээ нь: Хэрвээ чи найздаа юу хийхийг хэлж ойлгуулж чадахгүй бол өөр яаж ойлгуулж болох вэ? гэх мэт.

*Дэмжлэг үзүүлэх* – Хүүхэд зорьсон зорилгоо биелүүлэхэд нь дохио өгөх, сануулах, дөхүүлэх байдлаар туслах, дэм өгөх арга юм. Жишээ нь: Хүүхэд үгийн эхний авиа, үсгийг хэлж чадахгүй байвал чиний нэр ямар үсгээр эхэлдэг билээ, гараа алдалсан юм шиг ямар үсэг байдаг билээ гэх мэт.

*Мэдээллээр хангах* – Хүүхдэд шаардлагатай байгаа мэдээлэл, баримт, үг хэллэгийг шууд хэлж өгөх арга юм. Жишээ нь: Энэ урт сүүлтэй, хойд 2 хөл дээрээ зогсдог, зулзагаа өвөр дэх уутандаа хийж явдаг амьтныг минж гэдэг гэх мэт.



**Чиглүүлэх** – Хүүхдийн гаргаж буй зан байдал, хийж буй үйлд зааварчилгаа өгөх арга юм. Жишээ нь: Хүүхэд оноож тоолох үйлийг чиглүүлэхдээ “Чи энэ дүрсэнд хүрээд, тоогоо хэлнэ. Тэгээд дараагийн дүрс рүү шилжинэ” гэх мэт.

### Дүгнэлт

- Бага насны хүүхдийн хөгжил төлөвшилд нийгмийн иргэн бүр тодорхой үүрэг хүлээх учиртай.
- Бага насны хүүхдийн хөгжил төлөвшлийг дэмжихдээ тодорхой зарчмыг баримталж, арга барилаар ажиллах нь эерэг үр дүнд хүрэх боломжийг нээж байдаг.

### Өөрийгөө шалгах асуулт

- Хүрээлэн буй нийгмийн орчин, хүмүүс тэдгээрийн харилцаа бага насны хүүхдийн хөгжил төлөвшилд ямар хамааралтай вэ? Эргэцүүлэн бодож ярилцана уу.



## СЭДЭВ 7

# БНХ-ИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЦОГЦ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## ЦОГЦ ХӨГЖИЛ БАГ

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, улс төр, нийгэм соёлын нөхцөл байдлаас улбаалан төрийн байгууллагуудын хоорондын хамтын үйл ажиллагааг уялдуулах, тодорхой асуудал дээр төвлөрч ажиллах нь нэн тулгамдсан асуудал хэвээр байна. Энэ нөхцөлд тодорхой асуудалд чиглэсэн бичил баг, ажлын хэсгийн зохион байгуулалтад орж ажиллах нь нэг шийдэл юм. Ингэснээр улс төрийн тогтворгүй байдлаас үүдэлтэй богино хугацаанд төлөвлөлт хийх шаардлага, хүн хүч болон санхүүгийн нөөцийн хязгаарлагдмал хомсдолтой нөхцөлийг даван туулах боломжийг бидэнд олгох юм.

Орон нутгийн түвшинд БНХ-ийн эрүүл мэнд, хөгжил, хамгааллын хүрээнд өөрийн онцлог нөхцөл байдалтай холбоотой асуудлууд болон БНХ-ийн хөгжлийн нэн ялгаатай байдал, таргалалт, дэлгэцийн донтолт, хөдөлгөөний дутагдал зэрэг орчин үеийн, глобал шинжтэй шинэ тутам асуудал, бэрхшээл, сорилтуудыг амжилттай шийдвэрлэх нөхцөл бүрдэх юм.

Алдарт зохиолч Салмон Рашди (Salmon Rushdie) нэгэнтээ “Таны амьдралд хамгийн чухал зүйлс таны эзгүйд болоод өнгөрдөг” гэж бичсэн байдаг (*Rushdie, 1981*). Энэ нь орон нутгийн алс хэтийн хөгжлийн чухал асуудлуудад бид бүгд санаа тавин оролцож, нэгдсэн зорилго чиглэлтэй ажиллахын чухлыг илэрхийлж байгаа юм.

### Цогц хөгжил багийг зохион байгуулах (жишээ)

Орон нутгийн түвшинд (аймаг, дүүрэг)-т БНХ-ийн асуудлаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэлтэд оролцогч бүх талуудын төлөөлөлтэй орон нутгийн “цогц

хөгжил” багийг Нийгмийн бодлогын хэлтэс манлайлал дор зохион байгуулж олно. Цогц хөгжил баг БНХ-ийн асуудлаар өөрийн орон нутгийн стратеги төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд манлайлах үүрэг, хариуцлагатай байна. Орон нутгийн стратеги төлөвлөгөө нь багийн гишүүдийг “юуг юуны тулд, хэрхэн хийх вэ” гэдэгт чиглүүлэх баримт бичиг байх юм. Энэхүү стратеги төлөвлөлтийн үйл ажиллагааг 4 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- Бэлтгэл ажил
- Төлөвлөгөө боловсруулах
- Хэрэгжүүлэх
- Үнэлэх

Оролцогч талууд нь 10-15 хүний бүрэлдэхүүнтэй, байнгын бус бүтэц байх бөгөөд дараах нэгж, оролцогч талуудын төлөөлөл байж болно. Үүнд:

- НБХ-ийн дарга – уг багийг ахалж болно
- БСУГ-ын дарга
- ЭМГ-ын дарга
- ГБХЗХГ-ын дарга
- БСУГ-ын СӨБ мэргэжилтэн
- НБХ-ийн төсөл хариуцсан мэргэжилтэн
- НБХ-ийн бусад холбогдох мэргэжилтнүүд
- ГБХЗХГ-ын хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн сум, хорооны нийгмийн хөгжил хамгаалал, СӨБ, эрүүл мэнд хариуцсан мэргэжилтнүүд
- Цагдаагийн газрын Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМГ-ын хоол тэжээл, эх, хүүхдийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
- Мэргэжлийн хяналтын газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Цэцэрлэгийн эрхлэгч, багш, арга зүйч
- Өрхийн эмнэлгүүдийн төлөөлөл
- Төрийн бус байгууллагын төлөөлөл
- Орон нутаг эцэг эхийн төлөөлөл
- Орон нутгийн иргэдийн төлөөлөл

Энд Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газрын СӨБ хариуцсан мэргэжилтнүүдийн манлайлал, хамтын ажиллагаа чухал болохыг онцгойлон анхаарвал зүйтэй.

## СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Судлаачдын (*Olsen & Eadie, 1982*) тодорхойлсноор стратеги төлөвлөгөө гэдэг нь аливаа баг/байгууллагыг юуны тулд, яаж, хэрхэн ажиллахыг тодорхойлох, үйл ажиллагааг чиглүүлэх зорилготой цогц арга зүй юм. Өөрөөр хэлбэл стратеги төлөвлөгөө нь багийн манлайлагч болон гишүүд, оролцогчдод юуг, юуны тулд, хэрхэн хийх вэ гэдгийг ойлгоход нь тусалдаг (*Bryson, Crosby, & Bryson, 2009*).


Бидний сургалтын жишээн дээр авч үзвэл, цогц хөгжил багийн үйл ажиллагааны үндсэн баримт бичиг нь стратеги төлөвлөгөө бөгөөд дараах зорилтуудыг агуулж болох юм. Үүнд:

- Стратегийн ач холбогдол бүхий асуудлуудын хүрээнд мэдээлэл цуглуулах, шинжлэх, дүгнэх, түүнд тулгуурлан боломжит шийдвэр гаргах хувилбаруудыг тодорхойлох.
- Голлох оролцогч талуудад эрхэм зорилго, хэрэгжүүлэх арга зам, зорилт, үйл ажиллагааны хүрээнд баримт, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад нь туслах.
- Цогц хөгжил багт одоогоор үүсээд байгаа эсвэл алс хэтдээ тулгамдаж болох асуудлуудыг олж харах, тодорхойлох, шийдвэрлэх.
- Зорилгод чиглэсэн багийн үйл ажиллагаагаар дамжуулан цогц хөгжил багийн гишүүдийн тасралтгүй хөгжлийг хангах.
- Онцгой, цаг хугацаанаас хамааралгүй, хамтаар хүлээн зөвшилцөж нийтлэг үнэт зүйлийг бүтээх.

## СТРАТЕГИЙН УДИРДЛАГА

Стратегийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх, явц болон үр дүнг үнэлэх тасралтгүй үргэлжлэх үйл явцыг стратегийн удирдлага хэмээн ойлгоно. Стратегийн удирдлага нь Зураглал 10-д үзүүлсэнчлэн 5 үндсэн үе шатыг дамжин хэрэгжинэ. Төлөвлөлт нь эхний 3 үе шатыг хамарч байгаагаараа стратегийн удирдлагын нэн чухал хэсэг болохыг тодруулж байна.

### ЗУРАГЛАЛ 9. Стратегийн удирдлагын бүтэц



Тиймээс хүрэх үр дүнгийн 80 хувь нь үйл ажиллагааны 20 хувиас хамаардаг гэх буюу Паретогийн зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл төлөвлөлтийн үе шатны нийт үйл ажиллагаанд эзлэх хувь хэмжээ бага мэт боловч эцсийн үр дүнд үзүүлэх нөлөө нь маш их байдаг.

Цаашид бид дээрд зурагласан 5 үе шатны дагуу стратеги удирдлагын бүтэцтэй танилцах болно. Түүнчлэн эдгээр 5 үе шаттай тохирох ABCDE загварыг Хавсралт 3-аас харж, ашиглаж болно.

#### Дүгнэлт

- Стратегийн удирдлага нь орчны шинжилгээ, эрхэм зорилго, зорилгуудыг тодорхойлох, стратегийг шинжлэн сонгох, стратегийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж үнэлэх гэсэн 5 үндсэн хэсгээс бүрдэнэ.
- Стратегийн төлөвлөлт нь цогц хөгжил багийн хүн хүч, хэлхээ холбоо, эрх мэдэл, цаг хугацаа, хөрөнгө мөнгө зэрэг нөөцөө эрхэм зорилгод оновчтой чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

#### Өөрийгөө шалгах асуулт

- Стратегийн удирдлагын үе шатыг өөрийн амьдралын, үйл ажиллагааны жишээн дээр тайлбарлана уу? Ярилцана уу.

### ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээ нь стратегийн удирдлагын эхний үе шат юм. Орчны дүн шинжилгээнд тулгуурлан байгууллагын эрхэм зорилгыг тодорхойлох, үйл ажиллагааны стратеги боловсруулах, зорилгуудыг тодорхойлох үндэс суурь болдог. Орчны шинжилгээг цогц хөгжил багийн гадаад, дотоод хүрээнд хийнэ.

Орон нутгийн цогц хөгжил баг өөрийн гэсэн өвөрмөц дотоод, гадаад орчинтой тул тэдгээр орчинд тохирч нийцсэн үйл ажиллагаа хэрэгжих болно. Орчиндоо нийцээгүй үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэх нь хүн хүч, цаг хугацаа, хөрөнгийн нөөцийг ач холбогдолгүй үрж тараасан, ач холбогдол багатай төдийгүй багийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх талтай. Тиймээс орчноо сайтар судалж тодорхойлох нь стратегийн удирдлагын нэн тэргүүний, чухал алхам юм.

**ЦОГЦ ХӨГЖИЛ БАГИЙН ГАДААД ОРЧИН.** Цогц хөгжил багийн тогтвортой оршин тогтнохын утга учир болох эрхэм зорилгынхоо төлөө үйл ажиллагаа явуулах, үүний тулд гадаад орчноосоо дэмжлэг, нөөц олж авах, харилцаж хамтран ажиллахын зэрэгцээ эргээд гадаад орчиндоо ашиг тусаа өгдөг зүй тогтолтой юм. Тиймээс гадаад орчноо сайтар судлан шинжилж таньж мэдэх шаардлагатай.

Гадаад орчныг судлан шинжлэхэд дөхөм байх үүднээс цогц хөгжил багт үзүүлж буй нөлөөлөлд үндэслэн 1) макро орчин; 2) шууд хүрээллийн гэж 2 хуваан авч үзэж шинжилнэ.

Цогц хөгжил багийн тухайд макро орчин нь улс орны болон орон нутгийн эдийн засаг, хууль эрх зүй, улс төрийн нөхцөл байдал, нийгэм соёлын онцлог, шинжлэх ухаан технологийн орчин үеийн хандлага зэрэг юм. Эдгээр макро орчны бүрэлдэхүүн хэсгүүд нь хоорондоо нягт уялдаатай харилцан үйлчлэлд оршдог. Гэхдээ цогц хөгжил багт үзүүлэх нөлөөлөл, ач холбогдол нь харилцан адилгүй байж болно.

Харин *шууд хүрээлэлд* бидэнд шууд нөлөөлдөг, эргээд бид хариу нөлөөлж болох гадаад орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаан авч үзнэ. Бидний жишээн дээр орон нутаг, тойргийн бага насны хүүхэд, эцэг эх, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагууд, зэргийг авч үзэж болно.

**ЦОГЦ ХӨГЖИЛ БАГИЙН ДОТООД ОРЧИН.** Энэ нь цогц хөгжил багийн оршин тогтнох хүчний эх сурвалж, дотоод орчин болно. Учир нь цогц хөгжил баг цаг хугацаа, саад бэрхшээлийг даван туулж зорилгынхоо төлөө ажиллах хүч, нөөц энергийг бүрдүүлж ажиллах учиртай. Цогц хөгжил баг нь дотоод орчноо сайтар танин мэдэж, зөв удирдан чиглүүлээгүй тохиолдолд амжилтад хүрэхэд бэрхшээлтэй байх болно.

Цогц хөгжил багийн дотоод орчинд хүний нөөц, санхүүгийн эх үүсвэр, үйл ажиллагаа, дотоод соёл, харилцааны уур амьсгал, зохион байгуулалт зэргийг багтаан авч үзнэ.

## Дүгнэлт

- Орчны шинжилгээ нь гадаад (шууд хүрээлэл болон макро түвшний) болон дотоод орчинд хийгдэх бөгөөд стратеги төлөвлөлтөд нэн түрүүний алхам болдог.

## Өөрийгөө шалгах асуулт

- Цогц хөгжил багийн гадаад болон дотоод орчинд юуг багтаан авч үзэх вэ? Яагаад?
- Танай орон нутгийн цогц хөгжил багийн макро орчин, шууд хүрээлэлд юуг зайлшгүй хамран авч үзэх шаардлагатай байна вэ?

## АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ

**ЦОГЦ ХӨГЖИЛ БАГИЙН АЛСЫН ХАРАА.** Хүрэх ёстой цэгээ дүрслэн томъёолсон алсын хараатай байж түүнийгээ өдөр тутмын үйл ажиллагаа, хамтын ажиллагааныхаа баримжаа болгохгүйгээр цогц хөгжил баг оршин тогтнох боломжгүй юм. Цогц хөгжил багийг алс холын далайн аялалд яваа хөлөг онгоцны багийн гишүүд гэж төсөөлбөл луужингийн тасралтгүй зааж буй очих зүг бол алсын хараа болох юм.

*Жишээ: Цогц хөгжил багийн алсын хараа - Салбар дундын нягт хамтын ажиллагаагаар бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, хамгааллыг цогцоор дэмжих.*

Цогц хөгжил баг нэгэн зорилгод нэгдсэн боловч гишүүд нь өөр өөрийн зорилготой, тодорхой асуудлыг шийдэхээр багт нэгдсэн гэдгийг мартаж болохгүй. Энэ нь алсын харааг хэр оновчтой тодорхойлж, түүнийгээ хамтын ажиллагаа, харилцаан дээрээ ямагт санаж ажиллаж чадвал цогц хөгжил багийн болон оролцогч талуудын зорилго аяндаа биелэх учиртай.

Цогц хөгжил баг эрхэм зорилгоо оновчтой тодорхойлсноор баг юуны төлөө оршин буй нь тодорхой болно. Түүнчлэн эрхэм зорилго нь цогц хөгжил багийг яагаад байгуулах болсон, юуны тулд оршин тогтнож юунд, хэнд үйлчилж байна вэ? гэдгийн утга учир юм. Эрхэм зорилго нь харьцангуй тогтвортой бөгөөд төдийлөн өөрчлөгдөөд байх шаардлагагүй.

Энд мөн алсын харааны нэгэн адилаар цогц хөгжил багийн эрхэм зорилго орон нутгийн удирдлага, Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн хэлтэс, Эрүүл мэндийн төв, цэцэрлэг, хүүхэд, эцэг эх болон бусад оролцогч

талуудын хүсэл сонирхолтой нийцэж, огтлолцлын цэг болж байх учиртай. Ингэснээр эрхэм зорилго нь цогц хөгжил багийн хамтын үйл ажиллагаа, зорилгод чиглэсэн уур амьсгалыг үүсгэнэ.

Цогц хөгжил багийн алсын хараа, эрхэм зорилго тодорхойлохтой зэрэгцэн үнэлэмж, итгэл үнэмшил, үйл ажиллагаандаа баримтлах суурь зарчим зэргийг тогтоно. Үйл ажиллагааны чиглэлээс хамааран үнэт зүйл нь ялгаатай байна. Тухайлбал, сургалтын байгууллага эрдэм мэдлэг, хөгжил дэвшил, ёс суртахуун, үлгэр жишээ зэргийг үнэт зүйлс хэмээн үзэж байхад худалдааны байгууллага илүү хэрэглэгчдэдээ баримжаалсан, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт анхаарсан үнэт зүйлстэй байдаг. Харин үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага технологид чиглэсэн үнэт зүйлтэй байж болдог.

*Жишээ: Цогц хөгжил багийн эрхэм зорилго - Салбар дундын нягт хамтын ажиллагаагаар бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, хамгааллыг цогцоор дэмжих.*

*Жишээ: Цогц хөгжил багийн үнэт зүйл -*

- *Хувийн үзэл бодол, хандлагаас хамааралгүй, албан харилцаанд тулгуурласан багийн ажиллагаа*
- *Бага насны хүүхдэд оруулж буй хөрөнгө оруулалт бол орон нутгийн ирээдүйд оруулж буй хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт мөн*
- *Бага насны хүүхдийн хөгжлийг цогцоор харах хандлага*
- *Бага насны хүүхдийн хөгжлийн төлөө нэгэн зүгт сэтгэл, итгэл, зүтгэл*

### Дүгнэлт

- Цогц хөгжил багийн алсын хараа нь тодорхой хугацааны дараа бидний бий болгохыг хүсч буй төлөв байдлыг илэрхийлдэг бол эрхэм зорилго нь юу хийх вэ гэдэгт хариулдаг.
- Цогц хөгжил багийн эрхэм зорилго нь оролцогч талуудын зорилгыг нэгтгэсэн, цогц байдалтай томъёологддог бөгөөд бидний хамтын ажиллагааны утга учрыг илэрхийлэх учиртай.
- Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл нь багийг нэгтгэх үүргийг гүйцэтгэдэг.

### Өөрийгөө шалгах асуулт

- Цогц хөгжил багийн эрхэм зорилго гэж юу вэ?
- Цогц хөгжил багийн алсын хараа болон эрхэм зорилгын мөн чанар, ялгааг өөрийн цогц хөгжил баг дээр тайлбарлана уу?



- Манай орон нутгийн цогц хөгжил багийн эрхэм зорилго оролцогч талуудын ашиг сонирхол, зорилготой хэрхэн уялдаж байгаа вэ?

## SWOT ШИНЖИЛГЭЭ

**SWOT – ДАВУУ ТАЛ, СУЛ ТАЛ, БОЛОМЖ, АЮУЛ ЗАНАЛ.** Орчны хүчин зүйлс, нөхцөл байдлыг шинжилдэг хамгийн түгээмэл, гадаад дотоод орчныг цогцоор авч үзэх арга нь SWOT шинжилгээ юм. Уг шинжилгээгээр цогц хөгжил багийн давуу тал (S), сул тал (W), боломж (O), аюул занал (T)-ыг тодорхойлох боломжтой. Энэхүү шинжилгээний давуу тал нь орчны хүчин зүйлс, нөхцөл байдлыг дан ганц тодорхойлоод зогсохгүй цаашид авч хэрэгжүүлэх стратегийг боловсруулахад дөхөм болдог.

Гэхдээ давуу тал, боломжийг тодорхойлоод хэрэглэхгүй, сул тал, аюул заналыг тодорхойлоод даван туулах арга хэмжээ авахгүй бол чиглэсэн үр дүндээ хүрч чадахгүй. Өмнөх туршлагуудыг харж байхад SWOT шинжилгээний эхний алхамас цааш юу хийх талаар авч үзээгүйгээс алдаа гарч стратегийн удирдлага амжилттай хэрэгжихгүй байна (Хүснэгт 6-аас харна уу).

SWOT шинжилгээг хийх эхний алхам бол хэн бүхний мэддэг давуу тал, сул тал, боломж, аюул заналыг тодорхойлох үйл ажиллагаа юм.

**ХҮСНЭГТ 6. SWOT шинжилгээний матриц**

Дотоод орчин, одоо цагт	<b>Давуу тал</b> Дэд бүтэц Сайн туршлага Удирдлагын тогтвортой байдал Хүний нөөцийн чадавх гэх мэт	<b>Сул тал</b> Залуу боловсон хүчин Нийслэл хотоос алслагдмал байдал Ундны усны хангамж гэх мэт
Гадаад орчин, ирээдүй цагт	<b>Боломж</b> Бусад аймаг, орон нутагтай хамтран ажиллах боломж Орон нутгийн уул уурхай, үйлдвэр, ААН-ээс дэмжлэг авах гэх мэт	<b>Аюул занал</b> Ган зудын зэрэг гэнэтийн давагдашгүй хүчин зүйлд төсөв санхүү хуваарилагдах Сонгуулиас шалтгаалан удирдлага, бодлого солигдох гэх мэт

Цогц хөгжил багийн гишүүд 4 багт хуваагдаж, тус тусдаа “Оюуны дайралт”-ын аргаар SWOT шинжилгээний эхний үе шатыг хийвэл зохино. Оюуны дайралт (*Brain Storm*)-ын арга нь нэгдүгээрт оролцогч талууд дэвшүүлсэн

асуудлын хүрээнд харилцан асуулт, шүүмж тавихгүйгээр дан шийдэл, санал цуглуулах, хоёрдугаарт цугларсан шийдэл, саналуудыг хамтран үнэлэх үе шатнаас бүрддэг бүтээлч хэлэлцүүлгийн арга юм. Энэ үе шатанд дараах асуудлуудыг анхаарууштай. Үүнд:

- *SWOT* шинжилгээ хийхдээ Цогц хөгжил багийн эрхэм зорилго, зорилтууд, үйл ажиллагааны хүрээгээр хязгаарыг тогтоож, аажмаар өргөсөх, эсвэл төөрөгдөх нөхцөл үүсдэгийг анхаарах.
- Зарим нөхцөлийг давуу тал уу, боломж уу гэдгийг ялгахад төвөгтэй нөхцөл үүсвэл гадаад, дотоод орчны аль нь болох, одоо цагт уу, ирээдүйд байна уу гэдгийг тодорхойлох.
- Зарим тохиолдолд боломж нь аюул занал болж хувирах, аюул занал нь давуу тал болж хувирах нөхцөл байдлууд байдгийг анхаарах зэрэг болно.

**БОЛОМЖ БА АЮУЛ ЗАНАЛХИЙЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ.** Аюул занал ба Боломж нь тоочоод байвал заримдаа хэт өргөн хүрээтэй байдаг тул зарим талаар хязгаарлалт хийж өгөх хэрэгтэй. Үүний тулд Цогц хөгжил багт хэр зэрэг ач холбогдолтой вэ? гэдгээс үүдэн нарийвчилсан шинжилгээ хийж болно.

ХҮСНЭГТ 7. Боломжийн шинжилгээ				
Хүчтэй		Боломжоос цогц хөгжил багт үзүүлэх нөлөөлөл		
		Дунд зэрэг	Бага	
Боломжийг ашиглаж чадах магадлал	Өндөр	1	2	3
	Дунд зэрэг	4	5	6
	Бага	7	8	9

- 1, 4, 2 дугаар талбайд байгаа боломжууд нь цогц хөгжил багт чухал ач холбогдолтой бөгөөд нэн түрүүнд заавал ашиглах хэрэгтэй.
- 8, 6, 9 дугаар талбайд байгаа боломжууд нь цогц хөгжил багт төдийлөн ач холбогдолгүй учир хойш тавьж болно.
- 7, 5, 3 дугаар талбайд үүсч байгаа боломжуудыг ашиглах эсэхийг нэгжийн хүний нөөц, цаг хугацаа, хөрөнгө мөнгөнөөс хамааран шийдвэл зүйтэй.

**ХҮСНЭГТ 8. Аюул заналын шинжилгээ**

		Аюул заналаас цогц хөгжил багт үзүүлэх нөлөөлөл			
		Онцгой хүндрэл учруулна	Ноцтой хүндрэл учруулна	Хүнд байдалд оруулна	Бага зэрэг хүндрэл учруулна
Аюул занал учрах магадлал	Өндөр	1	2	3	4
	Дунд зэрэг	5	6	7	8
	Бага	9	10	11	12

- 1, 2, 5 дугаар талбайд байгаа аюул заналуудад нэн түрүүнд анхаарал хандуулж арилгах талаар арга хэмжээ авах шаардлагатай.
- 3, 6, 9 дүгээр талбайд байгаа аюул заналууд цогц хөгжил багийн анхаарлын төвд байх учиртай бөгөөд боломж гарах үед саармагжуулах, арилгах арга хэмжээ авбал зохино.
- 10, 7, 4 дүгээр талбайд байгаа аюул заналуудыг судалж хяналтдаа байлгаж саармагжуулах арга хэмжээ авах нь зүйтэй.
- 11, 8, 12 дугаар талбайд байгаа аюул заналуудыг шийдэх гэж нөөц хуваарилах шаардлагагүй бөгөөд анхаарч ажиллахад л болно.

Ийнхүү боломж болон аюул заналын үнэлгээ хийж дууссан бол цааш TOWS шинжилгээ рүү шилжинэ.

**TOWS**

*SWOT* болон боломж, аюул заналхийллийн шинжилгээг үр дүнтэй, бүтээлчээр хийвэл орчны шинжилгээний дараагийн алхам, үе шатууд харьцангуй хялбархан явах учиртай. Энд мөн Паретогийн зарчим үйлчилнэ.

Нэн түрүүнд *SWOT* шинжилгээний үр дүнг *TOWS* шинжилгээний харгалзах нүдэнд авчирч байрлуулна. Ингэхдээ боломж, аюул заналыг шинжилгээний үр дүнг харгалзаж эрэмбэлнэ.

**ХҮСНЭГТ 9. TOWS шинжилгээний матриц**

	Боломж	Аюул занал
		1. 2. ...
Давуу тал 1. 2. ...	A	B

Сул тал	C	D
1.		
2.		
...		

*TOWS* шинжилгээний дараагийн алхам бол боломж, аюул занал, давуу тал, сул талын огтлолцлыг тодруулна. Эдгээр огтлолцлын тодруулж буй нүднүүд дараах уялдаа холбоог үүсгэнэ. Үүнд:

*Нэгдүгээрт*, манай цогц хөгжил баг давуу талаа хэрхэн ашиглах, хоёрдугаарт, давуу талаа ашиглан боломжоос үр ашиг гаргаж авах стратеги боловсруулна. Өөрөө хэлбэл давуу талаа ашиглан гадаад орчинд үүсч байгаа боломжийг үр дүнтэй ашиглахад оршдог.

*Хоёрдугаарт*, баримтлах стратеги нь цогц хөгжил багийн давуу тал буюу хүч чадал, нөөцөө оновчтой ашиглан аюул заналыг сааруулах, арилгахад оршино.

*Гуравдугаарт*, гадаад орчинд үүсч байгаа боломжийг ашиглан цогц хөгжил багийн сул талыг нөхөх, даван туулах үйл ажиллагааг төлөвлөнө.

*Дөрөвдүгээрт*, цогц хөгжил баг нь ямар нэгэн сул тал, аюул заналын эрсдэл, хохирлыг нэмэгдүүлэх бий гэдэг үүднээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллана.

### Дүгнэлт

Орчны шинжилгээ хийдэг аргуудаас хамгийн түгээмэл, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нь *SWOT* шинжилгээний арга бөгөөд эхний үе шатыг бүтээлч, үр дүнтэй хийхээс дараа дараагийн үе шатууд их хамаарна.

### Өөрийгөө шалгах асуулт

*SWOT* шинжилгээнээс өөр орчны шинжилгээний арга мэдэх үү? Ялгаа, давуу, сул талыг тайлбарлана уу?

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

Үйл ажиллагааны стратеги нь хувьсан өөрчлөгдөж буй орчинд Цогц хөгжил баг ямар аргаар, ямар үйлдэл, үйл ажиллагаагаар тавьсан зорилгодоо хүрэх вэ? гэдэг асуултад хариулт болдог. Иймээс үйл ажиллагааны стратеги нь урт хугацааг баримжаалсан тоон бус, харин чанарын хандлага бөгөөд хүрэх ёстой төлөв байдалд тэмүүлэх дотоод хүчийг өөртөө агуулдаг. Өөрөөр хэлбэр стратегийг баримтлах ерөнхий чиг шугам гэж ойлгож болно.

Үйл ажиллагааны стратегийг сонгоход багийн эрхэм зорилгоос эхэлж цаашлаад оролцогч талуудын сонирхол, нөөц, хүртээмж, чадвар, боломж, цаг хугацаа зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй. Юутай ч энэ бүхний эцэст бид сонгосон үйл ажиллагааны стратегиа дараах 3 шалгуураар үнэлнэ.

- Стратеги нь орчин нөхцөлтэй хэр нийцэж байна вэ?
- Стратеги нь бидний боломж, нөөцөд хэр нийцэж байна вэ?
- Сонгосон стратегийн эрсдэл нь бидний хувьд даван туулж болохуйц байна уу? Өөрөөр хэлбэл стратеги хэрэгжээгүй тохиолдолд бидэнд ямар муу үр дагаврууд ирэх вэ? Эдгээрийг бид даван туулж чадах уу?

Бид бага насны хүүхдийн хөгжлийг цогцоор дэмжиж ажиллахаар төлөвлөж байгаа учраас үйл ажиллагааны стратегийн чиглэлээ дараах хүрээнд тодорхойлж болно. Үүнд:

- Эрүүл мэнд
- Хоол тэжээл
- Хамгаалал
- Боловсрол

Энд TOWS шинжилгээнээс гарсан үр дүн их чухал.

### Дүгнэлт

Стратегийг сонгох, хэрэгжүүлэх нь цогц хөгжил багийн стратегийн удирдлагын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Бид сонгосон стратегиа наанадаж 3 шалгуураар үнэлэх шаардлагатай.

### Өөрийгөө шалгах асуулт

Бидний хэрэгжүүлэх стратегиуд нь шалгууруудыг хангаж байгаа юу?

## ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### ЦОГЦ ХӨГЖИЛ БАГИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.

Алсын хараа, эрхэм зорилго нь цогц хөгжил багийн оршин байгаагийн утга учрыг илэрхийлэх бол, харин зорилго нь байгууллага товлосон хугацааны дараа хүрсэн байхыг эрмэлзэж байгаа төлөв байдал, үр дүнг илэрхийлдэг. Тиймээс хэсэг хугацааны дараа цогц хөгжил багийн хамтын ажиллагааны үр дүнг үнэлэхэд баримтлах шалгуур нь зорилго байх болно. Эндээс үүдэн зорилгыг Урт хугацааны зорилго болон Богино хугацааны зорилго гэж

тодорхойлно. Богино хугацаа гэдэгт ихэвчлэн 1 жил, урт хугацаанд 2-3 жилийн дараа хүрсэн байх үр дүнг багтааж ойлгодог.

Нэн түрүүнд цогц хөгжил багийн урт хугацааны зорилго, дараа нь богино хугацааны зорилгыг тодорхойлсноор үйл ажиллагаа, хөрөнгө нөөц, хүн хүч, цаг хугацааг юунд чиглүүлэх ёстой нь илэрхий, ойлгомжтой болно. Өөрөөр хэлбэл цогц хөгжил багийн зорилго нь бидний хамтын үйл ажиллагаа юунд чиглэх вэ, ямар үр дүнд хүрэх вэ гэдгийг илтгэнэ.

Аль ч түвшинд зорилго тодорхойлоход дараах шаардлагуудыг баримталдаг. Үүнд:

- Хүрэхэд хэтэрхий хялбар биш, хэрэгжих боломжгүй, хэт хүнд биш, *Хүрэх боломжтой* байх;
- Нөхцөл байдалтай уялдан *Уян хатан* байх;
- Зорилгод хүрсэн эсэхийг ямар нэгэн арга, шалгуур, хэмжээсээр *Хэмжих боломжтой* байх;
- Зорилго нь нэг утгатай, *Тодорхой*, ямар үр дүнд ямар хугацаанд хүрэх, тухайн ажлыг хэн хариуцах нь тодорхой байх;
- Цогц хөгжил багийн эрхэм зорилго, зорилтууд хоорондоо *Зохицол, нийцэлтэй*, залгамж чанартай байх;
- Зорилго нь цогц хөгжил багийн оролцогч талуудын үйл ажиллагаатай зөрчилгүй, ойлгомжтой, *хүлээж авахуйц* байх.

Энэ бүхний эцэст цогц хөгжил багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (1) орчны шинжилгээ, хэлэлцүүлгийн үр дүн, (2) SWOT, TOWS шинжилгээний үр дүн, (3) орон нутгийн дэд хөтөлбөр, холбогдох баримт бичиг, төлөвлөгөө зэрэгт тулгуурлан боловсруулна.

### Дүгнэлт

Цогц хөгжил багийн зорилго нь тодорхой хугацааны дараа хүрэх төлөв байдал, үр дүн бөгөөд урт болон богино хугацаанд тодорхойлогддог.

Зорилгуудыг тодорхойлохдоо тодорхой шаардлагуудыг баримталдаг.

### Өөрийгөө шалгах асуулт

Бидний зорилго нэг бүрчлэн 6 шаардлагыг хангаж байгаа юу?

## СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БА ҮНЭЛЭХ

Урьдчилан тодорхойлсон, онц ач холбогдол, утга агуулга бүхий асуудлуудыг нэн түрүүнд сонгон авч шийдвэрлэх нь стратегийн хэрэгжүүлэлт юм. Үйл ажиллагааны стратегиудыг үр дүнтэй хэрэгжүүлснээр цогц хөгжил багийн тавьсан зорилгодоо хүрч чадна. Практик дээр стратегийн шинжилгээ дутуу, буруу хийснээс, стратегийн алмуудыг оновчгүй сонгосон, дотоод, гадаад нөөцөө бүрэн дайчлан ажиллаж чадаагүй эсвэл орчин, хүчин зүйлсэд урьдчилан харах боломжгүй байсан томоохон өөрчлөлт, эрсдэл гарснаас стратеги амжилтгүй болох талтай.

Өмнө өгүүлснээр урт болон богино хугацаанд хийх ажил үүрэг, хуваарь байдалтай төлөвлөснөөр стратегийг хэрэгжүүлэхэд дөхөм болно. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг харгалзан анхаарч үзэх нь зүйтэй. Үүнд:

- Оролцогч талууд нэгэн зүгт сэтгэлтэй, цогц хөгжил багийнхаа стратегийг дэмждэг, түүнд үнэнч байх нь чухал. Өөрөөр хэлбэл стратегийг надад хамаатай зүйл, бид бүгдэд хамаатай, бидний үйл хэрэг гэсэн үзэл бодол, хандлага оролцогч талуудад гүн бат төлөвшсөн буюу бидний итгэл үнэмшил болсон байх.
- Оролцогч тал бүр өөрийн салбартаа, ажил мэргэжилдээ эзэн байх нь стратеги хэрэгжих үндсэн нөхцөл болно.
- Шаардлагатай нөөцийг (хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө гэх мэт) тооцоолох, бүрдүүлэх, төвлөрүүлэх, ашиглах механизмыг тодорхой болгох нь стратегийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц хөгжил баг нь дараах арга замуудыг ашиглан төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Стратеги төлөвлөгөө нь байгууллага, нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа хэлбэрээр хэрэгжинэ. Тухайн байгууллага, мэргэжилтнүүд цогц хөгжил багийнхаа зорилгод чиглэсэн үйл ажиллагаанд идэвхтэй хамтран ажиллах, бие биеэ дэмжих нь чухал юм. Жишээ нь: Эрүүл мэндийн төвөөс санаачилсан ажил нь эцэг эх, хороо, багийн удирдлагын оролцоонд тулгуурлаж болно.
- Цогц хөгжил багийн зорилтуудыг өөрийн байгууллага, нэгжийн үйл ажиллагаатай уялдуулах замаар ажиллах явдал юм. Жишээ нь Нийгмийн бодлогын хэлтэс цогц хөгжил багийн зорилгын хүрээнд стратеги үйл ажиллагааг байгууллагынхаа жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж болно.

- Дээрээс доош чиглэсэн хэлбэрээр зарим үйл ажиллагааг хэрэгжүүлж болно. Жишээлбэл стратегийн үйл ажиллагааг Аймаг, дүүргийн засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулж эсвэл тусгуулж ажиллаж болно.
- Мөн доороос дээш чиглэсэн санаачилга хэлбэрээр хэрэгжүүлж болно. Жишээлбэл цэцэрлэгүүд цогц хөгжил багийн зорилгын хүрээний асуудлыг нэгэн дуу хоолойтойгоор санал болгож сум, багийн засаг даргаар дамжуулан аймаг, дүүргийн ажилд тусгуулж болох юм.

Ийнхүү стратегийн үйл ажиллагааг зарим тохиолдолд байгууллага, нэгжүүд тус тусдаа, зарим тохиолдолд хамтран хэрэгжүүлэх боловч үнэлгээг нэгдсэн байдлаар хийнэ. Үнэлгээний ажлыг цогц хөгжил багийн манлайлагчид шаардлагатай оролцогч талуудын хамт ажлын тайлан уулзалт, хэлэлцүүлгийн хэлбэрээр хийж болно. Энд орон нутаг, цогц хөгжил багийн онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй.

Цогц хөгжил багийн зорилгын хэрэгжилтийг хянаж, үнэлэхдээ дараах 4 алхмын хүрээнд ажиллаж болно. Үүнд:

- Юуг, ямар үзүүлэлтээр хянаж, үнэлж шалгахыг тодорхойлох;
- Урьдчилан тодорхойлсон шалгуур (стандарт, норм, эталон үзүүлэлт байж болно)-ыг ашиглан хэрэгжилтийн төлөв байдлыг үнэлж дүгнэлт гаргах;
- Хяналт, үнэлгээний үр дүнд ямар нэгэн алдаа, дутагдал буюу төлөвлөсөн ажил, түүний шалгуур болон бодит байдлын хооронд зөрүү илэрсэн тохиолдолд түүний шалтгааныг тодруулах;
- Шаардлагатай бол илрүүлсэн зөрчил, дутагдал, алдаа зөрүүг засан залруулах зэрэг юм.

Дээрх 4 алхмыг гүйцэтгэснээр стратегийн хэрэгжилт нь цаашид ирээдүйтэй эсэх, түүнийг үргэлжлүүлснээр цогц хөгжил баг болон оролцогч талууд, орон нутаг зорилгодоо хүрч чадах эсэх талаар дүгнэлт хийнэ.

Эцэст нь үнэлгээг цогц хөгжил багийн зорилтуудын хүрээнд гүйцэтгэлийг хувиар илэрхийлж болох ч чанарын үнэлгээний ач холбогдлыг орхигдуулж болохгүй. Чанарын үнэлгээний дүнд аль зорилтууд ямар шалтгааны улмаас амжилттай биелсэн, эсвэл биелээгүй нь тодорхой болно.



## ДЭЛГЭРҮҮЛЭН УНШИХ НОМ ЗҮЙ

ЭМЯ, НҮБХС, НЭМХ. (2002). Монголын хүн амын хоол тэжээлийн байдал, үндэсний II судалгааны тайлан, НЭМХ, Улаанбаатар хот.

ЭМЯ, НҮБХС, НЭМХ. (2006). Монголын хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдал, үндэсний III судалгааны тайлан, НЭМХ, Улаанбаатар хот.

ЭМЯ, НҮБХС, НЭМХ. (2011). “Монголын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний IV судалгааны тайлан, НЭМХ, Улаанбаатар хот.

ЭМЯ, НҮБХС, НЭМҮТ. (2017). “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний V судалгааны тайлан, НЭМҮТ, Улаанбаатар хот.

ҮСХ, НҮБХС. (2015). Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа -2013, судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар хот.

WHO. (2009). Infant and young child feeding. World health organization, Geneva.

WHO & UNICEF. (2008). Indicators for assessing infant and young child feeding practices part 2: measurement. World health organization, Geneva.

WHO & UNICEF. (2010). Indicators for assessing infant and young child feeding practices part 2: measurement. World health organization, Geneva.

Bhutta Z.A., Das JK., Rizvi A. et al. (2003). Evidence-based intervention for improvement of maternal and child nutrition: what can be done and at what cost? Lancet; 382:452-477.

WHO. (2003). Infant and young child feeding strategy, WHO, Geneva.

Global Nutrition Report. (2014). Nourishing the SDGs. Bristol, UK: Development Initiatives. НҮБ-ын Хүүхдийн сан. Эцэг эхэд зориулсан гарын авлага

Dwyer, J. (1997). Дархлаажуулалт: хамгийн чухал эргэлт. Хүүхэд бүхэн. Дугаар 1, Vol. 3.

Favin, M., Naimoli, G. And Sherburne, L. (2004). Зан үйлийг өөрчилж эрүүл мэндийг сайжруулах: эрүүл ахуйг түгээн дэлгэрүүлэх үйл явцын гарын авлага.

АНУ-ын ОУХөгжлийн Агентлаг. Орчны эрүүл мэндийн төсөл. Хамтарсан нийтлэл 7. Вашингтон, Дэлхий эрүүл мэндийн товчоо, Эрүүл мэнд, Халдварт өвчин, Хоол тэжээлийн хэлтэс,

Bryson, J. M., Crosby, B. C., & Bryson, J. K. (2009). Understanding strategic planning and the formulation and implementation of strategic plans as a way of

knowing: The contributions of actor-network theory. *International Public Management Journal*, 12(2), 172-207.

Д., Г. (2018). Менежментийн онол, практикийн асуудлууд. Улаанбаатар.

БСШУЯ, НҮБ ХС, НҮБ ШУСБ. (2007). Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогын хэрэгжилтийн үнэлгээний тайлан. Улаанбаатар.

БСШУЯ, ЭМЯ, НХХЯ. (2005). Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого. Улаанбаатар.

Боловсролын хүрээлэн. (2018). Бага насны хүүхдийн хөгжилд эцэг эх, гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар СӨБ-ын байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нөхцөл байдлыг тодорхойлсон судалгааны тайлан. Улаанбаатар.

Bryson, J. M. (2011). *Strategic Planning for Public and Nonprofit Organizations*. San Francisco, CA: Jossey-Bass A Wiley Imprint.

Olsen, J. B., & Eadie, D. C. (1982). *The game plan: Governance with foresight*. Washington, DC: Council of State Planning Agencies.

Rushdie, S. (1981). *Midnight's children*. London: Jonathan Cape/Picador.

Taylor, A. C. (2017). *Alignment: Align your People, Strategy and Culture as you create your strategic plan*. USA: SME Strategy Consulting.

ЮНЕСКО. (2017). Боловсролд хариуцлагатай хандах нь: Бидний хариуцлагын биелэлт. Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн хариу.

НҮБ-ын Хүүхдийн Сан. (2015). Тархины хөгжил. Улаанбаатар хот.


World Health Organization (2019). *Guidelines on physical activity, sedentary behaviour and sleep for children under 5 years of age*. ISBN 978-92-4-155053-6

Ontario Centre of Excellence for Child and Youth Mental Health. (2017). *Evidence In-Sight: Key messages healthy development in early childhood*.


Unicef.org. Retrieved from [https://www.unicef.org/rwanda/media\\_9228.html](https://www.unicef.org/rwanda/media_9228.html)

UNESCO. (2006). *Changing perspectives on early childhood: theory, research and policy*. Retrieved from <https://unesdoc.unesco.org/in/document>

## ХАВСРАЛТ 1. 1999-2017 ОНЫ ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТЫН ЧИГ ХАНДЛАГА



## ХАВСРАЛТ 2. НАСАНДАА ТОХИРСОН ДАВТАМЖААР ХООЛЛОЖ БАЙГАА 5 ХҮРТЭЛ НАСНЫ ХҮҮХЭД



## ХАВСРАЛТ 3. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР (ABCDE ЗАГВАР)

..... аймаг (сум)-ын “Цогц хөгжил” багийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө

БИД ХААНА байна вэ?	БИД ХААНА хүрэхийг зорьж байна вэ?		ХЭРХЭН ХИЙх вэ?	БИДНИЙ ЯВЦ, ахиц, үр дүн ямаршуухан байна вэ?
Assessment Орчноо шинжлэх	Baseline Өнөөгийн нөхцөл байдал	Components Төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Down to Specifics Нарийвчлан төлөвлөх	Evaluate Үнэлэх
Орчноо шинжлэх	Нөхцөл байдал	Алсын хараа	Гүйцэтгэлийн шалгуур	Гүйцэтгэлийг үнэлэх
Орон нутгийн мэдээлэл	Гол асуудлууд	Эрхэм зорилго	Гүйцэтгэлийн хүрсэн байх түвшин	Ахицыг үнэлэх
Нөхцөл байдлын шинжилгээ	Нөөц боломж, хүчин чадалдаа тохируулах	Стратеги	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Зөвшрүүлэх арга хэмжээ авах
SWOT шинжилгээ	Зааг	Зорилгууд		Эргэх холбоо өгөх

